

ЭМНЕСТИ

ИНТЕРНЭШНЛИЙН

ТАЙЛАН 2022/23

**ДЭЛХИЙ ДАХИНЫ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**



**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал, эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс ангид бие даасан, хараат бус бөгөөд гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг. Хүмүүс эв санааны нэгдэлтэй, хүмүүнлэг энэрэнгүй байснаар илүү сайхан нийгмийг бий болгож, өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.

© Эмнести Интернэшнл 2023

Энэ баримт бичгийн агуулга нь Creative Commons лицензтэй болно.
(attribution, non-commercial, no derivatives, international 4.0)
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг вэб сайтаас үзнэ үү:

www.amnesty.org

Анхны хэвлэлт 2023 он

Эмнести Интернэшнл

Peter Benenson House, 1 Easton Street, London WC1X 0DW, UK

Индекс: POL 10/5670/2023

ISBN: 978-0-86210-502-0

Эх хэл: Англи

amnesty.org

amnesty.mn

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ӨМНӨХ ҮГ	5
ДЭЛХИЙ ДАХИНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ	10
Нүүн шилжигчдийн эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчил	10
Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан хийх эрх чөлөө	12
Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх	14
Нийгэм, эдийн засгийн эрх	16
Олон улсын хүний эрхийн механизм	17
АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	18
АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	28
АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	37
ЕВРОП БОЛОН ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	46
ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	56



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ASEAN –АСЕАН

Association of Southeast Asian Nations
Зүүн өмнөд Азийн орнуудын хамтын
нийгэмлэг

AU –АХ

African Union -Африкийн холбоо

CEDAW –ЭАБХУК

UN Convention on the Elimination of All
Forms of Discrimination against Women
НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх
хэлбэрийг устгах тухай конвенц

CEDAW Committee –ЭЭЯГУ Хороо

UN Committee on the Elimination of
Discrimination against Women
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг
ялгаварлан гадуурхалтыг устгах хороо

CERD –АӨАБХУОУК

International Convention on the
Elimination of All Forms of Racial
Discrimination
Арьс өнгөөр алагчлах бүх хэлбэрийг
устгах тухай олон улсын конвенц

CERD Committee –АӨАУУ хороо

UN Committee on the Elimination of
Racial Discrimination
НҮБ-ын Арьс өнгөөр алагчлах үзлийг
устгах хороо

CIA –ТТГ

US Central Intelligence Agency
АНУ-ын Тагнуулын төв газар

COP27

27th Conference of the Parties to the
UN Framework Convention on Climate
Change
НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн
Суурь конвенцод нэгдэн орсон улс
орнуудын 27 дахь удаагийн бага хурал

ECOWAS –БАУЭЗХН

Economic Community of West African
States
Баруун Африкийн улсуудын эдийн
засгийн хамтын нийгэмлэг

Escazú Agreement

Regional Agreement on Access to
Information, Public Participation and
Justice in Environmental Matters in Latin
America and the Caribbean
Латин Америк ба Карибын тэнгисийн
орнуудын хүрээлэн буй орчны
асуудлаарх мэдээллийн хүртээмж, олон
нийтийн оролцоо, шударга ёсны тухай
бүс нутгийн хэлэлцээр

EU – ЕХ

European Union -Европын холбоо

European Committee for the Prevention of Torture

**Эрүүдэн шүүхээс урьдчилан
сэргийлэх Европын хороо**
European Committee for the Prevention
of Torture and Inhuman or Degrading
Treatment or Punishment
Эрүүдэн шүүх, хүнлэг бусаар буюу нэр
төрийг доромжлон харьцах, шийтгэхээс
урьдчилан сэргийлэх Европын хороо

European Convention on Human Rights Европын Хүний эрхийн конвенц

(European) Convention for the Protection
of Human Rights and Fundamental
Freedom
Хүний эрх, үндсэн эрх чөлөөг
хамгаалах Европын конвенц

GDP –ДНБ

Gross domestic product
Дотоодын нийт бүтээгдэхүүн

ICC –ОУЭШ

International Criminal Court
Олон улсын Эрүүгийн Шүүх

ICCPR –ИУТЭОУП

International Covenant on Civil and
Political Rights
Иргэний Болон Улс Төрийн Эрхийн
Тухай Олон Улсын Пакт

ICESCR –ЭЗНСЭОУП

International Covenant on Economic,
Social and Cultural Rights
Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн
Тухай Олон Улсын Пакт

ICRC –ОУУЗХ

International Committee of the Red Cross
Олон улсын Улаан Загалмайн Хороо

ILO –ОУХБ

International Labour Organization
Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага

**International Convention against
Enforced Disappearance****Хүчээр Алга Болгохын эсрэг Олон****Улсын Конвенц**

International Convention for the
Protection of All Persons from Enforced
Disappearance

Хүчээр Алга Болгохоос Бүх Хүнийг
Хамгаалах тухай Олон Улсын Конвенц

LGBTI –ЛГБТИ

Lesbian, gay, bisexual, transgender and
intersex

Лесбиян, гей, бисексуал, трансжэндэр,
интерсекс

NATO –НАТО

North Atlantic Treaty Organization
Умард Атлантын Гэрээний Байгууллага

NDC

Nationally determined contribution
Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь
нэмэр

NGO –ТББ

Non-governmental organization
Төрийн бус байгууллага

OAS –АУБ

Organization of American States
Америкийн улсуудын байгууллага

ОСНА –ХЭЭГ

United Nations Office for the
Coordination of Humanitarian Affairs
Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Хүмүүнлэгийн Хэрэг Эрхлэх Газар

ОНСНР –ХЭДКГ

Office of the United Nations High
Commissioner for Human Rights
НҮБ-ын Хүний Эрхийн Дээд
Комиссарын Газар

OSCE –ЕАБХАБ

Organization for Security and Co-
operation in Europe
Европын Аюулгүй Байдал, Хамтын
Ажиллагааны Байгууллага

UK –ИБ

United Kingdom
Их Британи /Их Британи Умард
Ирландын Нэгдсэн Вант Улс/

UN –НҮБ

United Nations
Нэгдсэн Үндэстний Байгууллага

**UN Convention against Torture
НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг
конвенц**

Convention against Torture and Other
Cruel, Inhuman or Degrading Treatment
or Punishment

Эрүүдэн Шүүх болон бусад Хэлбэрээр
Хэрцгий, Хүнлэг бусаар буюу Хүний
Нэр Төрийг Доромжлон Харьцаж,
Шийтгэхийн Эсрэг Конвенц

UN Refugee Convention**НҮБ-ын Дүрвэгсдийн тухай конвенц**

Convention relating to the Status of
Refugees

Дүрвэгсдийн Эрх зүйн байдлын тухай
Конвенц

**UN Special Rapporteur on extrajudicial
executions****НҮБ-ын хууль бусаар цаазаар авах
ялын асуудал хариуцсан Тусгай
илтгэгч**

UN Special Rapporteur on extrajudicial,
summary or arbitrary executions
НҮБ-ын хууль бусаар, дур мэдэн,
олноор цаазаар авах асуудал
хариуцсан Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on extreme
poverty****НҮБ-ын нэн ядуурлын асуудал
хариуцсан Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on extreme
poverty and human rights
НҮБ-ын нэн ядуурал ба хүний эрхийн
асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on freedom of expression

НҮБ-ын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч

UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression

НҮБ-ын үзэл санаа, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, хамгаалах асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on racism

НҮБ-ын Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on contemporary forms of racism, racial discrimination, xenophobia and related intolerance

НҮБ-ын Ялгаварлан гадуурхах, арьс өнгөөр алагчлах, жигших, үл тэвчих орчин үеийн хэлбэрийн асуудлаарх Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on torture

НҮБ-ын эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment

НҮБ-ын эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудал Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on violence against women

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special rapporteur on violence against women, its causes and consequences

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UNHCR, the UN refugee agency

ДДКГ, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссар

Office of the United Nations High Commissioner for Refugees

НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал Эрхэлсэн Дээд Комиссарын Газар

UNICEF- ЮНИСЕФ

United Nations Children's Fund

НҮБ-ын Хүүхдийн сан

UPR -ЭДХ

UN Universal Periodic Review

НҮБ-ын Ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг

USA -АНУ

United States of America

Америкийн нэгдсэн улс

WHO -ДЭМБ

World Health Organization

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ӨМНӨХ ҮГ

Хүний эрхийн байгууллагууд сүүлийн арав гаруй жилийн турш хүний эрхийг хүндэтгэх үүрэг болон хууль дээдлэх ёс тасралтгүй алдагдаж байгааг анхааруулсаар ирсэн. 2022 онд энэ уналт аль түвшинд байна вэ? 2022 он хүний эрхийн хувьд өөр нэг гамшигт жил байв уу? Олон улсын хэм хэмжээг зөрчих байдал доод цэгтээ хүрсэн үү? Хэрэв тийм бол энэ талаар бид юу хийх вэ?

2022 оны хоёрдугаар сард Украин руу ОХУ түрэмгийлэн халдсанаар улс, ард түмний амар тайван байдал алдагдав. Хэдхэн сарын дотор иргэний дэд бүтцийг сүйрүүлж, олон мянган хүний амь үрэгдэж, түүнээс ч олон хүн гэмтэж шархаджээ. ОХУ-ын энэхүү үйлдэл нь дэлхийн эрчим хүчний хямралыг түргэтгэж, хүнсний үйлдвэрлэл, түгээлтийн тогтолцоог сулруулж, дэлхийн ядуу буурай үндэстнүүд болон арьс үндсээр ялгаварлагдсан бүлэг илүү ихээр өртсөөр байгаа дэлхийн хүнсний хомстолд хүргэв.

Түрэмгийлэл эхэлснээс хойш долоо хоноогүй байхад Олон улсын эрүүгийн шүүхийн ерөнхий прокурор Украин улсад үйлдэгдсэн дайны гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах болсныг зарласан. Гуравдугаар сарын 2-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы оролцогч улс орнуудын дийлэнх олонх нь ОХУ-ын түрэмгийллийг хүчирхийллийн үйлдэл хэмээн үзэж буруутгав. Түүнчлэн, дүрвэгсдийг хүлээн авахаас татгалзаж байсан европын улс орнууд аюулгүй байдлыг эрэлхийлсэн Украинчуудад хилээ нээжээ.

2022 оны турш шударга ёсыг шаардсан, дайны гэмт хэргийг мөрдөн шалгахыг дэмжсэн олон улсын уриалгууд маш хүчтэй өрнөлөө. НҮБ-ын Ерөнхий Ассамблей чуулганаар тогтолцооны сул байдлын үндэс болсон Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрт хориг тавих зөвлөлийн гишүүн улсын бүрэн эрхийг эсэргүүцэх тогтоолыг баталсан нь энэхүү давалгаанд улам хүч нэмэв.

Украины эсрэг ОХУ-ын хүчирхийлэл нь өргөн хүрээний сэрэмжлүүлэг болж чадсан уу? Энэ нь хүний эрх болон түгээмэл үнэт зүйлийнхээ төлөө дэлхийн хэмжээнд нэгдэх үйл хэрэг болж чадсан уу?

УЛАМ ОЛОН МӨРГӨЛДӨӨН, ИЛҮҮ ИХ ҮХЭЛ

Этиоп улс дахь дайн 2022 онд үргэлжилж, ерөнхий тооцооллоор хэдэн зуун хүний амийг хөнөөсөн нь энэ цаг үед тохиосон үхлийн хор уршиг дагуулсан мөргөлдөөний нэг байлаа. Гэвч олон хүнийг хамарсан энэхүү аллага нь Баруун Тигрей дэх Тигранчуудын эсрэг хийсэн угсаатны цэвэрлэгээний кампанит ажлын хүрээнд нүднээс далд хийгдсэн ажиллагаа юм.

2022 он Баруун эргийн Палестинчуудын хувьд сүүлийн арван жилд тохиосон хамгийн их үхэлд хүргэсэн жил боллоо. Израйлийн зэвсэгт хүчний тогтмол хийдэг цэргийн дайралт болон баривчлах ажиллагааны үеэр хамгийн багадаа 151 иргэн, түүний дотор хэдэн арван хүүхэд амь үрэгджээ. Мьянмарын арми тус улсын Карен болон Каренни иргэдийг системтэйгээр ялаж шийтгэсний улмаас хэдэн зуун хүн амь үрэгдэж, хамгийн багадаа 150,000 орчим иргэн орон гэрээсээ дайжжээ. Гайти, Мали, Венесуэл, Йемен болон бусад хэд хэдэн улсын иргэд зэвсэгт мөргөлдөөн, системт хүчирхийлэл, түүнтэй холбоотой хүний эрхийн зөрчилд нэрвэгдэв.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛ, ГАЗРЫН ТОС АШИГЛАЛТ ИХЭССЭН Ч ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ НЬ БАГА БАЙЛАА

Хязгаарлан тогтоон барих боломжгүй уур амьсгалын хямралын уршиг 2022 онд маш тодорхой илэрлээ. Үер, ган гачиг, хэт халалт, гал түймрийн улмаас олон тооны хүн амь эрсдэж, орон байр, амьжиргаанаас хагацаж, хүнсний аюулгүй байдал алдагдахад хүрэв.

Эдгээр гамшигтай нүүр тулгарсаар байгаа хэдий ч Египет улсад зохион байгуулагдсан Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх НҮБ-ын суурь конвенцын оролцогч талуудын 27 дахь удаагийн чуулганд оролцогч улс орны удирдагчид дэлхийн дулаарлыг цельсийн 1.5 хэмээс доош тогтоон барихад шаардлагатай арга хэмжээг авч чадсангүй. Улс орнууд дэлхийн дулаарлын үндсэн шалтгаан болох чулуужсан түлшний үйлдвэрлэл, ашиглалтын талаарх асуудлыг шийдвэрлэхээс татгалзав.

Дэлхийн дулаарлыг зогсооход чиглэсэн олон улсын хамтын ажиллагаа үр дүнгүй, чулуужсан түлшний хэрэглээг үе шаттайгаар зогсоох хэлэлцээр амжилт олсонгүй. Уур амьсгалын хямралд хамгийн ихээр нэрвэгдэж байгаа улс орнуудад санхүүжилт олгох асуудалд ахиц гарлаа. Алдагдал болон хохирлын санг байгуулсан нь уур амьсгалын хямралд тэргүүн эгнээнд өртөж байгаа хүмүүст зарим итгэл найдвар авчирлаа. Гэвч дээрх сан бодитоор ажиллаж эхлэхэд нэлээдгүй хугацаа шаардагдах бөгөөд чинээлэг улс орнууд 2009 оноос хойш хөгжиж байгаа улс орнуудад уур амьсгалтай холбоотойгоор жил бүр 100 тэрбум ам долларын санхүүжилт олгох амлалт хараахан хэрэгжиж эхлээгүй байна.

Үүний зэрэгцээ, барууны газрын тосны үйлдвэрлэгч зургаан том компаний татварын өмнөх орлого 200 тэрбум ам долларт хүрч дээд амжилт тогтоолоо. Энэ нь зөвхөн Украины эсрэг ОХУ-ын хүчирхийллийн улмаас эрчим хүчний үнэ өссөний үр дүн биш бөгөөд бизнесийн үйл ажиллагаа нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчинд хохирол учруулж байгааг үл тоомсорлодог, учруулсан хохиролд нөхөх олговор олгох, гэм хорыг арилгах арга хэмжээ авахдаа хойрго ханддаг чулуужсан түлшний үйлдвэрлэл эрхлэгчдийн тусгал юм.

ДАВХАР СТАНДАРТ БУЮУ ЯЛГАМЖТАЙ ХЭМ ХЭМЖЭЭ

Ковид-19 цар тахал болон Украин дахь дайн нь давхар стандартыг нэмэгдүүлсээр байна. Чинээлэг улс орнууд Ковид-19 цар тахлын эсрэг вакциныг хуримтлуулж байгаа нь олон улсын хуваарилалтын тогтолцоог сулруулж, тэгш бус байдлыг улам бүр гүнзгийрүүлсээр байна. Тайлангийн нэг жилийн хугацаанд дээрх нөхцөл байдлыг залруулах талаар өөрчлөлт бага гарлаа. Чинээлэг улс орнууд хөгжиж байгаа улс орнуудыг өөрийн өрийн дарамтаас чөлөөлөх талаарх арга хэмжээг авч чадсангүй.

ОХУ-ын Украины эсрэг түрэмгийлэл нь хүн төрөлхтний үнэт зүйлс, тэдгээрийг хамгаалахад чиглэсэн олон талт тогтолцооны эсрэг дайн юм. Ашиг сонирхол нь эрсдэлд орох учраас дайнд ялахын тулд барууны улс орнууд бусад улс оронд өрнөж буй ижил төрлийн мөргөлдөөний эсрэг үр дүнтэй арга хэмжээ авахгүй байна. Үнэндээ барууны улс орнуудын давхар стандарт нь Сауди Араб, Египет зэрэг улсад өрнөж байгаа хүний эрхийн хүчирхийллийн талаар дуугүй байх, бусад мөргөлдөөний хүний эрхийн ноцтой үр дагавар, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, өсөн нэмэгдэж байгаа дүрвэгсдийн эрхийн хамгаалалтын талаар ялгамжтай хариу үйлдэл үзүүлж байгаагаас тодорхой харагдаж байна.

Израйль улс болон эзлэгдсэн нутаг дэвсгэрт 2022 онд апартейдын тогтолцоо хүчээ авлаа. Израйлийн үе үеийн засгийн газрууд

Палестинчуудыг орон гэрээс нь зайлуулах, хууль бус суурингуудыг өргөжүүлэх, Баруун эргийн эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх одоогийн суурин зэргийг хууль ёсны болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. Барууны улс орнууд энэхүү дарангуйллын тогтолцоог эцэс болгохыг шаардахын оронд Израйлийн апартейдын тогтолцоог шүүмжлэгчид рүү дайрах аргыг сонголоо. Европын Холбоо ОХУ-ын түрэмгийллээс зугтсан Украины дүрвэгсдийг хүлээн авсан хэдий ч Афганистан, Сирийн дайн, дарангуйллаас зугтаасан дүрвэгсдийг хүлээн авсангүй. 2021 оны есдүгээр сараас эхлэн 2022 оны тавдугаар сарын хооронд АНУ 25,000 гаруй Гайти иргэдийг албадан гаргасан бөгөөд арьс өнгөөр ялгаварлан олон иргэдийг цагдан хорьж, эрүүдэн шүүж, зүй бус харьцжээ.

Эдгээр баримтууд бол барууныхны хүний эрхийн дэмжлэг нь сонголтод тулгуурласан, ашиг сонирхол бүхий болохыг дэлхийн улс орнуудад харуулж байгаа бөгөөд Украинд үзүүлэх олон улсын дэмжлэгийг сулруулж байна. Энэ мэт давхар стандарт зөвхөн барууныханд ашигтай байсангүй. Хятад улс Уйгар болон бусад мусульманчуудын эсрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон хүний эрхийн өргөн хүрээний зөрчил үйлдсэн хэрнээ НҮБ-ын Ерөнхий Ассамблей, НҮБ-ын Хүний эрхийн хорооны буруутгасан дүгнэлтийг үгүйсгэсэн хэвээр байна.

ҮНДЭСТНҮҮДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

ОХУ-ын түрэмгийллийн эсрэг дэлхийн хариу арга хэмжээ нь үнэт зүйлд тулгуурласан олон улсын тогтолцоонд шинэ үеийг харуулж, улс орнуудын дотоод дахь хүний эрхийн хамгаалалт илт дордож байгаагаас үүдэн эрх зүйт ёс суларсаар байна.

Бразил, Канад, Швед, Танзани, Вьетнам болон бусад улсад газар нутгийг нь төр хураан авсан, эсхүл төр засаг нь гуравдагч этгээд буюу бизнесийнхнээс хамгаалах үүргээ биелүүлээгүйгээс үүдэн уугуул хүмүүсийн эрх зөрчигдөж байна.

АНУ-ын Дээд шүүхээс тодорхойгүй хугацаагаар үр хөндүүлэх эрхийн баталгаагүй болгож улмаар хэдэн сая охид, эмэгтэйчүүд амьд явах, аюулгүй байх, үл ялгаварлагдах зэрэг амин чухал эрхээ эдлэх боломжгүй боллоо. Афганистан дахь Талибанчууд эмэгтэйчүүдийг эрчүүдээс хамааралтай болохыг нийтэд зарлахын зэрэгцээ охид, эмэгтэйчүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөрлөх эрхийг үгүйсгэсэн дарангуйллын хязгаарлалт тогтоолоо. Иран улсын ёс суртахууны цагдаа нар толгойн өмсгөлөө буруу зүүсний төлөө Махса Аминигийн амь насыг хөнөөсөн нь үндэсний хэмжээнд өрнөсөн томоохон эсэргүүцлийн жагсаалд хүргэсэн бөгөөд жагсаалд оролцсон олон охид, эмэгтэйчүүдийн эсрэг цагдаагийнхан хүч хэрэглэснээс хэдэн зуун охид, эмэгтэйчүүд бэртэж гэмтэн, амь насаа алдаж, цагдан хоригджээ.

2022 онд үзэл бодол, эсэргүүцлээ илэрхийлэх эрх ноцтой зөрчигдлөө. Орос улсад Украин дахь дайны талаар мэдээлснийх нь төлөө хэвлэл мэдээллийн байгууллагуудыг шүүхэд дуудан, үйл ажиллагааг нь зогсоож байна. Афганистан, Этиоп, Мьянмар, ОХУ болон дэлхийн бусад орнуудад сэтгүүлчдийг хорьж шийтгэсээр байна.

Эсэргүүцэл, шүүмжлэлийг дуугүй байлгах, олныг хамарсан жагсаал, цуглаанаас сэргийлэх, худал мэдээлэл тараах зорилгоор технологийг ашиглаж байна. Тайван жагсагчдын эсрэг бороохойноос эхлээд нулимс асгаруулагч хий, резинэн сум, галт зэвсэг гэх зэрэг өсөн нэмэгдсээр байгаа зэвсгийн нөөцийг хэрэглэж байгааг Иран, Перу, Шри-Ланка зэрэг улсаас харж болно. Англи улсад тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлаж цагдаагийн эрх мэдлийг хуулиар өргөжүүллээ.

Бид эсэргүүцлийн онцгой үйл явдлын гэрч боллоо. Афганистан эмэгтэйчүүд Талибанчуудын засаглалыг эсэргүүцэн гудамж, талбайд жагссан бол Ираны эмэгтэйчүүд нүүрээ халхлахыг шаардсан хууль тогтоомжийг эсэргүүцэн өөрсдийн үсийг тайрч байгаа бичлэгээ нийтлэлээ. Дарангуйллыг эсэргүүцэн хэдэн мянган хүн цугларч хүний эрхийн захидал бичиж, гомдолд гарын үсгээ зурж, гудамж талбайд жагсаж байгааг олж мэдэхэд бидэнд таатай байна. Өөрчлөлтийг шаардан, чөлөөтэй, хамтдаа нэгдэх бидний эрхийг хасаж болохгүй гэдгийг эрх баригчдад сануулах ёстой.

ЭЦЭСТ НЬ ХЭЛЭХЭД

2022 он олон улсын дэг журамд эргэлт гарсан жил байлаа. Жилийн өмнө буюу эмх замбараагүй байдал өрнөсөн 2021 онд Афганистанаас АНУ цэргээ татсаны дараа АНУ болон барууны хүчний хамтын ажиллагаа Атлантын эвсэлд шинэчлэл авчирлаа.

Гэвч хүний эрхийн фронтод эргэлт гарсангүй, харин ч уналт зогсолтгүй үргэлжилсээр байна. Олон арван жилийн хугацаанд хүчирхэг улс гүрнүүд олон улсын хуульд тогтоомжийг үл тоомсорлож, түүнд хариуцлага хүлээхгүй байсаар нэгэнт суларсан олон улсын олон талт тогтолцоог ОХУ-ын түрэмгийлэл улам бүр тогтворгүй болгов. Уур амьсгалын хямрал, удаан хугацаанд үргэлжилсэн бусад зэвсэгт мөргөлдөөн, дэлхийн өнцөг булан бүрд нүүрлэсэн хүний эрхийн асуудалд хандуулах анхаарал дайны хөлд сарниж, нөөцийн зориулалтыг өөрчлөхөд хүргэв.

ОХУ-ын Украин дахь түрэмгийлэлд үзүүлэх барууны орнуудын хариу арга хэмжээ нь НҮБ-ын дүрмийг зөрчсөн бусад олон үйлдэлд хариу үзүүлдэггүй, давхар стандарт хэрэгжүүлдэг болохыг харуулав.

Хэрэв ОХУ-ын түрэмгийлэл дэлхийн ирээдүйд дэг журамд өөрчлөлт оруулна гэж үзвэл үр дүнтэй, тууштай хэрэгждэг хэм хэмжээнд үндэслэсэн олон улсын дэг журам чухал болох нь харагдаж байна. Украйныг дэмжигч эвслийг тэргүүлэгч улс орнууд дэлхийн дийлэнх хүн амд ашиг тустай олон улсын тогтолцоог шинэчлэхэд хүчин чармайлт, хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх шаардлагатай.

Дэлхийн дайны үнс нурмаас бий болсон баримт бичиг болох Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдсаны 75 жилийн ой 2023 онд тохионо. Олон сая хүний амь насыг золиослон бий болсон эрх чөлөө, зарчмуудыг дахин амь золин шатаахыг хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй. 2023 он хүний эрхийг хамгаалахад эргэлт хийх жил байх ёстой. Дэлхийн удирдагчид энэхүү үйл хэргээс хойш суух нь хүн төрөлхтнийг ангал руу унагах урвалт байх болно.

Ерөнхий нарийн бичгийн дарга Агнес Калламард

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЭМНЕСТИ

ИНТЕРНЭШНЛИЙН

ТАЙЛАН 2022/23

**ДЭЛХИЙ ДАХИНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ,
БҮС НУТГИЙН ТОЙМ**



ДЭЛХИЙ ДАХИНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Урьд өмнөх болон шинээр үүссэн мөргөлдөөн ужгиран сунжирч байгааг 2022 онд харлаа. Зөрчилдөөн бүхий газар нутгуудад олон улсын хүмүүнлэгийн эрх зүй зөрчигдөн, хүн төрөлхтөн эмгэнэлт байдалд хүрлээ. Зөрчилдөөний хүний эрхэд учруулж буй нөлөө, үүнээс дайжсан хүмүүсийг хамгаалах, түүнчлэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдохуйц ноцтой зөрчлүүдэд үзүүлэх олон улсын хариу арга хэмжээ ихээхэн зөрүүтэй, ялгамжтай байна. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө, тэр дундаа эсэргүүцлийн жагсаал хийх эрхийг хатуу гараар нухчин дарж байна. Хүний эрхийг хамгаалж байгаа хүмүүс энэхүү дарамт шахалтынх нь үр дагаврыг илүүтэй амсаж байна.

Хуулийн хамгаалалтыг сайжруулах талаар зарим арга хэмжээ авсан хэдий ч охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл дэлхий нийтийн тулгамдсан асуудал хэвээр байгаа бөгөөд үр хөндөлтийн эрхийн талаар зарим нэгэн ахиц дэвшил, мөн ухралт ч гарчээ. Хэдийгээр олон улс Ковид-19-ийн сүүдрээс гарч эхэлсэн хэдий ч зарим нь салж чадаагүй хэвээр байна. Цар тахлаас улбаатай эдийн засгийн хямрал, өрийн тогтворгүй байдал, сөргөлдөөн болон уур амьсгалын өөрчлөлт зэрэг нь амьжиргааны өртгийн өсөлт, хүнсний аюулгүй байдлын асуудлыг огцом нэмэгдүүллээ. Энэхүү сорилт нь нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст илүүтэй нөлөөлж, тэгш бус байдлыг гааруулж байна.

Эдгээр нь Эмнести Интернэшнлээс 2022 онд дэлхийн 156 оронд хийсэн судалгаагаар хамгийн чухлаар хөндөгдсөн асуудлууд бөгөөд өөр хоорондоо нягт холбоотой юм. Эсэргүүцлийг нухчин дарсан нь зөрчилдөөнийг улам бүр даамжрууллаа. 2021 онд болсон зэвсэгт мөргөлдөөн, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах үйл ажиллагаа нь иргэний нийгмийг нухчин дарах нөхцөлийг бүрдүүллээ. Охид, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь зэвсэгт мөргөлдөөний харгис байдлыг илтгэж байна. Дайн, улс төрийн хямрал, амьжиргааны үнийн өсөлт, үр хөндөх эрхийн хязгаарлалт, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт зэрэг нь эсэргүүцлийн хөдөлгөөний үндсэн шалтгаан юм. Эдгээр хүний эрхийн зөрчлийн зарим хүрээнд хийсэн Эмнести Интернэшнлийн судалгаа мэдээллийн технологийн салбарт дэлхийг тэргүүлэгч компаниудын бизнесийн загвараас үүдэлтэй ноцтой хор хөнөөлийг илчилж, уур амьсгалын хямрал, байгаль орчны доройтлыг даван туулах илүү зоримог арга хэмжээ авах шаардлагатайг онцолж байна.

НҮҮН ШИЛЖИГЧДИЙН ЭРХ, ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Дэлхий дахинд шинээр болон өмнө нь үүссэн мөргөлдөөн удаан хугацаанд үргэлжилсэн хэвээр байна. Засгийн газрын зэвсэгт хүчин, зэвсэгт бүлэглэлүүд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй болон хүний эрхийг зөрчсөний зэрэгцээ дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдол гарлаа.

Европт, Оросын зэвсэгт хүчин Украйнд түрэмгийлэн халдаж, шүүхээс гадуур цаазаар авах ял гүйцэтгэж, энгийн иргэдийг ялгахгүйгээр халдлага үйлдсэний зэрэгцээ өвлийн улиралд тус улсын эрчим хүчний дэд бүтэц рүү дайралт хийлээ. Африкт Этиоп, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Сахел бүс нутгийн засгийн газрын зэвсэгт хүчин болон зэвсэгт бүлэглэлүүдийн тулалдааны улмаас олон мянган энгийн иргэд үй олноороо амь үрэгдлээ. Ойрх Дорнод болон Хойд Африкийн Ливи, Сири, Йемен зэрэг улсад удаан үргэлжилсэн мөргөлдөөн, мөн 8 дугаар сард Израйль болон Палестины зэвсэгт бүлэглэлийн мөргөлдөөний хурцадмал байдлын

үеэр энгийн иргэдийг ялгахгүйгээр үйлдсэн агаарын довтолгоо болон бусад хууль бус халдлагын улмаас энгийн иргэд амь үрэгдэж, шархаджээ. Афганистанд Талибанчууд хуучин засаг захиргаа болон аюулгүйн албаныхны эсрэг аллага үйлдэх кампанит ажлаа үргэлжлүүлж, дайны гэмт хэрэг үйлджээ.

Бэлгийн хүчирхийлэл нь мөргөлдөөн бүхий бүс нутгуудад тасралтгүй үйлдэгдсээр байгаа бөгөөд дайны зэвсэг болгон хэрэглэж байна. Төв Африкийн Бүгд Найрамдах Улс болон Өмнөд Суданд засгийн газрын хүчнийхэн болон зэвсэгт бүлэглэлийн хоорондын мөргөлдөөн, эсхүл зэвсэгт бүлэглэлийн дайралтаас үүдэн олон арван оксид, эмэгтэйчүүд хүчиндүүлсэн тохиолдол бүртгэгджээ. Этиоп улсад Тиграины цэргийн хүчнийхэн мөргөлдөөнтэй холбоотой хүчингийн болон бусад бэлгийн хүчирхийллийн олон хэрэг үйлджээ. Украинд ОХУ-ын цэргийн хүчнийхэн бэлгийн хүчирхийлэл үйлдсэн талаар мэдээлэл бүртгэгджээ. Оросын цэргүүд эмнэлгийн байгууллагууд руу халдсан нь төрөх эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг үгүй болгож, улмаар эмэгтэйчүүд жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн гишүүн орнуудын дийлэнх нь ОХУ-ын Украины эсрэг түрэмгийллийг буруутгасан бөгөөд энэхүү түрэмгийллийн дараа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл мөрдөн шалгах комисс байгуулахаар шуурхай ажилласан нь нааштай алхам юм. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл олон арван зөрчилдөөнийг зохицуулж чадахгүй байгаагаас үүдэн НҮБ-ын Ерөнхий Ассамблей Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн хоригийг ашиглан улс төрийн зардлын асуудлыг хөндөн тавилаа. Аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн улс хориг тавьсан тохиолдолд Ерөнхий Ассамблей автоматаар хуралддаг байх тухай тогтоолыг дөрөвдүгээр сард баталлаа.¹ Украины хэсэгчлэн эзлэгдсэн дөрвөн бүс нутгийг өөртөө нэгтгэх талаарх ОХУ-ын шийдвэрийг хүчингүй болгохыг шаардсан Аюулгүйн зөвлөлийн есдүгээр сард гаргасан тогтоолд ОХУ хориг тавьсны дараа НҮБ-ын Ерөнхий ассамблей хуралдсан юм. Ерөнхий ассамблей ОХУ-ын дээрх үйлдлийг хүчин төгөлдөр бус, хууль бус хэмээн үзэж буруутгав. Гэвч ОХУ-ын өөртөө тохируулсан энэхүү үйлдэл нь сөргөлдөөнт нөхцөлд хүчирхийлэлд хүргэх цорын ганц сонголтод хувилбар биш байв.

Украин дахь дайны гэмт хэргийг мөрдөн шалгах Олон улсын эрүүгийн шүүхийн (ОУЭШ) хүчин чармайлтыг барууны орнууд хүчтэй дэмжсэн бол зарим улс бусад олон нөхцөл байдлаас үүдэн тодорхой хариу үйлдэл үзүүлсэнгүй. Их Британи ОУЭШ-д нэмэлт дэмжлэг үзүүлсэн бол АНУ нь Ромын дүрмийг өөрөө соёрхон батлаагүй хэдий ч улс төрийн дэмжлэг үзүүлжээ. Харин Израйль зэрэг холбоотнууд Афганистан, Ирак дахь өөрийн иргэдтэй холбоотой мөрдөн байцаалтыг эсэргүүцжээ. 20 жилийн ойгоо тэмдэглэж буй ОУЭШ-ийн үйл ажиллагаа нь нөхцөл байдал, бүс нутгаас үл хамааран олон улсын эрх зүйн дагуу гэмт хэргийн хохирогчдод ижил зарчмууд үйлчлэх үү гэсэн асуултыг хөндөж байна. ОУЭШ Украины нөхцөл байдлын талаарх өргөн хүрээний мөрдөн шалгах ажиллагааг олон нийтэд сурталчилж байгаа хэдий ч Нигери, Палестин зэрэг улсын нөхцөл байдлыг мөрдөн шалгах ажиллагаанд хамаагүй бага нөөц зарцуулжээ.² Ялгамжтай хандаж байгаагийн өөр нэг жишээ бол НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Украинд гарсан зөрчлийг буруушаасан ч Йемен дэх мөргөлдөөнийг орхигдуулж байгаа нь хариуцлагын асар том зөрүү байгааг илтгэж байна.

Хүний эрх хамгаалагчид, байгууллагууд, түүнчлэн засгийн газар тодорхой арга хэмжээ авч байгаа хэдий ч бизнесийн оролцогчид зөрчилдөөнтэй нөхцөл байдлын үед хүний эрхийн зөрчлийг дэмжсээр байна. Эмнести Интернэшнл Мьянмарын зэвсэгт хүчинд энгийн иргэдийн эсрэг агаараас цохилт хийхэд ашиглаж болох нисэх онгоцны түлшийг импортлож, түгээж байгаа бизнес эрхлэгчдийн үйлдлийг баримтжуулан илчилсэн. Үүний дараа холбогдох зарим компаниуд Мьянмар дахь бизнесийн үйл ажиллагаагаа орхиж, түр зогсоож байгаагаа зарлав. Эмнести Интернэшнл мөн Фэйсбүүк, Инстаграмын өмчлөгч болох Метегийн алгоритм болон бизнес нь 2017 онд Мьянмарын зэвсэгт хүчин Рохинжачуудын эсрэг ажиллагаа явуулж хүний эрхийг ноцтой зөрчихөд нилээдгүй хувь нэмэр оруулсан болохыг тогтоосон.

Зэвсэгт мөргөлдөөн нь дүрвэгсэд болон дотоодын шилжилт хөдөлгөөний томоохон давалгааг бий болголоо. Оросын түрэмгийллээс зугтсан Украины дүрвэгсэд чиглэсэн Европын Холбооны нээлттэй хаалганы бодлого дэлхийн чинээлэг бүс нутаг болохын хувьд хамгаалалт хайж буй олон тооны хүмүүсийг хүлээн авч, эрүүл мэнд, боловсрол, орон сууц гэх мэт үндсэн үйлчилгээнд хамруулах боломжтой болохоо харууллаа. Гэвч дээрх хандлага нь өөр бүс нутгаас хамгаалалт хайж буй хүмүүст ханддагаас эрс ялгаатай байгаа нь арьс өнгөөр алагчлах, ялгаварлах үзэл хүчтэй байгааг илтгэж байна. Эдгээр дүрвэгсэд, цагаачдыг Ливи гэх зэрэг дамжигч улс орнууд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүчирхийлж байгааг үл харгалзан урьдчилсан нөхцөлийг шалгахгүйгээр хил дээрээс хуурай газраар болон далайгаар албадан гаргаж, зарим тохиолдолд хүч хэрэглэн буцааж нилээдгүй дүрвэгсдийг үхэлд хүргэсэн байна.

Ойрх Дорнод болон Хойд Африкт дүрвэгсдийн хамгаалал суларлаа. Ливаны эрх баригчид “сайн дурын” үндсэн дээр нутаг буцааж байгаа хэмээн Сиричүүдийг албадан гаргах ажиллагаагаа нэмэгдүүллээ. Америк тивд олон улсын хүчирхэг хамгаалалтын тогтолцоо дулимаг байгаа нь зэвсэгт хүчирхийлэл болон бусад хямралын нөхцөл байдлаас зугтаж, тоо нь өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа дүрвэгсдийг хамгаалалтгүй үлдээж байна. 2021 оны 9 дүгээр сараас 2022 оны 5 дугаар сарын хооронд АНУ 25,000 гаруй Гайтичуудыг албадан гаргасан бөгөөд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлээс үүдэн хар арьстнуудыг эрүүдэн шүүж, зүй бус байдлаар харьцжээ.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэж, хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгаж, гэмт хэрэгтнүүдэд ял шийтгэл хүлээлгэх ёстой. Бусад бүх засгийн газрууд тэднийг дээрх үүргээ биелүүлэхэд тууштай шахалт үзүүлж, мөргөлдөөнийг шийдвэрлэх, энх тайвныг тогтооход эмэгтэйчүүдийн бүрэн, эрх тэгш оролцоог хангах, охид, эмэгтэйчүүдийг мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийллээс хамгаалах тусгай арга хэмжээ авахыг шаардсан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 тоот тогтоолын хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах ёстой. ОУЭШ нь мөрдөн шалгах үйл ажиллагааны санхүүжилтийг ялгаварлалгүйгээр хуваарилах ёстой. Засгийн газрууд хавчлага дарамтаас зугтаж буй бүх хүний аюулгүй байдлыг хангаж, олон улсын хамгаалалтад авах боломжийг баталгаажуулж, хамгаалалт хайж буй хүмүүст хандах давхар стандартыг эцэс болгох ёстой.

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Эсэргүүцэл, шүүмжлэл, иргэний нийгмийг нухчин дарах үзэгдэл дэлхийн хүний эрхийн гол хандлагын нэг хэвээр байна.

Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нухчин дарах зарим үйл ажиллагаа зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой байв. ОХУ шинээр хууль батлах замаар Украины дайны талаар шүүмжлэхийг хатуу хориглов. Мянга мянган хүнд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэж, олон арван хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаажээ. Этиоп улсын эрх баригчид хэвлэл мэдээллийн ажилтнуудыг дур зоргоороо баривчилж, энх тайвныг уриалсан иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд саад хийв.

Засгийн эрх мэдлийг цэргийн хүчээр авсны дараа хүний эрхийг нухчин дарлаа. Афганистан дахь Талибаны эрх баригчид 2021 онд тус улсыг эзлэн авсныхаа дараа шүүмжилснийх нь төлөө сэтгүүлчдийг дур зоргоороо баривчилж, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцав. 2021 онд Мьянмарын засгийн эрх мэдлийг цэргийн хүчээр авсан эрх баригчид олон арван хэвлэл мэдээллийн ажилтнуудыг баривчилж, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглож, төрийн бус байгууллагуудын хууль ёсны үйл ажиллагаанд хязгаарлалт тавьж, зөрчил гаргасан тохиолдолд хорих ял оноож байв. 2020, 2021 онуудад Мали улсын засгийн эрх мэдлийг цэргийн хүчээр

хууль бусаар олж авсан эрх баригчид үндэсний болон гадаадын телевизийн үйл ажиллагааг зогсоож, засгийн газар, цэргийн хүчнийг шүүмжилсэн сэтгүүлчид болон бусад хүнийг баривчилж, заналхийлжээ.

Нөлөө бүхий улс орнууд өөрийн улс дахь хүний эрхийн нөхцөл байдлыг дотоод болон гадаадад хэлэлцэхээс сэргийлэх зорилгоор иргэний нийгэмд шахалт үзүүлж байна. Олон мянган эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг дур зоргоор цагдан хорьж байгаа гэх Шинжаанд Уйгур болон бусад мусульман үндэстний цөөнхийн эсрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүйг баримтжуулсан НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын удаан хугацаанд боловсруулсан тайланг Хятадын засгийн газар үгүйсгэлээ. Энэтхэгийн засгийн газар хүний эрхийг хамгаалагчдыг олон улсад зорчихыг хориглов.

Турк улсын эрх баригчид олон арван сэтгүүлч, хүний эрх хамгаалагч, сөрөг хүчний улстөрчдийг терроризмтой холбоотой хилс хэргээр цагдан хорьж, ялсаар байгаа бөгөөд тус улсын хууль тогтоох байгууллагаас олон нийтийн сүлжээнд засгийн газрын эрх мэдлийг өргөжүүлсэн худал мэдээллийн тухай хуулийг шинээр баталлаа. Египетийн засгийн газар өнгөрсөн арван нэгдүгээр сард НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын (COP27) Талуудын 27 дугаар бага хурлыг зохион байгуулахын өмнө өөрийн улсын хүний эрхийн нөхцөл байдлыг сайнаар харагдуулахын тулд улс төрийн шалтгаанаар хоригдож байсан хэдэн зуун хүнийг хэсэгчлэн сулласан. Гэвч тус улсын эрх баригчид бодит бий болсон болон тохиож болох эсэргүүцлийг нухчин дарахын тулд мөн хугацаанд гурав дахин их хүнийг дур мэдэн саатуулсны дотор COP27-ийн үеэр жагсаал цуглаан зохион байгуулахыг уриалсан хэргээр баривчлагдсан олон зуун хүн байжээ.

Египет дэх үйл явдал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон уур амьсгалын шударга ёс, байгаль орчны доройтлын хоорондын уялдаа холбоог илэрхийлж байна. Дэлхийн өнцөг булан бүрд байгаль орчныг хамгаалсныхаа төлөө тэмцэгчид халдлага, заналхийлэлд өртөж, амь насаа алдсаар байна. Латин Америк дахь тус асуудал хамгийн их анхаарал татаж байна. Global Witness байгууллагын 2022 оны тайланд бичсэнээр 2021 онд бүртгэгдсэн байгаль орчныг хамгаалагчид болон газрын төлөө тэмцэгчдийн амь насыг хөнөөсөн нийт хэргийн дөрөвний гурав нь дээрх бус нутагт үйлдэгджээ.

Дэлхий даяар хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны алдаа дутагдал болон дайн, улс төрийн хямрал, амьжиргааны өртгийн өсөлт, үр хөндөлтийн эрхийн хязгаарлалт, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах зэрэг санаа зовоосон олон асуудлуудаар эвлэлдэн нэгдэж жагсаж байна. Эсэргүүцлийг хүч хэрэглэн дарахын тулд улс орнууд ихэвчлэн хууль бус хүч, тэр дундаа хүний амь насанд аюултай хүч хэрэглэж байна. Иран улс үүнийг тодорхой харуулсан. Есдүгээр сараас эхлэн тус улсын эрх баригчид олон арван жилийн турш үргэлжилсэн жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хатуу хэлмэгдүүлэлтийн эсрэг сөрөн зогссон урьд өмнө болж байгаагүй том хэмжээний бослогыг дарахын тулд иргэдийг зодож, галт зэвсэг хэрэглэн, олон зуун хүний амь насыг хөнөөсний дотор олон арван хүүхэд багтжээ. Мөн Перу улсад өнгөрсөн арван хоёрдугаар сард ерөнхийлөгчөө огцруулсны дараах улс төрийн хямралын үеэр зохион байгуулагдсан эсэргүүцлийн жагсаалд оролцогчдыг эсрэг аюулгүй байдлын хүчнийхэн хууль бус хүч хэрэглэсний улмаас 20 гаруй хүн амь үрэгджээ.

Дэлхий даяар аюулгүйн албаныхан эсэргүүцлийн жагсаалын үеэр галт зэвсэг, бороохой, нулимс асгаруулагч хий, резинэн сум зэрэг хүний амь насанд аюултай олон төрлийн зэвсэг ашиглажээ. Зарим аюулгүйн албаныхан жагсагчдыг дур зоргоороо цагдан хорьж, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцсаны зэрэгцээ хөлийн гинж гэх зэрэг хүчирхийллийн хэрэгсэл ашиглажээ. Хууль сахиулах үйл ажиллагаанд хүчирхийллийн хэрэгсэл ашиглах явдал огцом нэмэгдсэн нь эдгээр хэрэгслийн импорт, экспортод тавих дэлхийн хүний эрхийн хяналт хангалтгүй байгаатай холбоотой. Гэхдээ тавдугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хүсэлтийн

дагуу Засгийн газрын шинжээчдийн бүлэг энэ төрлийн худалдааг зохицуулах эрх зүйн арга хэрэгслийн хувилбарыг дэвшүүлсэн илтгэл боловсруулжээ. 60 гаруй улсаас бүрдсэн дэлхийн эвслийг Европын холбоо, Аргентин, Монгол улс тэргүүлж, зохих хэлэлцээрийг дэмжлээ. Хүний эрхийн байгууллагууд Эрүүдэн шүүхээс ангид худалдааны хэлэлцээрт оруулах гол агуулгын талаарх саналыг боловсруулав.³

Улс орнууд эсэргүүцлийн жагсаалыг бусад арга хэрэгслээр дарсаар байна. Австрали, Энэтхэг, Индонез, Их Британи зэрэг улсад эрх баригчид жагсаал цуглааныг хязгаарласан шинэ хууль баталжээ.

Төрийн бодлогыг эсэргүүцэхээс сэргийлэхийн тулд Шри Ланкад онц байдал зарлах, Хятадад Ковид-19 цар тахал, 2021 онд засгийн эрх мэдлийг хууль бусаар авсан Гвинейд сонгуулийн аюулгүй байдлыг хангах нэрийдлээр зүй бус арга хэрэглэжээ. Засгийн газрууд мөн эсэргүүцэгчдийг зогсоохын тулд иргэний цахим орон зайг хязгаарлажээ. Иран, Мьянмар зэрэг улс интернэт болон харилцаа холбоог хааж, тасалдуулжээ.

Хүний эрхийн дээрх ноцтой зөрчил болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөний зөрчлийн талаарх олон улсын хариу арга хэмжээ нь зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдлын талаарх НҮБ болон Олон улсын эрүүгийн шүүхийн хариу үйлдэлтэй адил зөрүүтэй, ялгамжтай байв. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Орос дахь хүний эрхийн байдлын асуудлаар тусгай илтгэгчийг шинээр бий болгосны зэрэгцээ Иранд болсон эсэргүүцлийн жагсаалыг дарангуйлсны дараа мөрдөн шалгах механизмыг байгуулсан. Харин БНХАУ-ын Шинжаанд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэгдэж байж болзошгүй нотолсон НҮБ-ын өөрийн нотолгоог цаашид үргэлжлүүлэн судлахгүй, бүр хэлэлцэхгүй байхаар шийдвэрлэсний зэрэгцээ Филиппинтэй холбоотой тогтоолын хэрэгжилтийг зогсоосон юм. Түүнчлэн Израйль улс Палестинчуудын эсрэг апартейдийн тогтолцоог бий болгосон гэсэн Эмнести Интернэшнлийн дүгнэлтийг НҮБ-ын шинжээчид дэмжсэн ч үүнийг үл харгалзан Израйлийн холбоотнууд эрс үзүүлжээсэн юм. Израйль улсын апартейдын тогтолцооны талаарх хүний эрхийн байгууллагуудын дүгнэлт нэмэгдсээр байна. Түүнчлэн НҮБ-ын гурван «тулгуур»-ын нэг болох олон улсын хүний эрхийн тогтолцоо нь тогтмол санхүүжилтгүй байсаар байгаа бөгөөд зарим улс шаардлагатай механизмуудыг гацаах зорилгоор төсвийг сулруулахаар эрмэлзэж байв.

Засгийн газрууд эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарахын тулд шалтаг ашиглах, хүний эрхийн тайланг нь хэлэлцэхэд саад учруулахгүй байх ёстой. Засгийн газрууд хүний эрх хамгаалагчдын амь насыг хөнөөсөн, дарамт шахалт үзүүлсэн, хүчирхийлсэн үйлдлийг мөрдөн шалгахын зэрэгцээ аюулгүйн албаныхан шаардлагагүй үед жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэх явдлыг эцэс болгож, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн хууль тогтоомжийг өөрчилж, хүчингүй болгох шаардлагатай. Олон талт харилцааны түвшинд Засгийн газрууд худалдааны хяналтын шинэ хэлэлцээрийг бий болгох талаарх хэлцлийг дэмжих шаардлагатай. Түүнчлэн засгийн газрууд нь хүний эрхийн ноцтой зөрчлийн бүх хэлбэрт хамаарах хариуцлагын механизмыг тогтмол бий болгох шаардлагатай.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ, БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Охид, эмэгтэйчүүд болон ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл дэлхийн хэмжээний хүний эрхийн асуудал хэвээр байна. Өмнө дурдсанчлан зэвсэгт мөргөлдөөний үеэр энэ төрлийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа ч энх тайван цагт үйлдэгдэх дотоодын хүчирхийлэл зонхилох хувийг эзэлж байна.

Америкийн бүс нутгийн тухайд ял шийтгэл хүлээлгэдэггүйгээс үүдсэн жендэрт суурилсан аллага Мексикт хэдэн зуугаар бүртгэгджээ. Венесуэлийн дүрвэгч эмэгтэйчүүд Колумби, Эквадор, Перу болон Тринидад Тобаго зэрэг улсад жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртөв. Өмнөх жилүүдэд Канадад

уугуул эмэгтэйчүүдийг хүч хэрэглэн үр тогтоох чадваргүй болгох тохиолдол бүртгэгдэж байсан бол АНУ дахь уугуул эмэгтэйчүүд хүчин болон бэлгийн хүчирхийлэлд өртөх хувь хэмжээ нэмэгдсэн хэвээр байна. Цахим болон цахим бус орчин дахь хүчирхийллийн түвшин дэлхийн улс орнуудад өндөр хэвээр байна. Пакистан улсад гэр бүлийн орчинд үйлдэгдэх олныг түгшээсэн эмэгтэйчүүдийн эсрэг аллага бүртгэгдсээр байгаа ч 2021 оноос хойш хэлэлцэж байгаа гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийг хууль тогтоох байгууллагаас батлаагүй хэвээр байна. Энэтхэг улсад Далит болон Адиваси эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, кастад суурилсан үзэн ядах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд ял шийтгэлгүй үлдэж байна.

Зарим улсын засгийн газар эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагчдын шахалтын үр дүнд эрх зүйн хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авчээ. Европын бүс нутгийн улс болох Бельги, Финланд, Испанид зөвшилцлийн зарчмыг бэхжүүлсэн хүчингийн гэмт хэргийн шинэ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэллээ. Ази, Африкийн улсууд болох Хятад, Конго, Индонез, Папуа Шинэ Гвиней, Зимбабве зэрэг орнуудад охид, эмэгтэйчүүдийг бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах хамгаалалтыг бэхжүүлэхэд чиглэсэн шинэ хууль тогтоомжийг баталжээ. Гэвч эдгээр болон дэлхийн бусад улсын эрх баригчид охид, эмэгтэйчүүдийг нийгэмд ужирсан жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах, гэм буруутай этгээдэд зохих ял шийтгэл хүлээлгэх асуудалд төдийлөн амжилт гаргахгүй байна. Ойрх Дорнод болон Хойд Африк, Египет, Ирак, Иемен, Саудын Араб зэрэг улсын эрх баригчид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагч, идэвхтнүүдийг бэлгийн хүчирхийллийн эсрэг үг хэлснийг нь төлөө шийтгэх болон бусад төрлийн дарамт шахалт үзүүлжээ.

Энэ бүхний улмаас нийгмийн ялгаварлан гадуурхсан хандлага, охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ бүлгийн эсрэг ялгаварлан гадуурхалт хууль болон практикт өргөжин тэлсээр байна. Афганистанд охид, эмэгтэйчүүдийн эрх үгүйсгэгдсээр байна. Талибуудын шинэ шийдвэрээр охид, эмэгтэйчүүдийг эрэгтэй харгалзагчгүйгээр зорчих, олон нийтийн цэцэрлэгт хүрээлэнд явах, цаашлаад ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуульд суралцах, ТББ-д ажиллахыг хориглов.

Үр хөндөх эрхийн тухайд амжилт, ухралт аль аль нь ажиглагдлаа. Зургадугаар сард АНУ-ын дээд шүүхээс үр хөндөх эрхийн холбооны хамгаалалтыг хүчингүй болгосны дараа үр хөндөх эрхийг хамгаалах талаарх олон нийтийн саналыг үл харгалзан тус улсын хэд хэдэн муж улсад үр хөндөлт, түүний хүртээмжийг хориглон хязгаарласан хуулийг баталжээ. Америкийн бүс нутгийн нийт таван улсад үр хөндөлтийг эрүүгийн гэмт хэрэгт тооцсон хэвээр байгаа боловч Колумбын Үндсэн хуулийн шүүхээс жирэмсний 24 дэх долоо хоног хүртэл үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэхгүй байхаар шийдвэрлэсэн бол Эквадор улс хүчингийн гэмт хэргийн улмаас жирэмсэлсэн тохиолдолд үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх шинэ хууль баталжээ.

Үүнтэй төстэй хандлага Европын бүсэд ажиглагдлаа. Унгар, Польш, Словак улсад үр хөндөлтийн хүртээмжийг хязгаарлах шинэ арга хэмжээг хэрэгжүүлсэн бол Герман, Нидерланд зэрэг хэд хэдэн улс үр хөндөлттэй холбоотой зарим хязгаарлалтыг цуцалжээ. Андорра, Польш зэрэг улсад үр хөндөлтийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалагчид хавчлагад өртжээ.

Засгийн газар охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг нийгэмд өргөн тархсан жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, амьд үлдсэн хүмүүсийг хамгаалах, дэмжих, холбогдох гэмт хэрэгт ял шийтгэлгүй үлдэх асуудлыг шийдвэрлэх цогц арга хэмжээ авах ёстой. Үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцож байгаа бүх улс аливаа ялгаварлан гадуурхалт, хүч албадлага хэрэглэхгүйгээр үр хөндөлттэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ, үр хөндөлтийн дараах тусламж үйлчилгээ авах, нөхөн үржихүйн бие даасан байдал болон бусад хүний эрхийг хүндэтгэх баталгааг хангахын тулд үр хөндөлтийн талаарх хууль тогтоомжоо шинэчлэх шаардлагатай.

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ

Бүх бүс нутагт Ковид-19 тахлын үр дагавраас үүдсэн эдийн засгийн хямрал, өрийн тогтворгүй байдал, мөргөлдөөн, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн амьжиргааны өртгийн өсөлт, хүнсний аюулгүй байдлын асуудал асар хурдацтай өсөж байна. Олон улсын валютын сан аравдугаар сард бага орлоготой улс орнуудын 60 гаруй хувь, хөгжиж байгаа эдийн засгийн 25 гаруй хувь нь өр төлбөрөө барагдуулах боломжгүй байгааг онцолсон. ОХУ Украин руу довтолсон нь импортын хараат улс орнуудын улаан буудайн нийлүүлэлтийг тасалдуулаад зогсохгүй шатахууны үнийн огцом өсөлтөд нөлөөлсөн. Хоол хүнс, цэвэр ус, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, орон байртай холбоотой эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа үндсэн шалтгаан болон нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйл ажиллагаанд зарцуулах төсвийн хомсдол зэрэг бүтцийн шинжтэй тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадаагүйгээс сорилт бэрхшээл улам хурцдаж байна. Үүний үр дагаврыг нийт бүс нутгийн нийгмийн эмзэг бүлгийнхэн илүүтэй амсаж байна.

Африкийн холбоо 2022 оныг «Хоол тэжээлийн жил» болгон зарласан хэдий ч цаг агаарын эрс тэс нөхцөл байдлын улмаас тус бүс нутгийн хэд хэдэн улс орон хоол тэжээлийн дутагдалд оров. Сомалид нүүрлэсэн хүчтэй ган гачгаас үүдэн хоол тэжээлийн дутагдалд орсон тохиолдол ихэссэн бол Нигерт үерийн улмаас усаар дамждаг өвчний дэгдэлт болж, олон зуун хүн амь үрэгджээ. 2020 онд Афганистаны нийт хүн амын 47 хувь ядууралд өртсөн байсан бол эдийн засгийн хямралын улмаас энэ тоо 97 хувь хүртэл өсжээ. Шри Ланкад хүмүүс хоол хүнс, түлш, эм тариа болон бусад чухал хэрэгцээт зүйлийн хомсдолд орсон байна. Ойрх Дорнод болон Хойд Африкт нүүрлэсэн эдийн засгийн хямрал нь хүнсний аюулгүй байдлын асуудлыг нэмэгдүүлсэн. Сири, Йемений хувьд мөргөлдөөн гол хүчин зүйл хэвээр байна. Америкийн бүс нутгийн хүмүүнлэгийн хямралын улмаас Гайтийн хүн амын 40 гаруй хувь нь өлсгөлөнгийн онцгой түвшинд, Венесуэлийн хүн амын дийлэнх нь хүнсний аюулгүй байдлын асуудалд өртжээ. ОХУ-ын өдүүлсэн дайны улмаас Украинд дор хаяж хагас сая хүүхэд ядууралд нэрвэгджээ. Европын бусад улс орнуудын эрчим хүчний үнийн огцом өсөлт нь зарим талаараа дайнаас үүдсэн инфляц болон амьжиргааны өртгийн хямралд хүргэсэн бөгөөд энэ нь нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс харьцангуй ихээр нөлөөлж байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь ядуурал, хүнс тэжээлийн дутагдал болон нүүн, шилжин суурьшилтад хүргэж байна. Далайн түвшний өсөлт болон үер нь Бангладеш, Гондурас, Сенегал зэрэг улсын далайн эргийн хүмүүсийн ядуурлыг нэмэгдүүлж байгаа бол агаарын температурын өсөлт, эрчим хүчний дэд бүтцийн төслүүд нь Канад, ОХУ-ын уугуул иргэдэд сөргөөр нөлөөлж байна.⁴ Энэтхэг, Пакистан зэрэг бусад улс урьд өмнө тохиож байгаагүй хэт халалт болон агаарын бохирдлын улмаас тариалан эрхлэгчид, гудамжны худалдаачид, өдрийн цалинтай ажил эрхлэгч зэрэг гадаа ажиллахаас өөр аргагүй болсон хүмүүс ихээхэн хохирч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Пакистанд орсон аадар бороо, үер нь хүмүүсийн амьдрал, амьжиргааг гамшигт хүргэж байна. Долдугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоолыг улс орнууд сайшаан дэмжсэн хэдий ч уур амьсгалын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалтгүй хэвээр байна. COP27 нь уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хохирсон хүмүүст зориулан алдагдал, хохирлын санг бий болгохоор шийдвэрлэсэн хэдий ч чулуужсан түлшний хэрэглээг үе шаттайгаар зогсоох талаар тохиролцоонд хүрч чадсангүй.⁵ Үүний зэрэгцээ засгийн газруудын нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах өнөөгийн амлалт нь дэлхийн дулаарлыг 2.5°C-т хүргэсэн гамшигт үр нөлөө гаргасан хэмээн буруутгахад хүргэжээ.

Дэлхийн өнцөг булан бүрд албадан нүүлгэлтийн улмаас орон байртай байх эрх зөрчигдөн ялгаварлан гадуурхагддаг нийгмийн бүлгүүд их өртөж байна. Африк, Америк, Азийн улс орнуудын засгийн газрууд нөлөөлөлд өртсөн уугуул иргэдээс чөлөөт, урьдчилан, мэдээлэлтэй зөвшөөрөл авалгүйгээр олборлох, хөдөө аж ахуй, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхийг зэрэгцээ зарим тохиолдолд газар нутгаас

нь албадан нүүлгэжээ. Танзан улсын эрх баригчид аялал жуулчлалыг дэмжихийн тулд уугуул Маасай иргэдийг өвөг дээдсийнх нь газар нутгаас албадан нүүлгэн шилжүүлжээ.

Үндэстэн дамнасан хуулийн этгээдэд дэлхийн татвар ногдуулах талаарх НҮБ-аас дэмжин буй шинэ гэрээг боловсруулах ажил үргэлжилж байгаа бөгөөд 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар хэлэлцэн эцэслэх тогтоолыг санал нэгтэй батлав. Энэ нь 2021 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас дэлхийн татварын өнөөгийн хэлэлцээ нь компаний ашгийн эх үүсвэр болон татварын эрхийн хуваарилалтын тэнцвэргүй байдлыг залруулах хэмжээнд хүрээгүй хэмээн үзсэний үр дүн юм. Энэ нь дэлхийн өмнөд хэсгийн улс орнуудад асуудал болдог бол дэлхийн хойд хэсгийн улс орнуудын хувьд ихэвчлэн эрх зүйн зохицуулалттай байдаг. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг илүү сайн баталгаажуулахын тулд ялангуяа бага орлоготой орнуудад чухал шаардлагатай нэмэлт нөөцийг бий болгох шударга тогтолцоог хангах энэ хүчин чармайлтыг идэвхижүүлэх шаардлагатай.⁶

Засгийн газрууд уур амьсгалын хямралыг бууруулах, дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 1.5 хэмээс доош байлгах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэхийн тулд чулуужсан түлшний хэрэглээг зогсоож, нүүрстөрөгчгүй эдийн засагт хүрэх шударга, хүний эрхэд үндэслэсэн шилжилтийг тууштай хийх хэрэгтэй байна. Засгийн газрууд хүн бүрийн, тэр дундаа нийгмийн гадуурхагдсан хувь хүн, бүлгүүдийн амьжиргааны түвшин, хоол хүнс, цэвэр ус, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, орон байраар хангагдах эрхийг баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой. Засгийн газрууд өөрийн улсын нутаг дэвсгэрт аливаа төсөлд хэрэгжүүлэхдээ уугуул иргэдийн чөлөөт, урьдчилсан, мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрлийг авах ёстой.

Чинээлэг улс орнууд болон олон улсын санхүүгийн байгууллагууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх, тэр дундаа уур амьсгалын хямралд өртөж, тусламж шаардлагатай байгаа улс орнуудыг дэмжих олон улсын хүчин чармайлтын хүрээнд өр төлбөрөөс нь яаралтай чөлөөлж, хөрөнгө оруулах шаардлагатай. Орлого багатай орнууд НҮБ-аас санаачлан хэлэлцүүлж буй дэлхийн татварын шинэчлэлээр дамжуулан илүү шударга, үр ашиг бүхий нэмэлт чухал санхүүжилтийн эх үүсвэр хүртэх болно.

ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН МЕХАНИЗМ

2023 онд Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ой, Венийн тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрийн 30 жилийн ой, НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглал батлагдсаны 25 жилийн ой тохионо. Гэвч улс орнууд хүний эрхийн үүргээ бүрэн тууштай бус, эсхүл хангалтгүй хэрэгжүүлэх, хүний эрхийг ноцтой зөрчсөн үйлдэлд олон улсын хариу арга хэмжээ авахгүй байх, олон улсын хүний эрхийн механизмд хангалттай санхүүгийн эх үүсвэр бий болгохгүй байх зэргээр эдгээр хүний эрхийн баримт бичгийг үнэгүйдүүлж байна.

Олон улсын хүний эрхийн механизмын хүч чадал, уян хатан байдлыг нэмэгдүүлэхийн тулд улс орнууд үүрэг амлалтаа нэмэгдүүлэн, тодорхой алхам хийх ёстой. Үүнд, НҮБ-ын хүний эрхийн үндсэн тулгуур төсвийг нэмэгдүүлж, хүний эрхийн олон улсын үүргээ бүрэн тууштай хэрэгжүүлж, хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэх олон улсын механизмын уялдаа холбоо, үр дүнтэй байдлыг дэмжих зэрэг багтана.

1. "UN: Veto resolution is a vital step towards accountability", 26 April
2. "The ICC at 20: Double standards have no place in international justice", 1 July
3. *Essential Elements of a Torture-Free Trade Treaty*, September, 23 September
4. *Any Tidal Wave Could Drown Us: Stories from the Climate Crisis*, 3 November
5. "COP27: Loss and Damage fund is welcome but failure to deliver on phasing out fossil fuels is a huge setback", 21 November
6. *Taxation, Illicit Financial Flows and Human Rights*, 28 June

АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТАЛААРХ ТОЙМ

Мөргөлдөөний хор аюул тулгамдсан асуудал хэвээр, бууруулах чиглэлд ямар нэгэн ахиц гарсангүй. Гэхдээ хүчирхийллийн хохирогчдын үнэнийг мэдэх эрх, шударга ёс, хохирлын нөхөн төлбөр болон олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцогдож болох хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлд хариуцлага хүлээлгэх чиглэлд бүс нутгийн хэмжээнд бага ч болов ахиц гарлаа.

Бүс нутгийн бараг бүх улс Ковид-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн сөрөг үр дагавартай тэмцэж байна. Гэвч үүнд нь мөргөлдөөн, ОХУ-аас Украин улс руу халдан түрэмгийлснээс үүдсэн эдийн засгийн хямрал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн цаг агаарын хүндрэл бэрхшээл, нөхцөл байдал ихээхэн саад учруулж байна. Үүний улмаас сая сая хүний хоол хүнс, эрүүл мэнд болон амьжиргааны зохистой түвшинд аж төрөх эрх ноцтой зөрчигдсөөр байна.

Бүс нутгийн эрх баригчид тайван эсэргүүцэгчдийн шүүмжлэлт дуу хоолойг зогсоох олон арга тактикийг ашигласаар, үндэсний аюулгүй байдлыг хангах, эсхүл цар тахалтай тэмцэх нэрийдлээр тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг нухчин дарах, эсэргүүцлийн жагсаалыг хүч хэрэглэх тараах явдал эрчимжсээр байна. Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхэд тогтоох эрх баригчдын хяналт улам бүр нэмэгдсэнээр хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүд, сэтгүүлчид болон улс төрийн сөрөг хүчний гишүүд баривчлагдах, цагдан хоригдох, ял шийтгүүлэх зэргээр айлган сүрдүүлэлт, хүчирхийлэлд өртсөөр байна.

Мөргөлдөөн, уур амьсгалын хямралаас дайжих хүмүүсийн тоо улам бүр өссөөр байна. Гэвч олон улсын санхүүжилт дулимаг байгаагаас дүрвэгсдийн наад захын хэрэгцээг шуурхай хангахад шаардлагатай нөөцийн хомсдолд хүргэж байна.

Бүс нутаг даяар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл газар авч байгаа нь жендэрийн ялгаварлан гадуурхалт болон бусад хэлбэрийн тэгш бус байдал ямар түвшинд байгааг харуулж байна. Зарим улсад, ЛГБТИ хүмүүс болон альбинизмтай хүмүүс ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс хамгаалагдаж чадахгүй байна.

Одоо хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ашигт малтмал болон дэд бүтцийн төслөөс үүдэн байгаль орчин доройтох, иргэд нүүлгэн шилжүүлэгдэх эрсдэл өндөр хэвээр байна.

ХУУЛЬ БҮС ХАЛДЛАГА, АЛЛАГА

Зэвсэгт бүлэглэлүүд болон засгийн газрын цэргийн хүчнийхэн энгийн иргэдийг бай болгож байгаа нь үхэл, сүйрлийг дагуулсаар байна. Буркина Фасод Мусульман болон Исламын шашныг дэмжигч зэвсэгт бүлэглэл (GSIM), Сахел дахь Исламын зэвсэгт бүлэглэлүүд (ISS) хот суурин газрууд руу дайрчээ. Мусульман болон Исламын шашныг дэмжигч зэвсэгт бүлэглэл (GSIM) Жибо хот дахь цэвэр усны байгууламжийг сүйрүүлсний улмаас 300,000 орчим хүн сөрөг нөлөөлөлд өртжээ. Сахел дахь Исламын зэвсэгт бүлэглэлүүд (ISS) 6 дугаар сард Сейтенга хот руу дайрсан халдлагын үеэр хамгийн багадаа 80 орчим хүн амь үрэгдсэний ихэнх нь энгийн иргэд байжээ. Халдлага үйлдэгчид айл өрхүүдээр орж эрчүүдийг нь хөнөөжээ. Салан тусгаарлагчдын зэвсэгт бүлэглэлүүд Камеруны баруун хойд болон баруун өмнөд бүс нутгийн хүмүүс, эмнэлэг болон сургуулиудыг бай болгожээ. Алс хойд нутгийн зэвсэгт бүлэглэлүүд тосгон руу дайрч олон арван энгийн иргэдийн амь насыг хөнөөж, олон тооны хүнийг хүчээр авч явжээ. Төв Африкийн Бүгд Найрамдах улсад (ТАБНУ)

хоёр, гуравдугаар сарын хооронд зэвсэгт бүлэглэлүүд болон засгийн газрын цэргийн хүчний гарт наад зах нь 100 энгийн иргэн амь насаа алджээ. Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын зүүн хэсэгт зэвсэгт бүлэглэлүүд энгийн иргэд рүү халдах нь эрчимжиж 1800 орчим энгийн иргэн халдлагад өртөн нас баржээ.

Этиоп улсад засгийн газрын зэвсэгт хүчин болон зэвсэгт бүлэглэлүүд Оромиа, Бенишангул-Гумуз, Амхара, Тиграй, Гамбела зэрэг бүс нутаг дахь энгийн иргэд рүү халдсаны улмаас мөн олон тооны хүн амь үрэгджээ. Мали улсын Банкас-Серкл дахь гурван тосгон руу 6 дугаар сард хийсэн халдлагын үеэр 130 орчим хүн амь эрсдэсний ихэнх нь энгийн иргэд байжээ. Мозамбек дахь Аль-Шабааб бүлэглэл Кабо Делгадо бүс нутгаас Ниасса, Нампула хүртэлх бүс нутагт энгийн иргэд рүү дайрчээ. Уг зэвсэгт бүлэглэлийн тавдугаар сард Кабо Делгадо дахь 3 тосгон руу дайрсан халдлагын үеэр 10 хүний толгойг тастаж, охид, эмэгтэйчүүдийг хүчээр авч явж, иргэдийн орон гэрийг галдан шатаажээ. Нигер улсын гол төлөв зүүн хойд хэсэгт үйл ажиллагаа явуулж байсан Боко Харам зэвсэгт бүлэглэлийн халдлага төвийн хойд болон баруун хойд хэсгийн зарим мужуудад тархжээ. Боко Харам, Баруун Африкийн Исламын бүлэглэл болон бусад үл мэдэгдэх зэвсэгт этгээдүүдийн гарт хамгийн багадаа 6907 хүн амь үрэгджээ. Хоёр болон тавдугаар сарын хооронд Сомали улсад энгийн иргэд рүү дайрсан халдлагын улмаас 167 хүн эрсдэж, 261 хүн шархадсаны 76 хувийг Аль-Шабааб бүлэглэл үйлджээ. Өнгөрсөн 10 дугаар сард нийслэл Могадишу хотын Боловсролын яамны байр болон олон хүний хөдөлгөөн бүхий худалдааны захын замын уулзварт тэсрэх бөмбөг дэлбэлсний улмаас 100 гаруй иргэн амь насаа алджээ.

Энгийн иргэд агаарын цохилт гэх мэт халдлагын золиос болсоор байна. Буркина Фасо дахь үндэсний зэвсэгт хүчнийг дэмжигч Францын хүчин хоёрдугаар сард Ансарул Ислам зэвсэгт бүлэлд агаараас цохилт өгөх үеэр 4 энгийн иргэн амь үрэгджээ. Буркинабегийн зэвсэгт хүчний 4 болон 8 дугаар сард хийсэн агаарын цохилтын үеэр олон арван энгийн иргэд мөн үрэгджээ. Төв Африкийн Бүгд Найрамдах улсад 1-10 дугаар сарын хооронд гар хийцийн тэсрэх бөмбөгтэй холбоотой 40 удаагийн халдлагын улмаас 11 хүн амь эрсдэж, 42 хүн бэртэж гэмтжээ. Дедебит, Мекелле, Ади Даеро зэрэг Тиграйн хотуудад Этиопын засгийн газрын зэвсэгт хүчин хэд хэдэн удаагийн агаарын цохилт хийж улмаар олон зуун энгийн иргэд амь эрсдэжээ. Агаарын цохилтод хүүхдийн цэцэрлэг өртжээ. Өнгөрсөн хоёрдугаар сард Нигерийн зэвсэгт хүчний Маради мужид хийсэн агаарын довтолгоонд долоон хүүхэд өртөж амиа алджээ. Тус цэргийн хүчнийхнийг аравдугаар сард болсон агаарын довтолгооны үеэр гар аргаар алт олборлогч энгийн иргэдийн хууль бусаар хөнөөсөн хэрэгт мөн буруутгаж байгаа билээ.

Мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийлэл (МХБХ) өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд амьд үлдсэн хүмүүс сэтгэл зүйн болон бусад эрүүл мэндийн хүндрэл бэрхшээлтэй тулгарсаар байна. Өмнөд Суданд засгийн газрын зэвсэгт хүчний цэргүүд болон сөргөлдөгч хүчин болох Судан Ардын Чөлөөлөх Армийн хооронд 2-5 дугаар сард өрнөсөн мөргөлдөөний үеэр Юнити мужийн өмнөд хэсэгт 130 гаруй охид, эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Бүлэглэн хүчиндсэн тохиолдлууд ч гарчээ. ТАБНУ дахь НҮБ-ын олон талт байдлыг нэгтгэн тогтворжуулах байгууллага 6-10 дугаар сарын хооронд тус улсад мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийллийн 47 тохиолдлыг баримтжуулжээ. Тавдугаар сард Конгогийн Хөгжлийн төлөөх бүлэглэл Итури мужийн алт олборлогч тосгон руу дайрсан халдлагын үеэр наад зах нь 6 эмэгтэйг хүчиндсэн хэрэг Ардчилсан Бүгд Найрамдах Конго улсад гарчээ. НҮБ-ын мэдээлснээр 2-5 дугаар сарын хооронд Самоли улсад мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийллийн 4 тохиолдол гарчээ. Этиопын Афар бүс нутагт болсон халдлагын үеэр амьд үлдсэн 4 эмэгтэй Тиграины зэвсэгт хүчнийхэний халдлага, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хэмээн мэдүүлжээ.

Хүмүүнлэгийн тусламжийг хориглох, хязгаарлах үйл ажиллагааг дайны арга болгон ашигласаар байна. Буркина Фасогийн Мусульман болон Исламын шашныг дэмжигч зэвсэгт бүлэглэл нь хойд болон зүүн зүгт байрлах хэд хэдэн хот руу нэвтрэх

хүмүүнлэгийн тусламж болон худалдааны хангамжийг хаагаад зогсохгүй цэргийн хамгаалалтад явсан энгийн иргэдийн хангамжийн цуваа руу довтолжээ. Ардчилсан Бүгд Найрамдах Конго улсын зүүн хэсэг зэвсэгт бүлэглэлүүд болон цэргийн ажиллагаануудад өртөхийн зэрэгцээ засгийн газрын зэвсэгт хүчин болон зэвсэгт бүлэглэлүүдийн аль алиных нь зориуд тогтоосон хязгаарлалтын улмаас хүмүүнлэгийн тусламж саатаж, олон нийт чухал хэрэгцээтэй тусламж авч чадахгүй байна. Этиоп улсад 2020 оны арван нэгдүгээр сард үүссэн сөргөлдөөний үеэр Тигрэй рүү хүрэх хүмүүнлэгийн тусламжид хязгаарлалт тогтоосон бөгөөд хүмүүнлэгийн хэлэлцээр хийгдсэнтэй холбогдуулан Этиоп улсын Засгийн газраас гуравдугаар сараас эхлэн хүмүүнлэгийн тусламжийн цувааны тоог мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломж олгожээ. Гэвч ч байлдааны нөхцөл байдал хурцадсантай холбогдуулан дээрх үйл ажиллагааг наймдугаар сард бүрэн зогсоожээ. Харин байлдааны ажиллагаа зогсоох гэрээг арван нэгдүгээр сард байгуулснаар хүмүүнлэгийн тусламжийн хүртээмж дахин нээгджээ. Мали улсад Катиба Сермагийн дайчид 5-9 дүгээр сарын хооронд Бони, Дуэнца, Хомбори, Госси хотуудыг холбосон замыг хаасан нь худалдаачдыг цэргийн хүчнийхэнтэй дагалдан явахад хүргэв. Наймдугаар сард зэвсэгт бүлэглэл худалдаачдын цуваа руу халдаж 19 ачааны машиныг шатаажээ.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд энгийн иргэд болон иргэний дэд бүтцэд санаатайгаар халдахгүй байх, энгийн иргэдийн амь насанд хохирол учруулж болохуйц дайралт, довтолгоо хийхгүй байх зэргээр энгийн иргэдийг хамгаалах ёстой. Түүнчлэн эрсдэлд байгаа хүн амын хүмүүнлэгийн тусламжийг аюулгүй, саадгүй байхад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

ҮНЭНИЙГ МЭДЭХ ЭРХ, ШУДАРГА ЁС, НӨХӨН ТӨЛБӨР

Олон улсын хууль тогтоомжид заасан гэмт хэрэг, эсхүл хүний эрхийн бусад ноцтой зөрчил, хүчирхийллийн улмаас хохирсон хүмүүсийн үнэнийг мэдэх эрх, шударга ёсыг шаардах, хохирлын нөхөн төлбөр авах, гэмт этгээд ял завшихтай тэмцэх чиглэлээр бүс нутгийн хэмжээнд гарсан амжилт маш бага байлаа. Гуравдугаар сард Чадын эх баригчид Балакагийн эсрэг зэвсэгт бүлэглэлийн толгойлогч Максим Жеффрой Эли Мокком Гавакаг 2013, 2014 онд Төв Африкийн Бүгд Найрамдах улсад үйлдсэн дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутган ял шийтгэл ногдуулахаар Олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгчээ. Тавдугаар сард, Нидерландын эрх баригчид 1994 онд өрнөсөн төрлөөр устгах гэмт хэргийн үеэр Рүанда улсын Мугина хотод болсон Тутси үндэстнийг үйл олноор нь хоморголон устгасан хэрэгт өмнө цэргийн офицер байсан хүнийг буруутган баривчилсан. Судан улсын Дарфур хотод дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэрэгт буруутгагдаж буй Али Мохаммед Али болон Төв Африкийн Бүгд Найрамдах улс дах Селека зэвсэгт бүлэглэлийн командлагч гэгдэх Махамат Сайд нарын шүүх хурал дөрөв болон есдүгээр сард Олон улсын Эрүүгийн шүүхэд тус тус эхэлсэн. Зэвсэгт бүлэглэлүүдийн гишүүдийн үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой бусад хэргийг нийслэл Бангуй дахь шүүх болон Эрүүгийн тусгай шүүхээр хэлэлцэж эхлээд байна. Өмнөд Суданы Ией хотын цэргийн шүүхээс найман цэргийг мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийлэлд гэм буруутайд тооцсон. Гэвч Өмнөд Суданы холимог шүүхийн ажиллагаанд ахиц гараагүй л байна.

Засгийн газрууд олон улсын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг нарийн нягт, хараат бус, хөндлөнгийн, үр дүнтэй, ил тод байдлаар явуулж, гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүмүүсийг иргэний шүүхээр шударгаар шүүж, ял шийтгэл завшихтай тэмцэх талаарх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх ёстой.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

ХООЛ ХҮНСЭЭР ХАНГАГДАХ ЭРХ

ОХУ-ын Украин руу хийсэн дайралт нь улаан буудайн хамаарал бүхий Африкийн олон оронд нийлүүлэлтийг тасалдуулахад хүргэв. Үүний зэрэгцээ Европ дахь дайны өөр нэгэн үр дагавар болох шатахууны үнийн өсөлт нь хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг бий болгож нийгэм, эдийн засгийн эмзэг болон ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлтэй бүлэгт сөргөөр нөлөөлж байна. Африкийн хэд хэдэн улсад урьд тохиож байгаагүй ган гачиг болсон нь хүнсний аюулгүй байдлыг улам дордуулав. Ангол, Буркина Фасо, Төв Африкийн Бүгд Найрамдах улс, Чад, Кени, Самоли, Өмнөд Судан, Судан зэрэг улсад хүн амын томоохон хэсэг өлсгөлөнд нэрвэгдэж, хүнсний аюулгүй байдал эрсдэлийн өндөр түвшинд хүрлээ. Ангол улсын Куне, Хуила, Намибе зэрэг муж хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтээр хамгийн хангалтгүй бүс нутагт хамаардаг бөгөөд насанд хүрэгчид болон хүүхдүүд амьд үлдэхийн тулд өвсний ишийг идэж амь зогоож байна. Буркина Фасо улсад есдүгээр сар гэхэд 4.9 сая хүн, түүний дотор мөргөлдөөний улмаас орон гэрээ орхин дотооддоо дүрвэсэн олон сая хүн хүнсний аюулгүй байдлын асуудалтай нүүр тулгарч байна хэмээн НҮБ-ын Хүмүүнлэгийн асуудлыг зохицуулах газраас мэдээлжээ. Мөргөлдөөн болон нүүлгэн шилжүүлэлт нь Нигер улс дахь 4.4 сая хүн хүнсний аюулгүй байдалд заналхийлж байна. Төв Африкийн Бүгд Найрамдах улсын хүнсний аюултай байдал 50 хувь, зарим бүс нутагт 75 хүртэл хувийг хамарч байна. Самоли улсын хүн амын бараг тал орчим хувийн хүнсний аюулгүй байдал алдагдсан бол малчдийн амьжиргааны эх үүсвэр болсон 3 сая гаруй мал ган гачгийн улмаас хорогджээ. Мөн Анголд ган гачгийн улмаас мал их хэмжээгээр хорогджээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ

Хэдийгээр Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө буурч байгаа ч хэд хэдэн улсад шинэ төрлийн өвчний дэгдэлт нүүрлэлээ. Есдүгээр сард Эбола вирусийн дэгдэлтийн улмаас Уганда улсад 56 хүн нас баржээ. Конго улсын Пуэнт-Нуар бүс нутагт улаан бурхан өвчний тархалтын улмаас 112 хүүхэд эндсэн бол Зимбабве улсын Муцса дүүргээс бусад бүс нутагт халдварласан улаан бурхан өвчний улмаас таваас доош насны 750 хүүхэд нас баржээ. Камерунд холер тахал долоон бүс нутагт тархсаны улмаас 298 хүн нас барсан бол Дуала хот дахь Шинэ Белл шоронд холер тахал өвчний хоёр удаагийн тархалтын улмаас хамгийн багадаа 16 хоригдол нас баржээ. Тэдгээр нас барсан иргэдийн нэг нь тайван жагсаал, цуглаанд оролцсон үндэслэлээр 2020 оны есдүгээр сараас хойш хууль бусаар хоригдож байсан Родриге Ндагуэрх Куфет байжээ. Бүгд Найрамдах Малави улсын 28 дүүргийн 26 дүүрэгт тархсан Холер тахлын улмаас 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 576 хүн бас баржээ. Цаг агаарын эрс тэрс нөхцөл байдал өвчний дэгдэлтийг улам бүр нэмэгдүүлжээ. Нигер улсад үерийн усны улмаас Холер зэрэг тахал өвчин дэгдэж Йобе, Борно, Адамава зэрэг мужид 320 гаруй хүн нас баржээ. Сомалид нүүрлэсэн ган гачгийн улмаас хоол, хүнс тэжээлийн дутагдалд орсон тохиолдол улам бүр нэмэгдэж байгаагийн зэрэгцээ холер, улаан бурхан зэрэг халдварт өвчний сэжигтэй тохиолдол өмнөх жилүүдтэй харьцуулахад огцом нэмэгдсэн хэмээн Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас мэдээлжээ.

ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХ

Албадан нүүлгэн шилжүүлэх асуудал бүс нутгийн түвшинд ихээхэн анхаарал татаж байна.

Анголын өмнөд хэсэгт мал аж ахуйн зориулалтаар нийтийн бэлчээрийг булаан авах ажиллагаа үргэлжилсээр байна. Аравдугаар сард цагдаа нар Намибе бүс нутгийн Мосамедес хотын зах болох Ндамба орчим амьдардаг Мукуай бүлгийн иргэдийн эзэмшдэг газрыг худалдаа эрхлэгчдэд шилжүүлэх зорилгоор иргэдийн хүч

хэрэглэн нүүлгэн шилжүүлэхдээ 16 байшин болон бусад эд хогшлыг галдан шатаажээ. Танзани улсын эрх баригчид аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зорилгоор Аруша бүс нутгийн Лолиондо дүүргийн уугуул Маасай бүлгийн гишүүдийг өвөг дээдсээс үе уламжлан ирсэн газар нутгаас нь хүч хэрэглэн албадан нүүлгэжээ. Ийнхүү нүүлгэн шилжүүлэхээс өмнө төрийн холбогдох байгууллагаас оршин суугчидтай бодитоор зөвлөлдөх, зохих мэдэгдлийг урьдчилан өгөх, нөхөх олговор олгох зэрэг ажиллагааг огт хийгээгүй байна.

Хотын төв болон суурин газруудад албадан нүүлгэн шилжүүлэх ажиллагаа албан бус суурьшлын төвүүдэд төвлөрч байна. Тухайлбал, Гана дахь Их Аккра Бүс Нутгийн Аюулгүй байдлын Зөвлөлийн шийдвэрээр нийслэл Аккра дахь Фрафраха дахь Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн судалгааны зөвлөлийн харьяа газарт байрлах олон зуун байшинг нураажээ. Нүүлгэн шилжүүлэх тухай мэдэгдлийг ердөө 48 цагийн өмнө оршин суугчдад өгчээ. Нигерийн Холбооны Нийслэлийн Нутаг Дэвсгэрийн Захиргаа болон аюулгүй байдлын байгууллагаас наймдугаар сард Дубайдна Дуруми 3 тосгоны 100 орчим барилга, байгууламжийг нураажээ. Аюулгүй байдлын ажилтнууд нулимс асгаруулагч хий хэрэглэсний улмаас хоёр хүүхэд ухаан алдсан бөгөөд нураах явцдаа оршин суугчдын биед халджээ. Замби улсын Чингола хотын захиргаа Чингола дүүргийн Касомпе нислэгийн зурвас газарт баригдсан 300 гаруй байшинг нураажээ.

Засгийн газрууд хоол хүнс, эрүүл мэнд, орон байрны эрхийг баталгаажуулахын тулд олон улсын хамтын ажиллагаа болон шаардлагатай тусламж, дэмжлэгийг ашиглах шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй. Түүнчлэн хүний эрхийг зөрчигч этгээдэд хариуцлага хүлээлгэх шаардлагатай.

ЭСЭРГҮҮЦЭЛ, ШҮҮМЖЛЭЛИЙГ НУХЧИН ДАРСАН НЬ

ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Эрх баригчид үндэсний аюулгүй байдал, эсхүл Ковид-19 цар тахлыг иргэдийн эсэргүүцлийн жагсаал, цуглааныг хориглон хязгаарлах, эсхүл хүч хэрэглэх тараах шалтаг болгон ашигласнаас үүдэн жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг нухчин дарах явдал ихээхэн эрчимжсэн. Гэвч энэ нь эрхээ шаардан жагсаал, цуглаан хийх иргэдийн хүсэл зоригийг нухчин дарж чадаагүй юм. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт гэх зэрэг янз бүрийн асуудлаар томоохон эсэргүүцлийн жагсаал, цуглаан бүс нутгийн хот, суурин газруудад өрнөлөө.

Эсэргүүцлийн жагсаалд оролцогч олон тооны иргэд амиа алдсан бөгөөд үүнийг Чад, Төв Африкийн Бүгд Найрамдах улс, Гвиней, Кени, Нигери, Сенегал, Сьерра-Леон, Сомали, Судан зэрэг бусад улсын аюулгүйн албаныхан жагсагчдын эсрэг хүч, албадлага хэтрүүлэн хэрэглэсэнтэй холбон тайлбарлаж байна. Чад улсад аравдугаар сард 50 жагсагч, Сьерра-Леон улсад наймдугаар сард 27 жагсагчийн амь насыг хөнөөсөн талаарх мөрдөн байцаалтын үр дүн оны эцэст тодорхой болоогүй байна.

Эсэргүүцлийн жагсаалд оролцогчдыг баривчлах, цагдан хорих байдал бүс нутгийн хэмжээнд түгээмэл хэвээр байна. Тухайлбал, амьжиргааны зардал нэмэгдэж байгааг эсэргүүцсэн жагсагчдыг Кени, Сьерра-Леон, Өмнөд Судан зэрэг улсад баривчилж, хорьжээ. Суданы аюулгүй байдлын албаныхан 2021 оны цэргийн эргэлтийг эсэргүүцэгчдэд өргөн хүрээнд шахалт үзүүлэх ажлын нэг хэсэг болгон олон зуун жагсагчдыг цагдан хорьж, хүчээр алга болгожээ. Гвиней, Сенегал, Уганда улсын эрх баригчид сөрөг хүчний удирдагчид болон жагсаал, цуглаан зохион байгуулагчдын эсрэг арга хэмжээ хэрэгжүүлж байна. Угандад инфляц, амьжиргааны өртөг өндөр байгааг эсэргүүцсэнийх нь төлөө тус улсын сөрөг хүчний удирдагч Кизза Бесигие-г гурван удаа баривчилж, цагдан хорьжээ. Мөн түүнийг баривчлахыг эсэргүүцсэн зургаан эмэгтэйг бусдыг хүчирхийлэлд уриалсан, хууль бус жагсаал, цуглаан зохион байгуулсан үндэслэлээр цагдан хорьжээ. Долдугаар сард Гвиней улсад хуулиар хориглосон жагсаал, цуглаан зохион байгуулсан, оролцсон үндэслэлээр иргэдэд эрүүгийн хэрэг үүсгэжээ. Чад, Төв Африкийн Бүгд Найрамдах

улс, Гвинеи, Лесото, Нигер, Сенегал зэрэг хэд хэдэн улсад жагсаал, цуглаан хийхийг хориглосон нь хуран цуглах, жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлаж байгаа хэрэг юм. Баруун Африкийн улс орнуудыг Эдийн засгийн нийгэмлэгийн Шударга ёсны шүүхээс нийслэл Дакар хотын төвд улс төрийн чанартай жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглосон Сенегал улсын сайдын 2021 оны тушаал нь хүний үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчсөн хэмээн үзжээ. Сенегалын эрх баригчид шүүхийн шийдвэрийг давж заалджээ.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хүний эрх хамгаалагч, идэвхтэн, сэтгүүлч, сөрөг хүчний гишүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгөө хэрэгжүүлснийхээ төлөө хүчирхийлэл, айлган сүрдүүлэлт, заналхийлэлд өртөж байна. Нигер улсын Кано хотын шүүхээс олон нийтийн сүлжээний хоёр алдартыг комеди бичлэгээр дамжуулан Кано хотын амбан захирагчийг гүтгэсэн үндэслэлээр долоо хоног баривчлах, ташуурдах болон торгох шийтгэл ногдуулжээ. Сенегалд хүний нэр төрийг доромжилж худал мэдээлэл тараасан үндэслэлээр тус улсын сөрөг хүчний удирдагч болон хүний эрхийн хоёр идэвхтнийг баривчилжээ. Судан улсад Өмнөд Кордофаны нэгэн эмэгтэйг тус улсын зэвсэгт хүчинд хүүхэд элсүүлэх шаардлагын талаар нийгмийн сүлжээнд худал мэдээлэл нийтэлсэн үндэслэлээр Цахим гэмт хэргийн тухай хуульд заасан хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хэмээн үзэж ял шийтгэл ногдуулжээ. Идэвхтэн, зохиолч Каквенза Рукирабашайжаг Уганда улсын Ерөнхийлөгчийн хүү дэслэгч генерал Мухоози Кайнеругабагийн амгалан тайван байдлыг алдагдуулах зорилгоор өөрийн твиттер хуудсанд нийтлэл бичсэн үндэслэлээр цагдаа нар саатуулжээ. Тэрээр суллагдсаныхаа дараа тус улсыг орхин явжээ. Замби улсад тус улсын Ерөнхийлөгчийг TikTok ашиглан доромжилсон үндэслэлээр хоёр эрэгтэйд 24 сарын хорих ял оноожээ. Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг халдлага, түрэмгийлэл үргэлжилсээр байна. Гана, Мали, Нигери, Сомали, Танзани улсын эрх баригчид засгийн газрын шүүмжилсэн, тааламжгүй контент нийтэлсэн үндэслэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг зогсоож, хааж байна. Түүнчлэн Судан, Уганда улсын аюулгүй байдлын албаныхан хэвлэл мэдээллийн байгууллагад нэгжлэг хийжээ. Бүс нутгийн хэмжээнд олон тооны сэтгүүлчдэд байнгын шахалт дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, цаашлаад цагдан хорьж, баривчилж байна. Этиоп улсад эрх баригчид хамгийн багадаа 29 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг ямар нэгэн хэрэгт буруутгахгүйгээр баривчилжээ. Эсватини хотод Свазиландын Мэдээний нэвтрүүлгийн редактор Звели Мартин Дламиниг Терроризмын эсрэг хуулийн дагуу террорист хэмээн зарлав. Гана улсад ерөнхийлөгч Акуфо-Аддо 2020 оны ерөнхийлөгчийн сонгуульд нөлөөлөхийн тулд шүүгчидтэй хуйвалдсан гэх бичлэгийг нийтэлсний дараа нэгэн радиогийн хөтлөгчийг шүүхийг үл хүндэтгэсэн хэргээр хоёр долоо хоног хорьж, 3000 седи (377 орчим доллар)-ээр торгожээ. Брунди, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс, Мадагаскар, Малави, Мозамбик, Нигер, Руанда, Сомали, Зимбабве улсад сэтгүүлчид болон хүний эрх хамгаалагчдын эрхийг нухчин дарсаар байна. Мадагаскарт өнгөрсөн зургадугаар сард байгаль орчныг хамгаалагч 70 настай Анри Ракотоарисоаг хутгалан амь насыг нь хөнөөжээ. Мозамбикт хүний эрхийн хуульч Жоао Нхампоссагийн албан өрөөг эвдлэн орж компьютер, флаш диск, гар утас болон бичиг баримтуудыг нь хулгайлсны зэрэгцээ хүний эрхийн хуульч Адриано Нувунга нарын амь насанд заналхийлжээ. Уг хууль бус үйлдлийг төрийн байгууллага хийсэн хэмээн сэжиглэж байна.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн хэмжээнд эрх баригчид эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хэрэгжүүлэх боломжийг улам бүр чангатган иргэний нийгмийн байгууллагад нөлөөлж байна. Тухайлбал, Ангол улсын бүх нийтийн сонгуулийн өмнөхөн цагдаа нар Омунга болон Соёл, Хүний Эрхийн Хөгжлийн Холбоо байгууллагаас энх тайвны төлөөх бага хурал зохион байгуулах гэж байсныг зогсоосон бол Бурунди улсын эрх баригчид

гуравдугаар сард хэвлэлийн бага хурлыг зогсоожээ. Гвиней улсад шилжилтийн үеийн эрх баригчид үндсэн хуулийн засаглалыг эргэн бэхжүүлэхийг шаардсан иргэний нийгмийн байгууллагууд болон улс төрийн намын эвсэл болон Үндсэн хуулийн хамгаалах Үндэсний Хороог татан буулгажээ.

Түүнчлэн энэ мэт байгууллагын үйл ажиллагааг хянан зохицуулах хууль тогтоомжийг баталжээ. Нигер улс төрийн бус байгууллагуудын санаачилсан бүх хөтөлбөр, төслүүдийг засгийн газраас зөвшөөрөл авах шийдвэр гаргасан болохоо зарлажээ. Зимбабве улсад иргэний нийгмийн байгууллагуудын оршин тогтнол, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх зохицуулалтыг Хувийн сайн дурын байгууллагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль тогтоох байгууллагад өргөн барьжээ.

Засгийн газрууд хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, идэвхтнүүдийг хүчирхийлэх, айлган сүрдүүлэх явдлыг эцэс болгож, гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял тулгаж буй бүх хэргийг хэрэгсэхгүй болгон, дур зоргоор баривчилсан хүн бүрийг нэн даруй, ямар нэг урьдчилсан нөхцөлгүйгээр суллах, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэх, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даан ажиллах нөхцөлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧ, ДҮРВЭГЧ, ЦАГААЧДЫН ЭРХ

Мөргөлдөөн болон уур амьсгалын хямралаас үүдэн орон гэрээ орхин дүрвэх явдал нэмэгдсээр байна. Конго улсад нэмж 600 000 гаруй хүн орон гэрээ орхин явснаар дотооддоо дүрвэгсдийн тоо 6 саяд хүрсэн нь бүс нутгийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Мозамбик дахь мөргөлдөөн тэлсний уршгаар орон гэргүй болж шилжин суурьшигч иргэдийн тоо 1.5 саяд хүрчээ. Хоол хүнс, ундны усны аюулгүй байдал алдагдаж, хоол тэжээлийн дутагдал, эрүүл мэндийн эрсдэл, шаардлагад нийцээгүй орон байр нь тэдний амьдралын чанар ямар байгааг илтгэж байна. Сомалид ган гачиг, мөргөлдөөний улмаас 1.8 гаруй сая хүн нүүн шилжжээ.

Уганда улс 1.5 сая орчим дүрвэгсдийг хүлээн авсан нь бүс нутгийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт юм. Тэдний бараг 100,000 орчим нь 2020 онд дүрвэн иржээ. Гэвч 11 дүгээр сарын байдлаар Уганда улс шаардлагатай байгаа санхүүжилтийн ердөө 45 хувийг бүрдүүлжээ. Цаашид эрүүл мэнд, цэвэр ус, ариун цэврийн байгууламж болон боловсрол гэх зэрэг дүрвэгсдэд нэн шаардлагатай хэрэгцээг хангаж чадахгүйд хүрч байна. Судан хөрш зэргэлдээ орнуудаас ирэх дүрвэгсдийг хүлээн авсаар байна. Тухайлбал, Өмнөд Суданаас 20,000 орчим дүрвэгч, Этиопоос 59,800 дүрвэгч хүлээн авчээ. Гэвч олон улсын санхүүжилтийн хомсдол нь Дэлхийн хүнсний хөтөлбөрийн санхүүжилтийг бууруулж, дүрвэгсдэд олгох тусламжийг танахад хүргэжээ.

Цагаач иргэд хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлд өртсөөр байна. 1-5 дугаар сарын хооронд 14,000 иргэнийг Алжираас Нигер улстай хиллэдэг “Тэг цэг” хүртэл хүч хэрэглэн хөөн гаргажээ. Өнгөрсөн зургадугаар сард Ливитэй хил орчмоос 10 цагаач иргэний цогцос олджээ. Эквадорын Гвинейд олон арван цагаачдыг хуульд заасан журмыг зөрчин, өмгөөлөгч авах боломж олгохгүйгээр албадан нутаг буцаажээ.

Засгийн газар дүрвэгсэд, цагаачид болон орон гэргүй болж дотоодод шилжин суурьшиж байгаа иргэдийг хамгаалж, хоол хүнс, ус, орон байр зэрэг хүмүүнлэгийн тусламжид бүрэн хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ цагаач болон дүрвэгчдийг хууль зөрчин албадан буцаах, саатуулах явдлыг шуурхай таслан зогсоож, шаардлагатай хамгаалалтыг үзүүлж байгаа эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Олон улсын хамтын нийгэмлэг нь дүрвэгсдэд шаардлагатай үндсэн хэрэгцээг зохистой хангахад шаардагдах урт хугацааны тогтвортой, урьдчилан тооцоолох боломжтой санхүүжилтийг хүлээн авагч улсад олгох замаар санхүүжилтийн дутагдлыг шийдвэрлэх шаардлагатай.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ГАДУУРХАГДСАН БҮЛГҮҮД

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Танзани, Эквадорын Гвинеид жирэмсэн охидыг сургуулиас хөөх явдал газар авсан хэвээр байна. Гэхдээ зарим эерэг өөрчлөлт гарч байна. Есдүгээр сард Хүүхдийн эрх болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Африкийн Шинжээчдийн Хорооноос Танзани улсын дээрх бодлого нь Хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын талаарх Африкийн Хартиг зөрчсөн хэмээн үзэж бодлогыг шинэчлэх зөвлөмж өгчээ. Түүнчлэн, Сьерра-Леон улс жирэмсэн болон жирэмслэлтээс үүдэн сургууль завсардсан 800 орчим хүүхдийг сургуульд дахин хамруулжээ.

Жендэрт суурилсан хүчирхийлэл бүс нутгийн түвшинд тулгамдсан асуудал хэвээр байна. Өмнөд Африкт эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөсөн хэрэг 10.3%-иар өсжээ. 7-9 дүгээр сарын хооронд 989 эмэгтэй бусдын гарт алагдсан бол бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг 11%, 10.8%-иар тус тус нэмэгджээ. Эсватини улсад нэгэн эмэгтэйг хуучин хамтран амьдрагч нь харгис хэрцгийгээр хөнөөсөн хэрэг гарсан нь эмэгтэйчүүдийн эрхийн байгууллагууд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхийн тулд үндэсний хэмжээнд онц байдал зарлах уриалгыг гаргахад хүргэв. Гвинеид хүчингийн гэмт хэргийг хохирогч эмэгтэйчүүдийг ийм төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаа хангалтгүй байгаагийн зэрэгцээ эмнэлгийн тусламж, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүй, хууль зүйн болон нийгмийн тусламж, дэмжлэг маш муу байна.

Хэд хэдэн улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг баталсан нь дэвшил юм. Конго улсын хууль тогтоох байгууллагаас эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн болон бусад хүчирхийлэлтэй тэмцэх тухай “Моузбарагийн хууль”-ийг баталжээ. Сьерра-Леонд Газрын эрхийн тухай хуулиар эмэгтэйчүүдэд гэр бүлийн газрыг өмчлөх, ашиглах тэгш эрхийг хуульчилсны зэрэгцээ төрийн албаны бүх албан тушаалын 30 хувьд эмэгтэйчүүдийг ажиллуулахаар Тэгш эрхийн тухай хуульд заажээ. Зимбабве улсад эрт буюу бага насны гэрлэлтийг хуулиар хоригложээ. Түүнчлэн Мадагаскарын Үндэсний Ассамблейн Байнгын Комиссын ерөнхийлөгч үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцох талаарх эрүүгийн хуулийн нэмэлтийн тухай хуулийн төслийг эрс няцаажээ. Нигерт Үндэсний Ассамблей жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих зорилготой 5 хуулийн төслийг буцаажээ. Харин эмэгтэйчүүдийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагын эсэргүүцлийн дараа тэдгээр хуулийн төслөөс 3 хуулийн төслийн хэлэлцэхээр болжээ. Руанда улсын парламент 15-аас дээш насны хүмүүст жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх -ерөндөг зөвшөөрөх талаарх хуулийн төслийг хэлэлцэхээс татгалзжээ.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

ЛГБТИ хүмүүсийг дарамтлах, баривчлах, яллах явдал улс орнуудад түгээмэл байна. Бенин дэх трансжендэр эмэгтэйг хөршүүд болон таксины жолооч зодож хүчирхийлсний дараа цагдаа нар хэлтэс дээрээ аваачин зодож, нүцгэлэн гэрэл зургийг нь авчээ. Тэрээр гурван хоног нүцгэн, хоол ундгүй хоригдсоны эцэст ял шийтгэлгүй суллагджээ. Замби улсад бэлгийн цөөнхийг эсэргүүцэгчид жагсаал зохион байгуулж WhatsApp ашиглан ижил хүйстэн гэж сэжиглэгдсэн хүмүүсийг хөнөөж, хүчирхийлэхийг уриалжээ. Угандагийн ТББ-ууд хариуцсан Хорооноос ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг шүхэр байгууллага болох Уганда дахь Бэлгийн цөөнх байгууллагыг татан буулгах шийдвэр гаргажээ.

Хэд хэдэн улсад ижил хүйстнүүдийн харилцааг гэмт хэрэгт тооцох шинэ арга хэрэгслийг авч хэрэгжүүлж байна. Гана улсад ЛГБТИ хүмүүсийг гэмт хэрэгт ял шийтгэх талаарх хуулийн төслийг парламент хэлэлцэж байна. Экваторын Гвинеид ЛГБТИ хүмүүсийн эрхтэй холбоотой хуулийн төслийг боловсруулж байна. Сенегалын

Үндэсний Ассамблей ЛГБТИ хүмүүсийн харилцааг гэмт хэрэгт тооцох тухай хуулийн төслийг хэлэлцээд дэмжсэнгүй.

Үндэсний шүүхүүд ЛГБТИ хүмүүсийг эрхийг хамгаалах чиглэлд маш хойрго, идэвхгүй хандаж байна. Нигерийн Баучи мужийн Нинжи хотын шүүх гурван гей залууд цаазын ял оноожээ. Эсватини улсын Дээд шүүх Эсватини дахь Бэлгийн болон Жендэрийн Цөөнхийн байгууллагыг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэхээс татгалзсан бүртгэлийн байгууллагын шийдвэрийг хэвээр үлдээжээ. Намиби улсын Дээд шүүх гадаад улсад бүртгүүлсэн ижил хүйстнүүдийн гэрлэлтэд үндэслэн цагаачлалын эрх зүйн байдлаа тогтмолжуулахыг хүссэн Намиби иргэнтэй гэр бүл болсон хүний өргөдлийг хэрэгсэхгүй болгожээ. Бүс нутгийн түвшинд Африкийн хүний болон ард түмний эрхийн Комисс ЛГБТИ хүмүүсийн эрхийн чиглэлээр ажилладаг гурван байгууллагын ажиглагчаар ажиллах тухай өргөдлийг татгалзжээ.

АЛЬБИНИЗМТАЙ ХҮМҮҮС

Альбинизмын талаарх хуучны мухар сүсэг, буруу ташаа ойлголтоос үүдэж зүүн болон өмнөд Африкийн зарим хэсэгт альбинизмтай хүмүүсийн эсрэг зэрэмдэглэх болон бусад хэлбэрийн хүчирхийлэл халдлага үргэлжилсэн хэвээр байна. Мадагаскарт хүчирхийллийн халдлагын тоо хоёр дахин өсөж, альбинизмтай хүүхдийг хулгайлсан тохиолдол 2, 8 дугаар сард бүртгэгджээ. 3 дугаар сард Амбоасари Ацимо дүүргийн Берано гэх газарт зургаан настай хүүхдийн зэрэмдэглэгдсэн цогцос олджээ. Замби улсын Зүүн мужийн Чама дүүргийн Мунгвалала тосгонд 1 дүгээр сард 12 настай хүүгийн булшийг сүйтгэн гарыг нь тасадсан байжээ. Мөн төвийн бүсийн Мкуши дүүрэгт 10 настай гурван хүүгийн долоовор хурууг тастсан хэрэг гарчээ.

Засгийн газар ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс хүмүүсийг хамгаалах, ялангуяа охид, эмэгтэйчүүдийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах эрхийг хамгаалах, жендэрт суурилсан хүчирхийллээс ангид амьдрах боломжийг бүрдүүлэх, хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүст бэлгийн болон нөхөн үржихүйн болон бусад эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүй, хууль зүй болон нийгмийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОРОЙТОЛ

Уур амьсгалын өөрчлөлтийн уршгаар цаг агаарын хүндрэл бэрхшээл бүс нутагт нүүрлэсээр байна. Африкийн Хорнд сүүлийн 40 жилд тохиож байгаагүй ган гачиг болж байхад Өмнөд Африкийн зарим хэсэгт их хэмжээний бороо оржээ. Мадагаскарт нэгдүгээр сараас дөрөвдүгээр сарын хооронд зургаан шуурга, хар салхины улмаас 200 гаруй хүн амь үрэгджээ. Өмнөд Африкийн Квазулу-Натал мужид орон нутгийн засаг захиргаа орон зайн төлөвлөлт, дэд бүтцийн засвар үйлчилгээний хангалтгүй байдал нь үерийн улмаас олон зуун байшин барилга нурахад нөлөөлжээ. Баруун Африкт, Нигерийн эрх баригчид 25 мужийг хамарч 1.9 сая хүнд хор уршиг учруулж, 500 гаруй хүний амь насыг авч одсон үерийн хор уршгийг буруулах чиглэлээр шаардлагатай үйл ажиллагааг явуулж чадаагүй. Сенегалд далайн төвшин нэмэгдэж байгаа нь загас агнуурын тосгон устгах, тэр дундаа Сент-Луисын Гует-Ндар суурингийн иргэдийг газраа орхин явахад хүргэж байна.

Бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн уул уурхай болон дэд бүтцийн төслүүд нь байгаль орчны доройтол, иргэдийг нүүлгэн шилжүүлэх өндөр эрсдэл үүсгэж байна. Намиби улсын Дээд шүүхээс Каванго мужид үйл ажиллагаа явуулж байгаа Канадын уул уурхайн компаний хайгуулын үйл ажиллагааг зогсоох тухай хэд хэдэн байгууллагын гаргасан яаралтай нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ. Танзани болон Уганда зэрэг улс хүн амын суурьшил, зэрлэг амьтны нутаг, хөдөө аж ахуйн газар, усны эх үүсвэр бүхий газраар дамжин өнгөрөх

1,443 км урттай Зүүн Африкийн түүхий нефтийн хоолой барих төлөвлөгөөнд үргэлжлүүлэн оролцсон хэвээр байна.

Хэд хэдэн улс уур амьсгалын хямралыг бууруулах, байгаль орчны доройтлыг шийдвэрлэх шинэ арга хэмжээг санаачилжээ. Гвиней улсын Ерөнхий сайд байгаль орчныг ноцтой бохирдуулсан үйлдэлд буруутгагдаад байгаа боксит олборлогч байгууллагыг олон улсын бохирдлын хяналтын стандартыг мөрдөн ажиллах зааварчилгаа өгчээ. Сомали улсын холбооны засгийн газар Байгаль орчин Уур амьсгалын өөрчлөлтийн Яам байгуулж, ган гачигтай тэмцэх ерөнхийлөгчийн тусгай төлөөлөгчийг томилжээ. Өмнөд Африкийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл парламентад өргөн мэдүүлсэн хэдий ч уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд энэ нь хангалтгүй хэмээн үзэж байна. Өмнөд Суданы Ерөнхийлөгч Киир нөлөөлөлд буй бүлэг болон экосистемд нөлөөлөх үнэлгээг хийж дуусах хүртэл тус улс дахь гүний олборлолттой холбоотой бүх үйл ажиллагааг түр зогсоохыг зарлигджээ.

Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын хүндрэл бэрхшээлээс хувь хүн болон бүлгийг хамгаалах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж, Уур амьсгалын дасан зохицох, үр дагаврыг бууруулахад чиглэсэн олон улсын тусламж, хамтын ажиллагааг эрэлхийлэх шаардлагатай.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АМЕРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Ковид-19 цар тахлаас хойшхи 3 жилийн хугацаанд Америкийн бүс нутгийн улс орнууд түүний хортой үр дагаврыг амссан хэвээр байна. Эрх баригчид сая сая хүний хоол хүнс, ус, эрүүл мэнд зэрэг үндсэн эрх хэрэгжих баталгааг хангаж чадаагүй бөгөөд эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилт хангалтгүй хэвээр байна. Эдийн засгийн уналтаас сэргийлэх нэрийдлээр эрх баригчид эсэргүүцэгчдийн шүүмжлэлт дуу хоолойг хаах, эсэргүүцлийн бусад хэлбэрийн үйл ажиллагааг нухчин дарах тактикийг өргөн цар хүрээнд хэрэглэж байна. Хэд хэдэн улсад онц байдал зарлан дур зоргоор баривчлах, шударга бусаар шүүх, хууль бусаар ял оноох, цаазлан хороох хүртэл зөрчил гарав. Түүнчлэн жагсаал, цуглаан хийсэн иргэдийн эсрэг хүч, албадлагыг хэтрүүлэн хэрэглэх, хүний эрхийн идэвхтнүүдийг хууль бусаар ажиглах, хянах, сэтгүүлчдэд халдах гэх зэрэг бусад арга хэрэгслийг ашиглажээ. Уугуул иргэд, хар арьстнууд болон арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтад өртдөг бусад бүлгүүд хүний эрхийн зөрчилд харьцангуй их өртсөөр байна. Цагаачдыг урьдчилан саатуулах төвд цагдаа нар хүчирхийлж, эрүүдэн шүүж, зүй бусаар харьцаж байна. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудал хүндэрч хэд хэдэн улс орны эрх баригчид үр хөндөлтийн хүртээмжийг бууруулж, бэлгийн цогц боловсролыг хориглох арга хэмжээ авав. Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд ЛГБТИ хүмүүс эрсдэлд орсоор байна. Трансжендэр хүмүүсийн амь насыг хөнөөсөн хэргийн тоо зарим улс орнуудад огцом өсөв. Хэд хэдэн улсад өнгөрсөн хугацаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл хүлээлгэхээр шүүхэд шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч онц ноцтой хүний эрхийн зөрчил үйлдсэн этгээдүүд ял шийтгэл завших явдал байсан хэвээр байна. Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтийн талаар хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлж чадсангүй. Дүрвэгсэд болон сайхан амьдралын төлөө гадаад улс орнуудыг зорих иргэдийн тоо өндөр хэмжээнд хүрчээ. Харин улс орнууд дүрвэгсэд болон цагаачдын эрхийг дордуулсан, олон улсын эрх зүйг зөрчсөн бодлого хэрэгжүүлж байна.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

Ядуу хүмүүсийн тоо цар тахлын өмнөх үетэй харьцуулахад өндөр байна. Бүс нутгийн олон улсад цар тахлаас үүдсэн бүтцийн шинжтэй хямрал бэрхшээлийг тухайлбал цар тахлаас өмнөх эдийн засаг, нийгмийн тэгш бус байдал, татварын асуудал, эрүүл мэндийн төсвийн хомсдол, түүнчлэн хүнсний аюулгүй байдал, цэвэр ус, суурь дэд бүтцийн хүртээмжийн дутагдал гэх зэрэг асуудлыг шийдвэрлэж чадсангүй.

Инфляц эдийн засгийн хүндрэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Олон улсын валютын сангийн мэдээлснээр Аргентин, Чили, Колумб, Гайти, Гондурас, Никарагуа, Венесуэл зэрэг улсад инфляцын төвшин өндөр байна.

Бүс нутгийн хэмжээнд олон сая хүн хоол хүнс, эрүүл мэнд, ундны ус зэрэг үндсэн эрхээ эдэлж чадахгүй байна. Бразил улсад хүн амын талаас илүү хувь нь зохистой, аюулгүй хоол хүнсээр хангагдаж чадахгүй байгаа бөгөөд үүнд хар арьстнууд, нийгмийн гадуурхагдсан иргэд харьцангуй ихээр өртөж байна. Венесуэлд хүн амын дийлэнх хэсгийн хүнсний аюулгүй байдал алдагдсан бөгөөд Дэлхийн банкны мэдээлснээр наймдугаар сард тус улс хүнсний үнийн инфляцийн түвшингээр дэлхийд гуравдугаарт оржээ. Кубад хүнсний хомсдолын улмаас хүмүүс үндсэн хэрэгцээний бараа бүтээгдэхүүн авахын тулд олон цагаар дараалалд зогсоход хүргэдэг бол Гайти улсад холер өвчин дахин дэгдэх үед хүн амын 40 гаруй хувь нь өлсгөлөнд нэрвэгджээ. Оны эхний хагасын байдлаар Аргентин улсын хүн амын 36.5 хувь нь ядуу амьдарч байна. Эрүүл мэндийн тогтолцоонд үндсэн шинэчлэл хийх шаардлагатай байгаа нь цар тахлын нөхцөл байдлаас тодорхой харагдаж

байгаа хэдий ч ихэнх улс орны эрх баригчид эрүүл мэндийн эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж чадсангүй. Бразил улсын Конгресс сүүлийн 10 жилийн хугацаанд Эрүүл мэндийн яамны төсвийг хамгийн багаар баталсан нь эрүүл мэндийн тусламж, эм тарианы хүртээмж буурахад хүргэжээ. Гватемал, Гондурас, Парагвай зэрэг улс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд маш бага төсөв хуваарилсаар байгаа бөгөөд хүн амын үндсэн хэрэгцээг хангаж чадахгүйд хүрчээ. Чили улсад есдүгээр сард эдийн засаг, нийгэм, соёл, байгаль орчны эрхийн хамгааллыг нэмэгдүүлсэн шинэ үндсэн хуулийн төслөөс иргэдийн дийлэнх нь татгалзсан бол эрүүл мэнд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаар санал болгож буй шинэчлэлүүд оны эцэс хүртэл хүлээгдсээр байна.

Засгийн газрууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх хамгийн наад захын үндсэн үүргээ биелүүлэх баталгааг хангахын тулд боломжит нөөцийг дээд хэмжээнд хуваарилах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ДУР ЗОРГЫН БАРИВЧИЛГАА, ХУУЛЬ БУС АЛЛАГА, ЭРҮҮ ШҮҮЛТ, ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Олон орны эрх баригчид хүний амьд явах, эрх чөлөө, шударгаар шүүлгэх, бие махбодын халдашгүй байх эрхийг зөрчсөөр байна. Эдгээр зөрчил нь ихэвчлэн улс төрийн хямрал, онц байдлын үед засгийн газрын авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, эсхүл аюулгүй байдлыг хангах болон шүүх таслах байгууллагаас хууль бус, дур зоргоороо, тухайн нөхцөл байдлын хэр хэмжээнд нийцээгүй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх явцад гардаг. Аюулгүйн албаныхан хүч албадлагыг хэтрүүлэх, иргэдийн амь насыг хууль бусаар хохироох нь түгээмэл бөгөөд гол төлөв Аргентин, Бразил, Колумб, Доминикан, Мексик, АНУ, Венесуэл зэрэг улсын орлого багатай, арьс өнгөөр ялгаварлан гадуурхдаг нийгмийг бүлэгт чиглэж байна. Венесуэлийн аюулгүйн албаныхан 1-9 дүгээр сарын хооронд нутаг дэвсгэрийн хэмжээд 488 удаа шүүхээс гадуур цаазын ялыг гүйцэтгэжээ. Бразилд цагдаа нар олон арван хүний аминд хүрчээ. Колумб, Куба, Эквадор, Эль Сальвадор, Никарагуа, Мексик, Венесуэлд дур зоргоороо баривчлах ажиллагаа өргөн хүрээнд явагдсан хэвээр байна.

Баривчлагдсан хүмүүсийг ихэвчлэн эрүүдэн шүүж, бусад харгис хэргийг байдлаар харьцдаг бөгөөд зарим тохиолдолд хүчээр алга болгодог. Гуравдугаар сард Эль Сальвадорын эрх баригчид гэмт бүлэглэлүүдийн үйлдэж байгаа хүн амины хэрэг нэмэгдсэнтэй холбогдуулан онц байдал зарласан. Гэвч энэхүү арга хэмжээ нь 60,000 гаруй иргэнийг баривчилж, шударга бусаар шүүн таслах зэрэг нийтийг хамарсан хүний эрхийн ноцтой зөрчилд хүргэсэн юм. Эквадор улсын хорих газрын тогтолцооны хямралын улмаас эрх чөлөөгөө хасуулсан 146 хүн амиа алджээ. Эквадор, Мексикт олон нийтийн аюулгүй байдлыг хангахад зэвсэгт хүчний үүрэг оролцоог өргөжүүлэхэд чиглэсэн захиргааны, шүүхийн болон хууль тогтоох байгууллагын шийдвэрүүд гарчээ.

ЭСЭРГҮҮЦЭЛ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ НУХЧИН ДАРСАН НЬ

Хэд хэдэн улсад нийгмийн хөдөлгөөн, идэвхтнүүд эдийн засаг, нийгмийн наад захын эрхийг хангах, жендэрт суурилсан хүчирхийллийг эцэс болгох, үндэслэлгүйгээр баривчлагдсан хүмүүсийг суллах, байгаль орчныг хамгаалахыг шаардаж гудамж, талбайд жагсжээ. Гэвч эрх баригчид зайлшгүй шаардлага үүсгээгүй байхад хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэх явдал түгээмэл байна. Эквадорт аюулгүйн хүчнийхэн уугуул иргэдийн нийгэм, байгаль орчны талаарх эсэргүүцлийн жагсаалын эсрэг хүч

албадлагыг хэтрүүлэн хэрэглэсний улмаас дор хаяж зургаан хүн нас баржээ. Колумби улсад болсон байгаль орчныг хамгаалах эсэргүүцлийн жагсаалын үеэр уугуул иргэдийн удирдагч буудуулж амь насаа алдсан бол нийслэл Богота хотод болсон эсэргүүцлийн жагсаалын үеэр жагсаалд оролцогч нэгэн иргэн суманд оногдож нүд нь гэмтжээ. Перу улсад оны эхний хагаст эсэргүүцлийн жагсаалын үеэр цагдаагийн хариу арга хэмжээний улмаас наад зах нь гурван хүн амиа алдсан бол арван хоёрдугаар сард Ерөнхийлөгч асан Педро Кастилло албан тушаалаас нь огцруулсны дараах улс төрийн хямралын улмаас зохион байгуулсан жагсаалын үеэр наад зах 22 хүн амиа алджээ.

Болив улсад үр тариаг нь устгах оролдлогыг эсэргүүцсэн кока навч үйлдвэрлэгчдийн эсрэг хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүч хэрэглэж, зарим иргэдийг дур зоргоор саатуулжээ. Өнгөрсөн зургадугаар сард АНУ-д Охайо мужийн Акрон хотод хар арьст Жейланд Уокер цагдаа нарт 46 удаа буудуулж нас барсны дараа болсон эсэргүүцлийн жагсаалын үеэр 75 хүнийг баривчилжээ. Мексикт жэндэрт суурилсан хүчирхийллийн эсрэг засгийн газрын идэвхгүй байдлыг эсэргүүцсэн феминистүүд болон хүний эрхийг хамгаалагчдыг гутаан доромжилж, зарим мужид хамгаалалтын албаныхан жагсагчдыг зодож, дур зоргоороо баривчилжээ. Пуэрто-Рико болон Куба улсад болсон Иан хар салхины улмаас үүссэн цахилгааны тасалдал болон нийгмийн бусад шаардлагын талаар эсэргүүцсэн жагсагчдын эсрэг цагдаа нар хүч, албадлага хэтрүүлсэн тухай хэд хэдэн мэдээллүүд гарчээ.

Никарагуа улсын эрх баригчид нэг жилийн хугацаанд 1000 гаруй байгууллагын эрх зүйн статусыг цуцалж, хамгийн багадаа 12 их сургуулийг хааж, сэтгүүлчдийг хорьж, улс төрийн идэвхтнүүд болон сөрөг хүчнийхний эсрэг хүч хэрэглэжээ. Венесуэлд тагнуулын алба болон аюулгүй байдлын бусад хүчнийхэн шүүхэд нөлөөлөн зохих шийдвэр гаргуулж засгийн газрыг эсэргүүцэгчид гэж үзсэн хүмүүсийг дур зоргоороо баривчилж, эрүүдэн шүүж, бусад байдлаар хэргийг хандаж байна. Боливи, Бразил, Колумб, Гватемал, Гондурас, Мексик, Перу, Венесуэл зэрэг улсад хүний эрх хамгаалагчид үйл ажиллагаа явуулсныхаа төлөө амиа алдсаар байна. Үүнээс гадна Боливи, Бразил, Чили, Колумб, Куба, Эквадор, Эль Сальвадор, Гватемал, Гондурас, Мексик, Никарагуа, Парагвай, Перу, Венесуэл зэрэг улсад хүний эрх хамгаалагчдыг заналхийлж, дарамталж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж, дур зоргоор баривчилсаар байна. Колумбид нэг жилийн хугацаанд дор хаяж 189 нийгмийн зүтгэлтэн, хүний эрхийн хамгаалагч амиа алджээ. Венесуэлд дор хаяж 396 хүний эрхийг хамгаалагчид айлган сүрдүүлэлт, гутаан доромжлол, заналхийлэлд өртжээ. Никарагуад баривчлагдсан олон арван шүүмжлэгчдийн хэргийг шударга процессын хамгаалалтгүй нөхцөлд шүүхээр таслан шийдвэрлэж байна. Парагвай улсад төрийн эрүүл мэндийн бодлогыг эсэргүүцэн жагсаалд оролцсон идэвхтнүүдэд ял шийтгэл тулгаж байна. Гватемал улсад шүүгч, прокурор, хүний эрхийг хамгаалагчид болон жагсагчдад үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэжээ. Болив улсад хүний эрх хамгаалагчид засгийн газрыг шүүмжилсэн хэргээр ял сонссон.

Бус нутаг даяар хэвлэлийн эрх чөлөө эрсдэлтэй хэвээр байна. Колумб, Гайти, Мексик, Венесуэлд сэтгүүлчид амь насаа алджээ. Мексик улсад дор хаяж 13 сэтгүүлч амиа алдсан нь хэвлэлийнхний хувьд хамгийн эрсдэлтэй жил байлаа. Никарагуа, Венесуэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дур мэдэн хаажээ. Гватемал улсад авлига болон ял шийтгэл завшиж байгаа талаар мэдээлсэн сэтгүүлчид кампаничилсан гүтгэлэг, гэмт хэрэг үйлдсэн талаарх үндэсдлэлгүй гомдолтой байнга тулгардаг бол Сальвадорт олон арван сэтгүүлч рүү халдсан хэрэг гарчээ.

Идэвхтэн, сэтгүүлчдийг хууль бусаар тандах зорилгоор Пегасус тагнах программыг ашиглаж байсан нь Эль Сальвадор, Мексик улсад бүртгэгджээ.

Мөн эрх баригчид шүүмжлэгчдийн дуу хоолойг нухчин дарах зорилгоор хэт бүрхэг, өргөн хүрээтэй хууль тогтоомжийг ашиглаж байна. Эл Сальвадор улсад гэмт бүлэглэлийн талаар мэдээлэх замаар “айдас түгшүүр”, “гэнэтийн сандрал” нийгэмд бий болгосон тохиолдолд 10-15 жилийн хорих ялаар шийтгэхээр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Никарагуа улсад Ашгийн бус байгууллагуудын

зохицуулалт, хяналтын тухай ерөнхий хуулийг баталсан нь 2018 оноос хойш иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг сулруулж, нухчин дарах зорилго бүхий цуврал хуулийн нэг хэсэг юм. Кубад өнгөрсөн арван хоёрдугаар сард шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах эрсдэлтэй байна. Аргентин улсын Жужуй мужид эсэргүүцлийн жагсаалыг хязгаарлахын тулд зам хааж жагсаал, цуглаан хийх, "олон нийтийн орон зайг хууль бусаар авах"-ыг хориглох талаарх хуулийн төслийг санаачилжээ.

Засгийн газрууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа сэтгүүлч, хүний эрх хамгаалагч болон улс төрийн өрсөлдөгчид аюулгүй, хүчирхийлэл, дарамт болон хууль бус хяналт, ажиглалтаас ангид байдлаар үйл ажиллагаагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх баталгааг хангах шаардлагатай.

Засгийн газрууд иргэдийн тайван жагсаал, цуглаан хийх эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, хууль сахиулах байгууллагаас хүч албадлагыг зөвхөн зайлшгүй тохиолдолд, тухайн нөхцөл байдлын хэр хэмжээнд нийцүүлэн хуулийн дагуу хэрэглэх баталгааг хангах шаардлагатай.

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Бүс нутгийн хэд хэдэн улсын эрх баригчид бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг ноцтойгоор зөрчсөн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Сальвадор улсад үр хөндөлтийг бүхэлд нь хориглосон хууль хүчин төгөлдөр үйлчилсэн хэвээр байна. Наад зах нь хоёр эмэгтэй эх барих яаралтай тусламжтай холбоотой хэргээр хоригдсон бөгөөд нэг эмэгтэй 50 жилийн хорих ялаар шийтгэгджээ. Бүгд Найрамдах Доминикан улсын Конгресс үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх талаарх Эрүүгийн хуулийн шинэчлэлийг дахин хэлэлцэж чадсангүй. Өнгөрсөн зургадугаар сард АНУ-ын Дээд шүүх Роугийн мэдүүлсэн Вэйдийн эсрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож 50 орчим жил үргэлжилсэн хууль зүйн зарчмыг үгүйсгэснээр үр хөндөлтийн эрхийн талаарх холбооны хамгаалалтыг үгүй хийлээ. Энэхүү шийдвэрийн дараа АНУ-ын хэд хэдэн мужийн хууль тогтоогчид үр хөндөлтийг хориглох, хязгаарлах хууль баталсан юм. Харин АНУ-ын олон тооны мужийн иргэдийн олонх нь үр хөндөлтийн эрхийг хамгаалахын төлөө санал өгчээ. Пуэрто Рикод үр хөндөлтийг хязгаарлах зорилго бүхий таван хуулийн төслийг хэлэлцсэн боловч парламентын гишүүдийн саналыг авч чадаагүй юм. Перу улсын хууль тогтоох байгууллагад үр хөндүүлэх эрхийг хязгаарлаж эрсдэлд хүргэх хуулийн төслийг өргөн болилаа. Аргентин улсад 2020 онд батлагдсан хуулиар жирэмсний эхний 14 долоо хоногт үр хөндөлтийг хууль ёсны хэмээн үзэж, гэмт хэрэгт тооцохгүй байхаар заасан хэдий ч үр хөндөлтийн үйлчилгээ авахад ихээхэн саад бэрхшээл тулгарсаар байна.

Гэсэн хэдий ч бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаар зарим ахиц дэвшил гарчээ. Хоёрдугаар сард Колумбын Үндсэн хуулийн шүүхээс жирэмсний 24 дэх долоо хоног хүртэл үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар шийдвэрлэлээ. Мексикт дахин дөрвөн муж үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэхээс татгалзсанаар Мексикийн 32 мужаас 11 мужид үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй болж байна. Эквадор улсад хүчингийн гэмт хэргийн хохирогч үр хөндүүлснийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх хуулийн төслийг ерөнхийлөгч батламжилж гарын үсэг зурсан ч нөхөн үржихүйн эрхийг хязгаарласан зарим хязгаарлалт байсан хэвээр байна.

Хэд хэдэн улсын эрх баригчид бэлгийн цогц боловсролын эрхийг хамгаалж чадсангүй. Аргентин (Чако муж), Парагвай, Перу болон АНУ-ын хэд хэдэн муж улсын эрх баригчид боловсролын байгууллагын орчинд бэлгийн болон жендэрийн олон янз байдлын талаарх боловсролыг ашиглахыг хязгаарласан хэвээр байна.

Засгийн газар бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, тэр дундаа үр хөндөлтийн аюулгүй үйлчилгээ авах боломжийг хангах ёстой.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД, ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Эрх баригчид эмэгтэйчүүд, охидыг жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах, эдгээр гэмт хэргийг үйлдсэн этгээдүүд ял шийтгэлгүй үлдэж байгаа асуудлыг шийдвэрлэж чадсангүй. ТББ-ын мэдээллээр Аргентин улсад жендэрт суурилсан 233 аллага (эмэгтэйчүүдийн аминд хүрсэн) бүртгэгдсэний 91% нь гэр бүлийн орчинд үйлдэгджээ. Мексикт 1-11 дүгээр сарын хооронд 858 эмэгтэй бусдын гарт амиа алджээ. Гэмт хэрэгтнүүдэд ял шийтгэл оногдуулахгүй байгаа нь жендэрт суурилсан аллага, гэмт хэргийг улам нэмэгдүүлж байгаа бөгөөд төр болон хууль сахиулах байгууллага үүний хариуцлагыг хүлээх ёстой. Венесуэлд 1-9 дүгээр сар хүртэлх хугацаанд нийт 199 эмэгтэйн амь насыг хохироосон хэрэг гарсан талаар орон нутгийн байгууллагууд мэдээлсэн байна. Уругвай дахь иргэний нийгмийн ажиглалтын төвөөс эмэгтэйчүүдийг алах гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд Перу улсад 124 эмэгтэйн амь насыг хохироосон гэмт хэрэг бүртгэгджээ.

АНУ-д эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах санхүүжилтийн гол механизм болох өмнө нь хүчингүй болсон Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай хуулийг тус улсын Конгресс баталж, Ерөнхийлөгч Байден гарын үсэг зурав.

ЛГБТИ хүмүүс аллага, халдлага, ялгаварлан гадуурхалт, заналхийлэлд өртөх эрсдэлтэй хэвээр байгаа бөгөөд эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөхтэй холбоотой саад бэрхшээлтэй тулгарсаар байна. Бразил, Колумб, Гватемал, Гондурас, Мексикт трансжендэр хүмүүс амь насаа алдах эрсдэлд байна. 1 дүгээр сард нийтлэгдсэн тоо баримтаас үзэхэд жилдээ трансжендэр хүмүүсийн амь насыг хөнөөсөн гэмт хэргийн гаралтын хэмжээгээр Бразил улсад 13 дахь жилдээ дэлхийд тэргүүлжээ. Харин тус улсын түүхэнд анх удаа хоёр трансжендэр эмэгтэй холбооны их хуралд сонгогдов.

Нэг жилийн хугацаанд ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах талаар хэд хэдэн эрх зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Колумб улсын Үндсэн хуулийн шүүх иргэний үнэмлэхийг бүртгэхдээ эр, эм хүйсээс бусад тэмдэглэгээг хүлээн зөвшөөрч жендэрийн олон янз байдлын талаар эрхзүйн жишиг тогтоов. Куба улс есдүгээр сард явуулсан бүх нийтийн санал асуулгын дараа Гэр бүлийн хуулийг шинэчлэн баталж ижил хүйстнүүдийн гэрлэлт болон ижил хүйстэн хосуудад хүүхэд үрчлүүлэхийг хуулиар хүлээн зөвшөөрчээ. 10 дугаар сард Мексикийн Тамаулипас муж ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуулиар хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ нь бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ. АНУ-д 12 дугаар сард Гэрлэлтийг хүндэтгэх тухай хуулийг баталж, ижил хүйстнүүдийн гэрлэлтийг холбооны хэмжээнд зарим хамгаалалтаар хангасан. Үүний эсрэгээр, тавдугаар сард Пуэрто Рикогийн Хүний эрх, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн комисс ЛГБТИ хүмүүсийн эрхийн тухай хуулийн төслийг хэлэлцэхээс татгалзсан.

Бүс нутгийн засгийн газрууд нь жендэрт үндэслэн эмэгтэйчүүдийн амь насыг хохироох, ЛГБТИ хүнийг алах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, гэмт этгээдүүдийг шүүхэд шилжүүлэх, тухайн гэмт хэрэг дахин гарахгүй байх баталгааг хангах шаардлагатай.

УУГУУЛ ИРГЭД, ХАР АРЬСТ ХҮМҮҮСИЙН ЭСРЭГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Түүхийн туршид арьс өнгөөр ялгаварлан гадуурхаж байсан хүмүүс хүний эрхийн зөрчилд харьцангуй их өртсөөр байна. Бразил, Колумб, Эквадор, Мексикт болсон газар нутгийн төлөөх мөргөлдөөний үеэр уугуул иргэдийн удирдагчид амь үрэгджээ. Колумбид уугуул үндэстний удирдагчид болон хүний эрх хамгаалагчид халдлагад

өртөж, амь насаа алдсан бөгөөд сөрөг хүчний зэвсэгт бүлгүүд үйл ажиллагаагаа явуулсаар байгаа бүс нутагт уугуул иргэд болон афро-удмын бүлгүүдийг албадан нүүлгэн шилжүүлж, зарим нь хүмүүнлэгийн хямралтай тулгарчээ. Парагвайн уугуул иргэдийг газар нутгаас нь албадан нүүлгэн шилжүүлэх үед эрх баригчид зохих хариу арга хэмжээ авч чадсангүй. Никарагуад уугуул иргэдийг албадан нүүлгэн шилжүүлж, зэвсэгт этгээдүүд хүчирхийлжээ.

Аргентин, Бразил, Канад, Гватемал, Гондурас, Мексик, Парагвай, Перу, Венесуэл зэрэг хэд хэдэн улсад засгийн газрууд нөлөөлөлд өртсөн уугуул иргэдтэй урьдчилан мэдээлэлтэйгээр зөвшилцөхгүйгээр олборлолт, хөдөө аж ахуйн, дэд бүтцийн төслүүдээ цаашид үргэлжлүүлсээр байна. Аргентинд уугуул иргэд газрын хамтын эрхийг олж авахад ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгарсаар байна. Эквадор уугуул иргэдийн удирдагчид болон хамгаалагчид руу чиглэсэн аллага, заналхийлэл үргэлжилсээр байна. Нэгдүгээр сард их хэмжээний нефт асгарсны улмаас нөлөөлөлд өртсөн Эквадорын Амазон дахь уугуул иргэд 2020 онд гарсан газрын тос асгарсан хэргийн нэгэн адил хохирлын нөхөн төлбөр авч чадсангүй.

АНУ-д уугуул эмэгтэйчүүд хүчингийн гэмт хэрэг болон бэлгийн хүчирхийлэлд илүүтэй өртөж, хүчингийн дараах үндсэн тусламж үйлчилгээ авах боломжгүйн зэрэгцээ алга болж, амь насаа алдсаар байна. Канадын Кебек мужийн хэд хэдэн анхны үндэстэн болон Иннуит бүлгийн уугуул эмэгтэйчүүд жирэмсэлтээс албадан сэргийлэх ажиллагаа болон бусад хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл байна.

Анхны уугуул иргэдийн сургуулийн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэхэд Канадын Засгийн газар болон Католик сүм оролцсон талаар Канадын ерөнхий сайд Трюдо хүлээн зөвшөөрсөн. Уг явдал нь Нийтийн Танхимын 10 дугаар сарын шийдвэрээр уугуул иргэдийн эсрэг геноцид болох нь тогтоогдсон.

Бүс нутгийн хэд хэдэн улсад төрийн хүч хэрэглэх үйлдэлд хар арьстнууд илүүтэй хохирсон байна. Бразилд цагдаагийн хэд хэдэн ажиллагааны үр дүнд олон хүний амь эрсэджээ. Тухайлбал, тавдугаар сард Рио-де-Жанейро хотын Вила Крузейро дүүрэгт 23 хүн амиа алдсан хэрэг гарчээ. Иргэний нийгмийнхний цуглуулсан мэдээллээр Бразилд цагдаа нарын гарт амиа алдсан нийт хүмүүсийн 84 хувь нь хар арьстнууд болохыг тогтоожээ. Мөн Пуэрто-Рико дахь цагдаа нарын аллагын талаарх тоо баримтаас үзэхэд орлого багатай арьс өнгөөр ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хүмүүс бага орлоготой цагаан арьстнуудтай харьцуулахад цагдаагийн аллагад өртөх өндөр эрсдэлтэй байна. АНУ-ын хууль хяналтын байгууллагаас хар арьст Гайти орогнол хүсэгчдийг дур мэдэн баривчилж, арьс өнгөөр ялгаварлан гадуурхаж, эрүүдэн шүүж, доромжлон харьцжээ. Мөн АНУ дахь цагдаа нарын амь насанд аюултай зэвсэг, хэрэгсэлд хар арьстнууд харьцангуй ихээр өртсөн болохыг харуулж байна. АНУ-ын Сенатын танхим Жорж Флойдын хэрэгт шударга ёс тогтоох асуудлыг Цагдаагийн тухай хуульд тусгаж чадсангүй. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, хууль сахиулах хариуцлагатай холбоотой өргөн хүрээний бодлого, асуудлыг шийдвэрлэх зорилготой уг хуулийг тус улсын Төлөөлөгчдийн танхим 2021 онд баталсан. Канад улсын Торонтогийн цагдаагийн алба арьс өнгөөр, ялангуяа хар арьст хүмүүсийг ялгаварлан гадуурхаж хүч хэрэглэдэг, нэгжих ажиллагаа явуулдаг гэсэн мэдээлэл бүртгэгджээ.

Эрх баригчид уугуул хүмүүсийн өөрийгөө тодорхойлох эрхийг хүндэтгэж, тэдний газар нутаг дээр аливаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхдээ чөлөөт, урьдчилан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авахыг баталгаажуулах ёстой. Уугуул хүмүүсийн амь насыг хөнөөсөн хэргийг шуурхай, хараат бусаар, үр дүнтэй мөрдөн шалгах шаардлагатай.

Эрх баригчид хууль сахиулах, цагаачлалын асуудлаарх тогтолцооны шинжтэй арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг устгах чиглэлээр шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд нөлөөлөлд өртсөн нийгмийн бүлгийн бүрэн, үр дүнтэй оролцоог хангах замаар арьс өнгөөр ялгаварлаж байгаа талаарх мэдээллийг цуглуулах тогтолцоог бий болгох шаардлагатай.

ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭХ БА ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ХАНГАЛТГҮЙ БАЙДАЛ

Хэд хэдэн улсын эрх баригчид хүний эрхийг зөрчсөн, тэр дундаа өмнөх хэдэн арван жилийн хугацаанд үйлдэгдсэн олон улсын эрх зүйн гэмт хэрэгт хариуцлага тооцох талаар гэмт хэдий ч өчүүхэн дэвшил гаргасан. Гэвч сүүлийн үед үйлдэгдсэн ийм төрлийн гэмт хэрэг болон хүний эрхийн бусад ноцтой зөрчилд сэжиглэгдсэн хүмүүсийг засгийн газрууд ерөнхийдөө яллаж чадаагүй бөгөөд ял шийтгэлгүй үлдэх нь бүс нутгийн шударга ёсны тогтолцооны нийтлэг дүр төрх хэвээр байна.

Аргентин, Боливи, Чили, Колумби, Гватемал, Уругвайн эрх баригчид хуучин цэргийн дэглэм болон дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэр үйлдсэн хүний эрхийн зөрчлийн хэргийг мөрдөн байцаах, зохих ял шийтгэл хүлээлгэх ажилд ахиц гаргажээ. Колумб улсад оны эцэс гэхэд Энх тайвны төлөөх тусгай шүүхээс армийн хэдэн арван эрхтний хэргийг шийдвэрлэж ял шийтгэл ногдуулжээ.

Гэсэн хэдий ч Эль Сальвадор эрх баригчид зэвсэгт мөргөлдөөний үеэр (1980-1992) гэмт хэрэг үйлдэж, хүний эрхийг зөрчсөн хэрэгт буруутгагдаж буй хүмүүсийг яллах тал дээр дорвитой ахиц гаргаж чадсангүй. АНУ-д Тагнуулын төв газрын (2001-2009 он хүртэл зөвшөөрөгдсөн) удирддаг нууцаар саатуулах системийн (2001-2009 онуудад) үйлдсэн хүнийг хүчээр алга болгох, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах зэрэг өргөн хүрээтэй хүний эрхийн зөрчилд хэн ч хариуцлага хүлээсэнгүй. Гватемал улсын эрх баригчид дотоодын зэвсэгт мөргөлдөөн (1960-1996)-тай холбоотой хэргүүд дээр ажиллаж буй шүүгч, прокуроруудыг олон удаа давтагдсан айлган сүрдүүлэх, дарамтлах, үндэслэлгүй эрүүгийн хариуцлага хүлээхээс хамгаалж чадсангүй.

Боливи, Чили, Колумб, Гондурас, Никарагуа, Венесуэлийн эрх баригчид 2017-2021 оны хооронд өрнөсөн эсэргүүцлийн жагсаалын үеэр хүний эрхийг зөрчиж, эсэргүүцлийг нухчин дарсан үйлдэлдээ ямар нэгэн ял шийтгэл хүлээсэнгүй. Мексикт ор сураггүй алга болсон буюу алга болгосон хүмүүсийн нийт тоо 1960-аад оноос хойш 109,000 хүрсэн бол эдгээрийн 90,000 орчим нь 2006 оноос хойш бүртгэгджээ.

Венесуэлийн асуудлаарх НҮБ-ын баримтын тайланд тус улсын цагдаа болон цэргийн албан хаагчдыг хуулийн хариуцлагаас чөлөөлөхийн тулд шүүхийн системд зүй бусаар нөлөөлсөн, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүд нь Николас Мадурогийн засгийн газартай хэлхээ холбоо байгаа талаарх мэдээллийг дурджээ. Олон улсын эрүүгийн шүүхийн Прокурорын газар Венесуэлд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн асуудлаар мөрдөн байцаалт эхлүүлээ. Энэ нь тус бүс нутагт явуулж байгаа ийм төрлийн мөрдөн байцаалтын анхны тохиолдол юм.

Чили улсад 2019 оны олон нийтийн эсэргүүцлийн жагсаалын үеэр гэмт хэрэг үйлдсэн хэмээн буруутгагдсан хүмүүс хоригдсон хэвээр байгаа бөгөөд зарим нь хилс хэргээр шийтгэгджээ. Түүнчлэн эсэргүүцлийн жагсаалын үеэр нүд нь гэмтсэн 400 гаруй хүнд нөхөн төлбөр олгох шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх талаар Засгийн газраас мэдээлсэн. Никарагуа улсад 2018 онд эхэлсэн хүний эрхийн хямралын улмаас баривчлагдсан хүмүүсийн тоо оны эцэс гэхэд 225-д хүрчээ.

Бразилын Ерөнхий прокурор тухайн үеийн Ерөнхийлөгч Болсонаротай холбоотой 10 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлсний долоог хэрэгсэхгүй болгох хүсэлтийг Улсын дээд шүүхэд гаргасан. Ковид-19 тахлын удирдлагын асуудлыг шалгах Парламентын мөрдөн шалгах комиссоос түүнийг хууль зөрчсөн, албаны эрх мэдлээ урвуулсан, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх хэрэгт яллах дүгнэлт үйлдэхийг зөвлөсөн юм. Бразилын аюулгүй байдлын хүчин болон цагдаагийн ажилтнууд хууль бусаар хүний амь хөнөөсөн үйлдэлдээ ял шийтгэлгүй үлдлээ.

Чили, Эквадор, Эль Сальвадор, Уругвай, Венесуэлд хорих газрууд өндөр ачаалалтай хэвээр байна.

Кубын Гуантанамо дахь АНУ-ын тэнгисийн цэргийн баазын баривчлах газарт 35 мусульман эрэгтэйг АНУ-ын цэргийн албаныхан дур зоргоороо, тодорхойгүй хугацаагаар баривчилсан нь олон улсын хууль тогтоомжийг зөрчиж байна.

Эрх баригчид өнгөрсөн болон өнөө үед үйлдэгдсэн олон улсын хууль тогтоомжийг зөрчсөн бүхий л гэмт хэрэг, хүний эрхийн бусад зөрчлийг шуурхай, хараат бус, шударга, үр дүнтэй мөрдөн шалгах замаар ял шийтгэлгүй үлдэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Эрх баригчид олон улсын хууль тогтоомжийг зөрчиж гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэжиглэгдэж байгаа хүмүүсийг шүүхэд шилжүүлж, үнэн зөв, шударга ёсыг тогтоож хохирогч болон амьд үлдэгсдэд нөхөн төлбөр олгох ёстой.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОРОЙТОЛ, УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ ЧАДСАНГҮЙ

Засгийн газрууд уур амьсгалын хямралын асуудлыг шийдвэрлэх хангалттай арга хэмжээ авч чадаагүй бөгөөд байгаль хамгаалагч идэвхтнүүд, уугуул иргэд энэхүү хямралыг шийдвэрлэх гэж оролдсоныхоо төлөө халдлагад өртлөө. Дэлхийн дулаан ялгаруулалтыг бууруулахад бүс нутгийн улс орнууд дэмжлэг үзүүлнэ хэмээн гоё сайхнаар ярьж байгаа ч энэхүү яриаг бодит үйл хэрэг болгож чадсангүй. Глобал Витнесс байгууллагын 2022 оны тайланд дурдсанаар 2021 онд газар нутаг, байгаль орчныг хамгаалагчдын амь насыг хөнөөсөн хэргийн дөрөвний гурав нь Латин Америкт гарчээ. Ийм аллага Аргентин, Боливи, Бразил, Колумб, Эквадор, Гватемал, Гондурас, Мексик, Никарагуа, Перу, Венесуэлд бүртгэгджээ.

НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагын мэдээлснээр Латин Америк, Африк нь байгалийн ойн бүрхэвчийг хамгийн их хэмжээгээр алдсан бүс нутгийн нэг хэвээр байна. Бразил улсад 1 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд тус улсын Амазоны ой устгах байдал 2015 оноос хойшхи хамгийн дээд түвшинд хүрчээ. Болив улсын эрх баригчид ойн бүрхэвчийг хадгалах, хууль бус ойн устгалтай тэмцэх амлалт өгсөн ч голчлон хөдөө аж ахуйн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор нэг сая гаруй га талбайг шатаажээ.

Хэд хэдэн улсын засгийн газар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх амлалт авч, хууль тогтоомж баталсан боловч тэдгээрийн аль нь ч энэхүү хямралын цар хүрээтэй нийцэхгүй байв. Арваннэгдүгээр сард болсон Талуудын 27-р бага хурлын (COP27) үеэр Канад, АНУ 2030 он хүртэл дулаан ялгаруулалтаа бууруулах зорилтоо нэмэгдүүлж чадсангүй.

АНУ-ын Конгресс тус улсын түүхэнд анх удаа уур амьсгалын өөрчлөлтийн тухай багц хууль тогтоомжийг баталсан боловч Байдены засаг захиргаа урьд нь цуцлахыг оролдож байсан холбооны газар болон Мексикийн булан дахь газрын тос, байгалийн хийг ашиглуулах дуудлага худалдааг сэргээсний зэрэгцээ есдүгээр сард хэд хэдэн шинэ дуудлага худалдаа явуулахыг засаг захиргаанд үүрэг болгожээ.

Бразил улсын ерөнхийлөгчөөр сонгогдсон Луис Инасио Лула да Силва тус улсын экосистемийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын комиссоос ган гачиг, өндөр температурт өртөмтгий хэмээн мэдэгдсэн Амазон мөрөнд онцгой анхаарал хандуулна гэдгээ мэдэгдэв. Колумбын Ерөнхийлөгч Густаво Петро COP27 бага хуралд уламжлалт бус сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт чиглэсэн эрчим хүчний шилжилтийн төлөвлөгөөг зарласан бол Насион Ваюу, Индепаз зэрэг байгууллагууд Колумбын Гуажирад хэрэгжиж байгаа салхины эрчим хүчний хэд хэдэн төсөл уугуул иргэдийн чөлөөт, урьдчилан, мэдээлэлтэй зөвлөлдөх эрхийг зөрчиж байгааг буруутгав.

Бүс нутгийн эрх баригчид өмнө нь Парисын хэлэлцээрт гарын үсэг зурж байсан үүрэг амлалтаа биелүүлээгүй бөгөөд зарим тохиолдолд чулуужсан түлшний төслүүдийг идэвхтэй дэмжиж байв. Бразилын эрх баригчдын хүргүүлсэн үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр нь тус улсын уур амьсгалын өөрчлөлтөд оруулсан хувь хэмжээтэй харьцуулахад хангалтгүй байв. Оны дунд гэхэд Канадын Экспортын хөгжлийн агентлаг Канад болон гадаадад газрын тос, байгалийн хийн салбарт 3.4 тэрбум канад доллар (2.5 тэрбум ам. доллар)-ын хөрөнгө оруулалт

хийжээ. Үүний зэрэгцээ Канад улс чулуужсан түлшний шинэ төслүүдэд төрийн санхүүжилтийг үе шаттайгаар зогсоох төлөвлөгөө гаргажээ.

Эрх баригчид нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг хязгаарлахын тулд яаралтай арга хэмжээ авч, чулуужсан түлшний төслүүдийг санхүүжүүлэхээ зогсоохын зэрэгцээ уугуул иргэд, хүний эрх хамгаалагчдыг байгаль орчны талаарх төрийн бодлогын хүрээнд хамгаалах шаардлагатай. Бүс нутгийн чинээлэг улс орнууд бага орлоготой улс орнуудад уур амьсгалын хямралыг зогсоох санхүүжилтийг яаралтай өргөжүүлж, алдагдал, хохирлыг арилгахад зориулсан нэмэлт санхүүжилт олгох үүрэг хүлээх шаардлагатай.

ДҮРВЭГЧ, ЦАГААЧДЫН ЭРХ

Бүс нутаг дахь хүний эрх, хүмүүнлэгийн ноцтой хямрал нь хамгаалалт хайж эх орноо орхин гарах хүмүүсийн тоог огцом нэмэгдүүллээ. 6 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн сангийн гаргасан мэдээллээр Колумб, Панамын хоорондох Дариенийн сувгаар дамжин гарсан хүүхдийн тоо 2022 оны эхний байдлаар 5000-д хүрсэн нь 2021 оны мөн үеийнхээс хоёр дахин их байна. Венесуэлийн Дүрвэгсэд болон цагаачдыг зохицуулах байгууллагын гаргасан тооцооллоор 2022 оны эцсийн байдлаар 7.13 сая Венесуэлчүүд эх орноо орхин гарсан бөгөөд тэдний 84 хувь нь Латин Америк, Карибын тэнгисийн 17 улсаас хамгаалалт хайж байна. Мөн Куба, Гайтиг орхин гарсан хүмүүсийн тоо сүүлийн жилүүдтэй харьцуулахад ихээхэн нэмэгдэж байгаа бол Венесуэл болон Төв Америкаас дүрвэсэн хүмүүсийн тоо тогтмол нэмэгдсээр байна. Аргентин, Канад, Чили, Колумб, Мексик, Перу, Тринидад ба Тобаго, АНУ зэрэг улсуудад олон улсын хамгаалалтын цогц тогтолцоо дутмаг байгаа нь дүрвэгсэд, цагаачдыг хамгаалалтгүй үлдээж байна.

АНУ-ын холбооны шүүхүүд Цагаачдыг хамгаалах протокол болон АНУ-ын хуулийн 42-р заалтыг дэмжсэн нь Мексикт аюулд өртсөн олон арван мянган орогнол хүсэгчдэд нөхөж баршгүй хохирол учруулсан. Мексикийн эрх баригчид АНУ-ын эрх баригчидтай энэ чиглэлээр хамтран ажиллаж байгаа нь дүрвэгсдийн эрхийн талаарх олон улсын эрх зүйн үндсэн зарчим болох дүрвэгсдийг аюулд өртөх улс руу буцаахгүй байх зарчмыг зөрчиж байна. АНУ-д эрх баригчид 2022 онд өдөр бүр 34,000 хүнийг баривчлах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн нь цагаачдыг дур зоргоороо, олноор нь баривчлахад хүргэж байна. 2021 оны есдүгээр сараас 2022 оны тавдугаар сарын хооронд АНУ үндэсний болон олон улсын хууль тогтоомжийг зөрчиж эрх зүйн шударга хамгаалалтгүйгээр 25,000 гаруй Гайти иргэдийг албадан гаргажээ. Мексикийн эрх баригчид 281,149 хүнийг ачаалал нь хэтэрсэн цагаачдын хорих төвд саатуулж, Төв Америкаас голдуу 98,299 хүн, түүний дотор хараа хяналтгүй олон мянган хүүхдийг албадан гаргажээ.

Тринидад ба Тобаго улс орогнох эрхийн талаарх үндэсний хууль тогтоомжгүй Америк тивийн цөөхөн орны тоонд орж байна. Тус улсын Венесуэлийн орогнол хүсэгчдийг нутаг буцаах, шилжүүлэн өгөх, хүнлэг бусаар саатуулах зэрэг үйл ажиллагаа нь ноцтой түвшинд хүрлээ хэмээн НҮБ санаа зовниж байна. Түүнчлэн Венесуэлийн дүрвэгсэд Колумб, Эквадор, Перу, Тринидад, Тобаго зэрэг улсад жендэрт суурилсан хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхалтад өртдөг бөгөөд эрх баригчид хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид амьдрах эрхийг нь баталгаажуулж чадаагүй хэвээр байна. Перу улсад улс төрийн орогнол хүссэн өргөдлийг хүлээн авах, шийдвэрлэх процесс түр зогссон хэвээр байна.

Чили улсын эрх баригчид гадаадын иргэдийг олон улсын хамгаалалтад авах шаардлагатай эсэх, эсвэл нутаг буцаах нь эрсдэлтэй эсэх талаар дүгнэлт хийлгүйгээр шууд хөөн гаргах ажлыг дахин эхлүүллээ. Аргентинд хууль тогтоогчид орогнол хүсэгчид болон дүрвэгсэдэд боловсрол, ажил хөдөлмөр, эрүүл мэнд гэх мэт үндсэн эрхүүдийг илүү хүртээмжтэй болгох зохицуулалтыг баталж чадаагүй юм.

Эрх баригчид дүрвэгсэд, цагаачдыг хууль бусаар албадан гаргаах нэн даруй зогсоож, баривчлахаас зайлсхийж тэдэнд олон улсын хамгаалалтыг эдлүүлэхэд анхаарах шаардлагатай.

АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Ази-Номхон далайн бүс нутагт хүний эрхийн бага боловч найдвар төрүүлэхүйц дэвшил гарлаа. Хэд хэдэн улсад эмэгтэйчүүд болон ЛГБТИ хүмүүсийн эрхийг хангахад ахиц гарсан. Пакистанд эрүү шүүлтийг гэмт хэрэгт тооцох шинэ хууль батлагдсан бол Папуа Шинэ Гвинейд цаазаар авах ялыг халжээ. Гэвч хүний эрхийн ерөнхий дүр зураг бүрхэг хэвээр. Мьянмар дахь хурцадсан зэвсэгт мөргөлдөөний хор уршгийг энгийн иргэд амсаж байна. Талибуудын засаглалын Афганистан дахь хүний эрхэд үзүүлэх нөлөө нь охид, эмэгтэйчүүдийн эрхэд мэдэгдэхүйц ухралт авчирлаа. Цар тахлын нөлөөгөөр даамжирсан эдийн засгийн хямрал, эдийн засгийн алдаатай менежмент, бүс нутаг доторх болон гаднах зэвсэгт мөргөлдөөн нь эдийн засаг, нийгмийн эрхэд ноцтой нөлөөлөв. Афганистан, Лаос, Шри Ланка зэрэг улсын эдийн засгийн хямрал нь хоол хүнс, эрүүл мэнд, амьжиргааны зохистой байдлыг алдагдуулав. Бүс нутгийн хэд хэдэн улсын эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд тавьсан хязгаарлалтыг чангатгаж, шүүмжлэгчдийг дур мэдэн цагдан хорих, баривчлах зэргээр эсэргүүцсэн үзэл бодлыг үл тэвчих байдал улам нэмэгдэв. Шударга бус байдал, хомсдол, ялгаварлан гадуурхалтыг эсэргүүцсэн иргэд бүс нутгийн өнцөг булан бүрт жагссан хэдий ч Бангладеш, Энэтхэг, Индонез, Балба, Пакистан, Шри Ланка, Тайланд зэрэг улсад жагсагчдын эсрэг хүч хэтрүүлсэн, зарим тохиолдолд хүний амь насанд аюултай хүч хэрэглэжээ. Хятад, Филиппинд үүсээд буй ноцтой асуудлуудыг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл үр дүнтэй шийдвэрлэж чадахгүй байгаа нь ял шийтгэлгүй үлдэх боломжийг нэмэгдүүлж байна. Нийгмийн цөөнх, охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүс, уугуул иргэдийн эсрэг ялгаварлан гадуурхах үзлийн тогтсон хэв маяг амь бөхтэй байсаар байна. Афганистан, Мьянмарт цаазаар авах ялыг дахин сэргээсэн нь мөн томоохон ухралт боллоо.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

Эдийн засгийн хямрал нь амьжиргааны зохистой түвшинд аж төрөх, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг хүний эрхэд ноцтой нөлөөлсөн. Есдүгээр сард Шри Ланка улсад инфляцын түвшин 73%-иас давж, хоол хүнс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон бусад үндсэн хэрэгцээг хангах боломжгүй болсон нь ялангуяа, эмэгтэйчүүд болон Малайяха Тамил үндэстний цөөнх голдуу өдрийн цалинтай ажилчдад ихээхэн нөлөөлөв. Мөн Лаос дахь үнийн өсөлт үндсэн бараа бүтээгдэхүүний хүртээмжийг алдагдуулав. Афганистанд эдийн засгийн хямралын улмаас хүн амын 97% ядууралд өртөж, өрхийн дийлэнх нь өлсгөлөнд нэрвэгдсэний улмаас, амь зуулгаа залгуулахын тулд буруу арга ашиглах нь нэмэгджээ. Талибанчууд арван хоёрдугаар сард хүмүүнлэгийн болон бусад төрийн бус байгууллагуудад эмэгтэйчүүд ажиллахыг хориглосны дараа нөхцөл байдал улам дордож байна. Энэ шийдвэр эмэгтэйчүүдийн амьжиргаагаа залгуулах боломжийг хязгаарлаж, өмнө нь эмэгтэй ажилчдын үзүүлж байсан үйлчилгээг авах боломжгүй болгосон.

Орон байртай байх эрхийн хамгаалалт хангалтгүй, орон сууцны эвдэн сүйтгэсний улмаас олон мянган хүн орон гэргүй болж, гачигдал, эрсдэлд өртжээ. Балба улсын засгийн газар орон байртай байх эрхийг хангалттай баталгаажуулж чадаагүй 2018 оны орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай шаардлага, уриалгыг хүлээн аваагүйгээс гадуурхагдсан болон албан бус сууринд амьдардаг олон зуун гэр бүл нүүлгэн шилжүүлэгдэх эрсдэлд аж төрж байна. Энэтхэгийн эрх баригчид нийслэл Шинэ Дели болон хэд хэдэн мужийн гол төлөв Исламын шашинтнуудын эзэмшиж байсан орон сууц болон бусад хувийн өмчийг хууль бусаар нураасан нь нийгэм хоорондын

мөргөлдөөнд оролцсон гэх асуудлыг үүсгэж байна. Камбож, Монголд хот дахин төлөвлөлтийн төслийн улмаас олон өрх орон гэргүй болж, амьжиргаагаа алджээ.

Засгийн газар аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн баталгааг хангах үүрэгтэй.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн цөөн бус тооны улсын засгийн газар эсэргүүцэл, шүүмжлэлийг нухчин дарж, хяналтаас зайлсхийхийн тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд заналхийлсэн хэвээр байна.

Хэвлэлийн эрх чөлөөнд халдах байдал олон оронд өргөн тархжээ. Афганистан улсад Талибанчуудыг шүүмжилсэн сэтгүүлчдийг дур зоргоор баривчлах, цагдан хорихоос гадна эрүүдэн шүүх болон бусад зүй бус хэлбэрээр харьцаж байна. Бангладеш улсад сэтгүүлчид нийтэлсэн мэдээллийнхээ төлөө бие махбодын халдлагад өртөж, шүүхийн дарамт, бусад хэлмэгдүүлэлтэд өртсөн хэвээр байна. Мэдээлэл хамгаалах хуулийн төсөл нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улам бүр хязгаарлах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Пакистанд хэвлэл мэдээллийн ажилтнууд сэтгүүлчдийн нэгэн адил дарамт шахалтад өртөх нь нэмэгдсэн бөгөөд үндэслэлгүйгээр баривчлагдсаар байна. Филиппиний шинэ засаг захиргаа хэвлэл мэдээллийнхэнд тулгараад байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэж чадсангүй. Энэ оны сүүлийн хагаст дор хаяж хоёр сэтгүүлч амь насаа алдсан бол шүүхийн дарамт, хараат бус хэвлэл мэдээллийн байгууллагуудын вэбсайтуудыг хаах зэрэг үйлдэл гарсан хэвээр байна.

Хятад улсад цахим орчныг цензурдэх, тандах нь улам гаарчээ. Шинжааны уйгурууд болон бусад Исламын шашинт үндэстний цөөнхийн эсрэг үйлдсэн байж болзошгүй олон улсын эрх зүйн гэмт хэрэг, бусад хүний эрхийн ноцтой зөрчлийг баримтжуулсан НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын тайланг нийтлэхийг зогсоохыг оролдох зэргээр тус улсын засгийн газар хүний эрхийн талаарх олон улсын хэмжээний шүүмжлэлд өртөхөөс зайлсхийж байна. Мөн Энэтхэгийн засгийн газар хүний эрх хамгаалагчдын олон улсад зорчих эрхэд нь хориг тавих зэргээр тус улсад өрнөж буй хүний эрхийн асуудлыг гадаадад хэлэлцэхээс урьдчилан сэргийлэхээр оролдож байна. Сөрөг хүчний намуудын шүүмжлэлийг хязгаарлахын тулд парламентын хэлэлцүүлэгт ашиглахыг хориглосон ердийн үгийн жагсаалт гаргасан нь хууль бус, ер бусын алхам боллоо.

Мьянмарт цэргийн эрх баригчид цахим болон цахим бус хяналтыг эрчимжүүлэхийн зэрэгцээ мэдээлэл авах эрхийг хязгаарлаж, томоохон хотуудад нүүр царай таних хяналтын камер ашиглаж, интернэт болон харилцаа холбоог үндэсний хэмжээнд тогтмол хааж байна. Хойд Солонгост засгийн газрыг шүүмжлэхийг бүрэн хориглосон хэвээр байв.

12 дугаар сард Индонези улсад ерөнхийлөгч болон бусад албан тушаалтан, төрийн байгууллагуудыг доромжилсон үйлдлийг гэмт хэрэгт тооцсон шинэ эрүүгийн хуулийг баталсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд томоохон цохилт боллоо. Мальдив улсын хууль тогтоох байгуулагаас сэтгүүлчдийг мэдээллийн эх сурвалжаа ил болгохыг шаардах агуулга бүхий хууль баталлаа. Мальдивын засгийн газар уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байсан ч хүчтэй шүүмжлэлд өртөв.

Вьетнамын эрх баригчид шүүмжлэгчдийг дур мэдэн баривчлах, ялах зорилгоор одоогийн эрүүгийн хуулиа ашигласаар байна. "53 дугаар тогтоол"-оор технологийн компаниудыг хэрэглэгчийн мэдээллийг хадгалж, тухайн мэдээллийг эрх баригчдад хуваалцахыг шаардаж байгаа нь шүүмжлэгчдийг дуугүй байлгах шинэ хэрэгсэл болж магадгүй юм. Малайз, Балба улсад комеди хийснийхээ төлөө иргэд хорих ял эдэлж байна.

Засгийн газар хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэж, аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л мөрдөн байцаалт, ял шийтгэх ажиллагааг таслан зогсоож, хууль ёсны үзэл бодлоо илэрхийлэхийг гэмт хэрэгт тооцсон, эсхүл түүнийг хязгаарлахад ашиглаж болох хуулийн заалтуудыг хүчингүй болгох ёстой.

ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газар шүүмжлэлт үзэл бодлыг нухчин дарахыг хичээх тусам бүс нутгийн хэмжээнд хүмүүс шударга бус байдал, ялгаварлан гадуурхалтыг эсэргүүцэх эрхээ эдлэх болсон нь эрх баригчид зайлшгүй шаардлага үүсээгүй байхад хүч албадлагыг байнга хэтрүүлэн хэрэглэж, дур зоргоороо баривчлах, цагдан хорих, гэмтэл учруулах, зарим тохиолдолд үхэлд хүргэх эрсдэлийг бий болгож байна.

Шри Ланкад цагдаа нар эдийн засгийн хямралыг эсэргүүцсэн тайван жагсаалд оролцсон иргэдийн эсрэг галт зэвсэг, нулимс асгаруулагч хий, усан буу ашигласны улмаас хүний амь нас эрсдэж, шархаджээ. Бангладешийн цагдаа нар оюутнууд болон ажилчдын эсэргүүцлийн жагсаалыг тараахын тулд байлдааны болон резин сум, дуут гранат, нулимс асгаруулагч хий ашиглажээ.

Пакистанд эрх баригчид идэвхтнүүд болон хүчээр алга болгосон хэргийн хохирогчдын гэр бүлийн гишүүдийн оролцсон тайван жагсаалыг хүч хэрэглэн тараажээ. Балбын томоохон зээлдүүлэгчдийн хохирогчдыг цагдаа нар бороохойдож, дур мэдэн саатуулжээ. Энэтхэгийн Жаркханд мужид болсон жагсаалын үеэр 15 настай хүү болон өөр нэгэн жагсагч цагдаад буудуулж амиа алджээ. Индонезийн цагдаа нар Папуа, Баруун Папуа зэрэг газарт болсон жагсаалын үеэр жагсагчдын эсрэг зайлшгүй бус хариу үйлдэл үзүүлж, зарим тохиолдолд амь насанд аюултай хүч хэрэглэжээ.

Хэд хэдэн улсад жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарласан шинэ хууль хэрэгжүүлж байна. Энэтхэгийн Карнатака мужид эсэргүүцлийн жагсаалыг нийслэлийн нутаг дэвсгэрийн нэрлэн заасан тодорхой бүсэд хязгаарлах талаарх шийдвэр гарсан. Индонезийн шинэ эрүүгийн хуулиар зөвшөөрөлгүй жагсаал цуглаан хийхийг хориглосон бол Австрали улсын хэд хэдэн мужид зөвшөөрөлгүй жагсаал цуглаанд оролцсон тохиолдолд торгох, хорих ял оногдуулах шинэ хууль баталжээ.

Түүнчлэн хэд хэдэн улсад эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг улам бүр хязгаарлажээ. Афганистанд хүний эрхийн хараат бус дүн шинжилгээ, тайлагнах орон зай бүхэлдээ үгүй боллоо. Энэтхэг улсад төрийн бус байгууллагуудыг мөнгө угаахтай тэмцэх тухай хууль болон бусад шалтаг, шалтгаанаар дарамталсаар байна. Мьянмар дахь төрийн бус байгууллагууд хууль ёсны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тогтоосон шинэ хязгаарлалтыг дагаж мөрдөөгүй тохиолдолд хорих ялаар шийтгүүлэхээр хуульд тусгажээ.

Камбожид гол сөрөг хүчин болох Камбожийн Үндэсний аврах намыг хориглосон хэвээр байгаа бөгөөд түүний гишүүд болон эрх залгамжлагч Лааны гэрлийн намын гишүүдийг яллах ажиллагаа үргэлжилсээр байна. “Улаан шошго” гэгдэх коммунист бүлгүүдтэй холбоотой хэмээн үзэж иргэд, байгууллагуудыг буруутган дур мэдэн хорих, хууль бусаар алах явдал үргэлжилсээр байна. Монгол улсад хүний эрх хамгаалагчид тагнуулын хэрэгт буруутгагдаж, бусад ийм төрлийн айлган сүрдүүлэлтэд өртөж байна. 2022 онд Хятадын автономит бүс болох Хонг Конгод хууль ёсны төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа гэмт хэрэгт тооцох болсноор айдас, өөрийгөө цензурдах орчин бүрдэж улмаар иргэний нийгмийн орон зай улам бүр хумигдсаар байна.

Засгийн газар тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хүндэтгэж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ёстой. Хүний эрх хамгаалагчдыг хүндэтгэн, тэдэнд ажиллах аюулгүй, таатай орчин бүрдүүлэх ёстой.

ДУР МЭДЭН БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ

Хятадын эрх баригчид хүлээн зөвшөөрөхгүй байгаа ч Шинжаанд олон мянган эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг дур мэдэн хорьж байна хэмээн үздэг. Мөн Хятад дахь Төвдийн идэвхтнүүдийг “салан тусгаарлах үзлийг өдөөсөн” эсвэл “үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн” үйл ажиллагаа явуулсан хэргээр шударга бусаар шүүж, олон жилийн хорих ял оноожээ.

Бүс нутгийн хэмжээнд хүний эрхийн хамгаалагчид, улс төр, байгаль орчны идэвхтнүүд болон бусад хүмүүсийг жагсаал цуглаан хийх эрхээ хэрэгжүүлсэн, засгийн газрын бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн үндэслэлээр дур мэдэн баривчилж, цагдан хорьж байна.

Тайландад 1000 гаруй хүн, тэр дундаа хэдэн зуун хүүхдэд эсэргүүцлийн жагсаалд оролцсон хэргээр эрүүгийн хэрэг үүсгэжээ. Шри Ланкад жагсагчдыг баривчлан, дур мэдэн цагдан хорьж, терроризм болон бусад гэмт хэрэгт буруутган ял оногдуулж байна. Мьянмарт цэргийн дэглэмийг эсэргүүцэгчдийг олноор нь дур мэдэн баривчлах, цагдан хорих ажиллагаа үргэлжилж, 1000 гаруй хүнийг шударга бус шүүхээр шийтгэжээ.

Вьетнамд хүний эрх, газрын эрхийн төлөө тэмцэгчдийг урт хугацаагаар хорих ял оногдуулсан бол Энэтхэгт хүний эрхийг хамгаалагчдыг ямар нэг шүүхийн шийдвэргүйгээр цагдан хорьжээ.

Засгийн газрууд төр, засгийн газрыг шүүмжлэгч болон бусад хүнийг дур зоргоороо баривчлах, цагдан хорих үйлдлээ зогсоож, үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх болон хүний бусад эрхээ тайван замаар хэрэгжүүлсний төлөө хоригдсон хүмүүсийг нэн даруй суллах ёстой.

ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭХ БА ШҮҮХЭД ХАНДАХ ЭРХ

Улс орнуудын эрх баригчид хохирогчдын шүүхэд хандах эрх, үнэнийг мэдэх, хохирлыг барагдуулах эрхийг хангаж чадахгүй байгаа, түүнчлэн олон улсын байгууллагууд тэднийг хамгаалах үүргээ хэт умартаж байгаагаас үүдэн ял шийтгэлгүй үлдэх явдал нэмэгдсээр байна.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Шинжаан дахь Хятадын харгис хэрцгий үйлдлийг нэмэлтээр нотолсон НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын илтгэлийг үл харгалзан нөхцөл байдлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулахаас татгалзсан юм. Түүнчлэн өнгөрсөн онд Филиппинд хар тамхины эсрэг ажиллагааны үеэр цагдаа нарын үйлдсэн аллага эрс нэмэгдсэн ч НҮБ-ын Хүний эрхийн хорооноос уг асуудалд дүн шинжилгээ хийх талаарх НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын бүрэн эрхийг сунгахаас татгалзаж “хар тамхины эсрэг дайн”-ын тоо томшгий олон хохирогчдоос нүүр бууруулсан юм. Харин Шри Ланкад зэвсэгт мөргөлдөөний үеэр болон дараа нь үйлдэгдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх асуудалд зохих ахиц дэвшил гарахгүй байгаа тул нотлох баримт цуглуулах талаарх НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын бүрэн эрхийг сунгах тогтоолыг Хүний эрхийн зөвлөл гаргасан.

Афганистанд ял шийтгэл завших байдал улам бүр газар авч байна. Балбад 1996-2006 оны дотоодын зэвсэгт мөргөлдөөний үеэр хүний эрхийн ноцтой зөрчлийн улмаас хохирсон олон арван мянган хүний шүүхэд хандах эрхийг хэрэгжүүлэхэд ямар нэгэн ахиц дэвшил гарсангүй

Гэмт хэрэг үйлдсэн гэх хүмүүсийг яллах шүүх хуралдаан ихэвчлэн зөрчил, дутагдалтай байсаар байна. Тухайлбал, 2014 онд Папуан ахлах сургуулийн дөрвөн сурагчийг хууль бусаар алсан хэрэгт буруутгагдсан Индонез улсын цэргийн командлагчийг цагаатгасан шийдвэр гаргасан шүүх хуралдаан үнэн зөв явагдсан эсэх талаарх ноцтой асуудал үүссэн.

Засгийн газрууд олон улсын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг болон хүний эрхийг ноцтой зөрчсөн бусад хүчирхийллийг нягт нямбай, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод мөрдөн шалгах, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдийг шударга шүүхээр шүүн шийтгэх замаар ял завших асуудлыг шийдвэрлэх ёстой. Олон улсын мөрдөн байцаалт, шүүхийн үйл явцад бүрэн дүүрэн хамтын ажиллагааг өргөжүүлэх ёстой.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Мьянмарын зэвсэгт хүчин ялгаварлахгүйгээр, эсхүл онилж энгийн иргэд болон иргэний объектуудын эсрэг газрын болон агаарын довтолгоогоо эрчимжүүлж, тосгодыг тонон дээрэмдэж шатаасан, олон зуун хүнийг хөнөөж, олон мянган хүнийг албадан нүүлгэн шилжүүлсэн дайны гэмт хэрэг үйлдсэн. Мөн олон улсын хуулиар хориглосон цацардаг тэсрэх бөмбөг, газарт булагч тэсрэх мина ашигласан болохыг баримтжуулсан.

Афганистанд мөн дайны гэмт хэрэг үйлдэгдсэн. Талибанчууд хуучин засаг захиргаа, аюулгүй байдлын хүчний гишүүдийг хэлмэгдүүлэн хөнөөх кампанит ажлаа үргэлжлүүлж, Үндэсний эсэргүүцлийн фронт болон бусад зэвсэгт сөрөг хүчний бүлэглэлтэй холбоотой гэх хүмүүсийг дур зоргоороо баривчилж, шүүхээс гадуур цаазалж, эрүүдэн шүүжээ.

Исламын улс-Хорасан бүсэд (IS-KP) үндэсний цөөнх, шашны бүлгүүд рүү чиглэсэн дайралт, тэр дундаа Хазара, Сикх бүлгийн шашны болон боловсролын байгууламжуудыг бөмбөгдсөн Афганистан дахь ноцтой зөрчлийн хариуцлагыг зэвсэгт бүлэглэлүүд хүлээсэн юм. Мьянмарт зарим бүлэглэлүүд явган цэргийн эсрэг хориотой мина эсвэл гар хийцийн тэсрэх төхөөрөмж ашиглажээ. Энэтхэгийн Жамму ба Кашмир бүсэд зэвсэгт бүлэглэлүүд Хинду үндэстний цөөнх болох 19 энгийн иргэнийг хөнөөсөн гэх мэдээлэл байна.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүх тал олон улсын хүмүүнлэгийн хуулийг дагаж мөрдөх ёстой. Ялангуяа энгийн иргэд эсвэл иргэний дэд бүтцийн эсрэг шууд халдлага, эсхүл ялгаварлахгүйгээр халдах явдлыг зогсоох ёстой.

БИЗНЕСИЙН ХАРИУЦЛАГА

Мьянмарын энгийн иргэдийн эсрэг цэргийн агаарын цохилт хийхэд ашиглаж байж болохуйц онгоцны түлшийг импортлох, түгээхэд бизнес эрхлэгчдийн гүйцэтгэсэн үүргийг баримтжуулсан Эмнести Интернэшнлийн тайлангийн дараа Пума Энержи болон бусад гадаадын бизнес эрхлэгчид Мьянмар дахь бизнесийн үйл ажиллагаагаа орхиж, түр зогсоож байгаа тухайгаа зарлан мэдэгдэв.

Бизнесүүд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үүргээ нухацтай авч үзэн хамгаалахгүй бол хариуцлага хүлээх шаардлагатай болохыг Эмнести Интернэшнл онцлон тэмдэглээд Мета (хуучнаар Facebook) алгоритмууд болон бизнесийн үйл ажиллагаа нь 2017 онд Мьянмарт хүний эрхийг ноцтой зөрчил үйлдэгдэхэд ихээхэн нөлөөлсөн болохыг тогтоожээ.

Корпорациуд өөрсдийн болон түншүүдийнх нь үйл ажиллагаа хүний эрхийг зөрчих, эсхүл, зөрчилд хувь нэмэр оруулахгүй байхыг баталгаажуулахын тулд хүний эрхийн зохих шалгалтыг хийж байх шаардлагатай. Тэд мөн аливаа болзошгүй хүчирхийллийг бууруулах арга хэмжээ авах ёстой.

ШАШИН ШҮТЭХ, ИТГЭЛ ҮНЭМШИЛТЭЙ БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хэд хэдэн улсад шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө заналхийлэлд өртсөн хэвээр байна. Исламын шашинтнуудыг шашин шүтэх эрх чөлөөгөө эдэлснийх нь төлөө баривчилж, шийтгэсээр байна. Энэтхэгийн Карнатака мужийн засгийн газар бусад мужуудын нэгэн адил эхнэр, нөхөр, ихэвчлэн Хинду эмэгтэйчүүдийг хамаатан садан болон бусад хүний тулгалтаар шашнаа сольж гэрлэсэн гэрлэлтийг гэмт хэрэгт тооцох хууль баталжээ. Түүнчлэн Карнатака муж улсын сургуулиудад охидыг хижаб өмсөхийг хоригложээ.

Бурхныг үл хүндэтгэсэн зөрчил үйлдсэн этгээдэд Пакистанд цаазаар авах ял

оноож, ихэвчлэн дүүжлэн гүйцэтгэж байгаа бөгөөд Хинду, Христийн шашинт, Сикх охид эмэгтэйчүүдийг хүчээр Исламын шашинд оруулсан явдал үргэлжилсээр байна.

Хятадад шашны удирдагчид болон Фалун Гун шашинтнуудыг дур зоргоороо цагдан хорьж, баривчилсаар байгаа бол Шинжаан дахь Уйгур, казахууд болон голдуу Исламын шашинт үндэстний цөөнхийн хүмүүсийг дарлах явдал үргэлжилсээр байгаа нь тэдний шашин шүтлэг, соёлын онцлог устгах аюул заналхийллийг бий болгож байна.

Засгийн газар шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг ялгаварлан гадуурхахгүйгээр бүрэн хамгаалах, дэмжих, баталгаажуулах эрх зүйн болон бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авах ёстой.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Хятад, Индонези, Папуа Шинэ Гвиней зэрэг хэд хэдэн улсад бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хууль гэх зэрэг охид, эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн шинэ хууль тогтоомжийг баталсан. Энэтхэгийн Дээд шүүх секс ажилчдын нэр төртэй байх эрхийг баталгаажуулсан хоёр шийдвэрээр цагдаа нарт тэднийг дарамтлахаа зогсоохыг үүрэг болгосны зэрэгцээ гэр бүлийн байдлаас үл хамааран бүх эмэгтэйчүүдэд үр хөндөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд одоо байгаа хууль тогтоомжид тодруулга хийв.

Гэсэн хэдий ч бүс нутгийн олон охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх явдал тогтолцооны хувьд бодитоор байсан хэвээр байна. Афганистанд охид, эмэгтэйчүүдийг олон нийтийн амьдрал, орон зайнаас үр дүнтэй гаргахад чиглэсэн шинэ шийдвэрүүд, тухайлбал ТББ-тай хамтран ажиллах, эрэгтэй харгалзагчгүйгээр зорчих, дунд сургууль, их дээд сургуульд суралцах, олон нийтийн цэцэрлэгт хүрээлэнд очих эрхийг хориглосон зэрэг нь нь тэдний эрх, эрх чөлөөг улам бүр хязгаарлаж байна.

Балбад эмэгтэйчүүдийн иргэний харьяаллын тэгш эрхийг үгүйсгэсэн хэвээр байгаа бөгөөд хүчингийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сунгасан ч гомдол гаргах боломжийг хэт богино хугацаагаар хязгаарласан нь амьд үлдсэн хохирогч нарт үр дүнтэй эрх хамгаалал хэрэгжүүлэхэд ихээхэн саад болж байна.

Арван хоёрдугаар сард болсон парламентын сонгуулийн үеэр Фижи дэх эмэгтэйчүүдийн сонгуульд оролцоход тулгардаг хууль эрх зүйн саад бэрхшээл хэвээр байв. Учир нь эмэгтэйчүүд гэрлэснийхээ дараа санал өгөхийг хүсвэл төрсний гэрчилгээн дээрх нэрээ солихыг шаарддаг ялгаварлан гадуурхсан хуулийн талаарх эрх зүйн маргаан эцэслэн шийдэгдээгүй байна. Нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн төлөөлөл доогуур хэвээр байна. Папуа Шинэ Гвинейд 2022 онд сонгогдсон 118 парламентын гишүүний ердөө хоёр нь эмэгтэй байсан, мөн Японы парламентын гишүүдийн 10.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл тулгамдсан асуудал хэвээр байна. НҮБ-ын шинжээчид Мальдивын эрх баригчдад хандан өсөн нэмэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэхийг уриалжээ. Бангладеш улсад эмэгтэйчүүдийг нөхөр болон гэр бүлийн бусад гишүүд нь хүчирхийлсэн, хөнөөсөн олон зуун хэргийг ТББ бүртгэсэн боловч өөр бусад олон тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд ийм гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэх нь өргөн тархсан хэвээр байна. Хэдийгээр гэмт хэрэгт тооцсон хэдий ч Папуа Шинэ Гвинейд охид, эмэгтэйчүүдийг хар шидэнд буруутган хүчирхийлэх явдал гарсаар байна.

Пакистанд эмэгтэйчүүдийг хамтрагч эсвэл гэр бүлийн гишүүд нь хөнөөсөн хэрэг олноор бүртгэгдсэн хэдий ч Үндэсний ассамблей 2021 оноос хойш хүлээгдэж буй гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталж чадаагүй.

Бүс нутгийн улс орны засгийн газрууд охид, эмэгтэйчүүдийг хамгаалах, ялгаварлан гадуурхалтыг эцэс болгох хүчин чармайлтаа эрчимжүүлж, жендэрт суурилсан болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнд ял шийтгэл ногдуулах талаар тодорхой арга хэмжээ авах ёстой.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Япон, Сингапур, Тайвань зэрэг улс ЛГБТИ хүмүүсийн эрхийг хууль ёсоор хүлээн зөвшөөрөх зарим алхмуудыг хийсэн. Сингапурт эрчүүдийн харилцан тохиролцсоны дагуу бэлгийн харьцаанд орохыг гэмт хэрэгт тооцохоос татгалзжээ. Гэсэн хэдий ч Сингапурын засгийн газар ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хориглох үүднээс Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд ерөнхийдөө бүс нутгийн ЛГБТИ хүмүүс Өмнөд Азийн орнуудад хамгийн их эрсдэлтэй бүлгийн нэг хэвээр байна.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооноос Шри-Ланка улсын Эрүүгийн хуульд заасан ижил хүйстний зөвшилцсөн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон заалт нь ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг зөрчиж байна хэмээн үзэж шийдвэр гаргасан хэдий ч засгийн газар тодорхой арга хэмжээ авсангүй. Афганистанд ЛГБТИ хүмүүс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл, Талибуудын дур зоргоороо баривчлах зэрэг бусад зөрчлөөс өөрсдийгөө хамгаалахын тулд нуугдаж амьдрахаас өөр аргагүйд хүрчээ. Хятадын эрх баригчид ЛГБТИ хүмүүсийн эсрэг кампанит ажлаа үргэлжлүүлж, цахим болон цахим бус орчинд ЛГБТИ хөдөлгөөнийг эрс хязгаарлаж, ЛГБТИ контентыг хянан зохицуулж байна. Пакистанд трансжендэр хүмүүсийн эсрэг хүчирхийллийн халдлага, үзэн ядалт, заналхийлэл хэвээр байгаа бөгөөд амь насыг нь хөнөөх явдал бүс нутагтаа хамгийн өндөр байна.

Засгийн газрууд ижил хүйстнүүдийн зөвшилцсөн харилцааг гэмт хэрэг гэж үзэхгүй байх, ижил хүйстний гэрлэлтийг хориглох хууль эрх зүйн хүндэтгэл бэрхшээлийг арилгах зэргээр ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хууль, бодлогыг хүчингүй болгож, ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах, тэднийг аюулгүй, нэр төртэй амьдрах боломжийг олгох арга хэмжээ авах ёстой.

УГСАА ГАРАЛ, КАСТАД ҮНДЭСЛЭСЭН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ

Энэтхэг, Пакистан улсад кастад суурилсан ялгаварлан гадуурхалт тасралтгүй үргэлжилсээр байв. Энэтхэгт Далит, Адивасис нар дээд давхаргын гэм буруутай хүмүүс ямар нэгэн ял шийтгэл хүлээдэггүй кастын хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын хохирогч болж байна. Бангладеш улсад каст, шашин шүтлэг болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглосон хуулийн төслийг өргөн барьсан боловч Хинду үндэстний цөөнхийн эсрэг хүчирхийлэл гарсаар байна.

Камбож, Индонез, Япон, Лаос, Малайз, Балба, Филиппин, Шри-Ланка, Тайланд улсад уугуул иргэд, үндэстэн, шашны цөөнхийн бүлгүүд өргөн хүрээнд ялгаварлан гадуурхалтад өртсөн хэвээр байна. Австралид уугуул иргэд болон Торресийн арлын иргэд эрүүгийн хэрэгт ял шийтгүүлэгчдийн томоохон хувийг эзэлж байна. Шри Ланкад Исламын болон Тамил үндэстний цөөнхүүдийг Терроризмоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу дур зоргоороо баривчилж, олноор нь цагдан хорьж байна. Японд солонгос үндэстнийг үзэн ядах сурталчилгаа цахим орчинд үргэлжилсээр байсан бөгөөд тэднийг Ерөнхий сайд асан Шинзо Абэгийн амийг хөнөөсөн хэрэгт буруутгаж байв.

Балбад үндэстний цэцэрлэгт хүрээлэн, хамгаалалтын бүс байгуулах явцад өвөг дээдсийнхээ газар нутгаас хөөгдсөн уугуул хүмүүс газаргүй болсны зэрэгцээ албан бус сууринаас нүүлгэн шилжүүлэгдэх эрсдэлд өртөж байна. Малайзын эрх баригчид далан барих ажилд зам гаргах зорилгоор Келантан мужийн уугуул хүмүүсийг хүчээр нүүлгэн шилжүүлсэн бол Камбожи улсад хууль бусаар мод бэлтгэх үйл ажиллагаа нь тэнд амьдарч байгаа уугуул хүмүүсийн амьжиргаа, соёлд заналхийлсээр байна.

Засгийн газрууд үндэс угсаа, шашин шүтлэг, кастын ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтын гэмт хэргийн хохирогчдод шүүхэд хандах боломжийг олгож, эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь ялгаварлан гадуурхалтыг арилгах, үзэн ядалттай тэмцэх явдлыг цахим болон цахим бус орчинд өргөжүүлэх цогц хөтөлбөрүүдийг боловсруулах ёстой.

ЭРҮҮ ШҮҮЛТ, БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Хоригдлуудыг эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах нь улс орнуудад энгийн үзэгдэл хэвээр байгаа бөгөөд эрүү шүүлтийн улмаас нас барсан тохиолдол дор хаяж арав гаруй улсад бүртгэгджээ. Арван жилийн турш үргэлжилсэн тэмцлийн үр дүнд Пакистан улс эрүүдэн шүүхийг гэмт хэрэгт тооцох тухай хуулийг эцэслэн баталсан ч хоригдлуудыг эрүүдэн шүүсэн, бусад зүй бусаар харьцсан тухай мэдээллүүд гарсаар байна. Монгол улсад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болсон ч цагдан хорих газарт эрүүдэн шүүсэн хэрэг гарсаар байна. Балбад мөн л “хэрэг хүлээлгэн мэдүүлэг” авахын тулд урьдчилан хорих газарт эрүүдэн шүүсэн тухай мэдээлэл гарсан хэвээр байгаа хэдий ч 2017 онд эрүүдэн шүүхийг гэмт хэрэгт тооцсон хуулийн дагуу ял шийтгэл хүлээлгэсэн тохиолдол гарсангүй.

Бангладеш улсад 2022 оны эхний есөн сарын байдлаар хорих газарт нас барсан 54 тохиолдол бүртгэгджээ. Мьянмарт цагдан хоригдож байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай мэдээллүүд гарсан бөгөөд жилийн хугацаанд олон зуун хүн баривчлагдаж нас баржээ. Хятад, Хойд Солонгос, Вьетнам зэрэг бусад улсад эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцсан тухай мэдээлэл бүртгэгдсэн.

Индонезийн Аче мужид олон тооны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг ташуурдсан байна. Талибанчууд засгийн эрхэнд эргэн ирсний дараа олон нийтийн өмнө ташуурдах шийтгэлийг Афганистанд мөн дахин хэрэглэж эхэлсэн.

Улс орнууд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах үйлдлийг хориглож, гэмт хэрэгт тооцож, хүмүүсийг хамгаалах, хүчирхийллийн эдгээр хэлбэрээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах ёстой. Ийм зүйл гарсан тохиолдолд муж улсууд гомдлыг шалгаж, буруутай хүмүүст хариуцлага тооцож, хохирогчдод арга хэмжээ авах ёстой.

Улс орнууд эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хүмүүсийг хамгаалах, хүчирхийллийн эдгээр хэлбэрээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ ЧАДСАНГҮЙ

Үерийн гамшиг, хэт халалт, үхлийн аюултай хар салхи, далайн эргийн элэгдэл зэрэг нь бүс нутгийн цаг уурын эмзэг байдлыг илтгэж байна. Гэвч бэлэн байдал, дасан зохицох байдал хангалтгүй хэвээр бөгөөд хамгийн ядуу, хамгийн гадуурхагдсан хүмүүс үр дагаврыг нь тэргүүн ээлжинд амсаж байна. Пакистанд хэт халуун, ган гачиг болон дараа нь тохиосон аймшигт үерийн улмаас 750,000 орчим хүн орон сууц, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжгүй болжээ. Энэтхэгт тариаланчид, гудамжны худалдаачид, тогтмол цалингүй хүмүүс болон бусад ажилладаг ажилчид урьд тохиож байгаагүй хэт халалт болон агаарын бохирдлыг үр дагаварт өртөж байна. Бангладеш улсад уур амьсгалын өөрчлөлт, ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэйгээр далайн эргийн баруун өмнөд бүс нутгаас гаралтай Далитууд болон бусад гадуурхагдсан бүлгүүдэд цэвэр ус, ариун цэврийн байгууламж хүртээмжгүй байна.

Бодитой эрсдэлийг үл харгалзан бүс нутгийн олон муж, тэр дундаа томоохон улсуудын нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах зорилтууд нь дэлхийн дундаж температурын өсөлтийг 1.5°C-аас доош байлгахад хангалтгүй хэвээр байгаа бөгөөд баримталж буй бодлогууд нь дээрх зорилтыг хангахад нийцэхгүй байна. Япон улс дэлхийн газрын тос, байгалийн хий, нүүрсний төслүүдийг үргэлжлүүлэн санхүүжүүлж, нүүрсээр ажилладаг шинэ цахилгаан станц барихаар төлөвлөж байгаа нь онцгой анхаарал татаж байна. Хятад улс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих амлалт өгсөн хэдий ч нүүрсний үйлдвэрлэлээ нэмэгдүүлжээ. Өмнөд Солонгосын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх төлөвлөгөө нь 2030 он гэхэд нүүрсийг үе шаттайгаар хэрэглээнээс гаргах зорилгод нийцэхгүй байна.

Бүс нутгийн улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилт, бодлого нь дэлхийн дундаж дулаарлыг бууруулахад нийцэж байгаа эсэхийг нэн даруй хянаж үзэх ёстой. Гамшгийн бэлэн байдал, дасан зохицох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд тэргүүн ээлжинд өртөх нийгмийн гадуурхагдсан, эрсдэлтэй бусад бүлгийг хамгаалах шаардлагатай. Бүс нутгийн чинээлэг улс орнууд бага орлоготой улс орнуудын уур амьсгалын санхүүжилтийг яаралтай нэмэгдүүлж, алдагдал, хохирлыг арилгахад зориулж нэмэлт санхүүжилт олгох үүрэг хүлээх ёстой.

ДҮРВЭГЧ, ЦАГААЧДЫН ЭРХ

Дүрвэгсэд, орогнол хүсэгчид ялгаварлан гадуурхалт, нутаг буцаах өндөр эрсдэлд амьдарсан хэвээр байна.

Мьянмараас ирсэн Рохинжа дүрвэгсдийн бэрхшээл шийдэгдээгүй хэвээр байна. Бангладеш улсад Рохинжа хүүхдүүдийн боловсролын хүртээмж тодорхой хэмжээгээр сайжирсан хэдий ч ойролцоогоор 100,000 хүүхэд сургуульд хамрагдаагүй байна. Малайзад Рохинжа болон Мьянмараас ирсэн бусад дүрвэгсдийг тодорхойгүй хугацаагаар цагдан хорьсон хэвээр байгаа бөгөөд хэд хэдэн хүн зугтаах үедээ нас баржээ. Цагаачдыг саатуулах төвийн нөхцөл байдал муу, зүй бусаар харьцдаг бөгөөд Индонезийн олон иргэнийг нас барсан гэсэн мэдээлэл байна.

Дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийг саатуулдаг практик Австрали, Япон, Хятадын засаг захиргааны тусгай бүс Хонгконгод үргэлжилсэн хэвээр байна. Өмнөд Солонгост цагдан хорих төвд гадаадын иргэдтэй зүй бус харьцсан тухай мэдээлэл гарчээ. Шинэ Зеландад хийсэн хөндлөнгийн шалгалтаар цагаачдыг саатуулах тогтолцоо нь «дур мэдэн саатуулах тогтолцоо» болохыг тогтоож, орогнол хүсэгчдийг цагдан хорих газарт хорихыг зогсоохыг зөвлөжээ.

Мөрдлөг хавчлагаас дүрвэн эх орноо орхиж явсан Афганчуудыг хөрш зэргэлдээ улс орнууд нутаг буцаасаар байна. Мьянмар дахь хүний эрхийн нөхцөл байдал хүнд байгаа хэдий ч Малайзын эрх баригчид олон мянган дүрвэгсдийг албадан гаргажээ.

Засгийн газрууд орогнол хүсэгчдийг цагаачлалын эрх зүйн байдлаас нь хамааран цагдан хорих явдлыг зогсоож, олон улсын хамгаалалт хүсэх боломж олгож, хавчлагад өртөж болзошгүй улс руу нь албадан буцаахгүй байх шаардлагатай.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Папуа Шинэ Гвинейн засгийн газар цаазаар авах ялыг халсан. Афганистан, Мьянмар, Сингапурт цаазаар авах ялыг дахин хэрэглэв. Сингапурт цаазаар авах ялтай хүмүүсийг өмгөөлж буй хуульчид айлган сүрдүүлэлт, дарамтад өртжээ.

Цаазаар авах ялыг хадгалан үлдсэн улс орнууд уг ялыг бүрэн халах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЕВРОП БОЛОН ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2022 он Европ болон Төв Азийн бүсийн хувьд Орос улсаас Украин улсад цэргийн довтолгоо хийсэн, дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн, дэлхийн 2 дугаар дайнаас хойш Европт хамгийн том дүрвэгсдийн хөдөлгөөнийг өдөөсөн жил гэдгээр түүхэнд бичигдлээ. Орос улс хууль бус бүслэлтийн тактик хэрэглэж, эрчим хүчний дэд бүтэц, иргэдийн өмчид халдсаны улмаас олон мянган энгийн иргэд шархдаж, амь насаа алдаж, үндсэн хэрэгцээт зүйлийн гачигдалд орсон.

Украин улс даяар 7 сая орчим хүн орон гэрээсээ дайжсан бол 5 сая хүн Европын улс орнууд руу, 2,8 сая орчим хүн Орос, Беларусь улс руу дүрвэжээ. Европын Холбоо дүрвэгсдийг хүлээн авсан нь сайшаалтай хэдий ч Украйнаас дүрвэж буй зарим ангиллын хүмүүс, тухайлбал хар арьстнууд, түр оршин суух зөвшөөрөлтэй харьяат бус хүмүүс, зохих хамгаалалт авахад хүндрэл бэрхшээлтэй тулгарсан Рома хүмүүсийг хамруулаагүй нь ялгаварласан хэрэг юм. Украины ихэнх хүмүүсийг найрсгаар хүлээн авсан нь Европын гадаад хил дээрх бусад дүрвэгсэд, цагаачдыг хүч хэрэглэн хүлээн авахаас татгалзах, тэднийг хүчирхийлдэг байдлаас эрс ялгаатай байв. Энэхүү давхар стандарт нь ЕХ-ны гадаад хилийн бодлого, практикт арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл амь бөхтэй байгааг илтгэж байна. Европын олон орон Оросын иргэдийн эсрэг хилийн хатуу хязгаарлалт тавьсан бөгөөд тэдний ихэнх нь цэргийн дайчилгаанаас зугтахыг хүссэн иргэд байлаа.

Дайны нийгэм, эдийн засгийн үр дагавар дэлхийн хэмжээнд сөргөөр нөлөөлсөн бөгөөд ялангуяа дэлхийн өмнөд хэсэгт үр тариа, бордооны экспорт тасалдсан нь хүнд цохилт болов. Европын улс орнуудад эрчим хүчний үнэ огцом нэмэгдэв. Оны эцэс гэхэд Европын олон улс амьжиргааны өртгийн хямралд өртөж, инфляцын түвшин урьд байгаагүй хэмжээнд хүрсэн нь нийгмийн эмзэг бүлгийнхэнд ихээхэн нөлөөлсөн. Инфляцын түвшин Молдав улсад 30%, Турк 64% давжээ. ОХУ-ын газрын тос, байгалийн хийн хараат байдлаас зайлсхийх улс орнуудын оролдлого нь уур амьсгалын хямралыг даван туулах алхмуудыг сулруулав.

Дайн нь бүс нутгийн улс төрийг өргөн хүрээнд дахин зураглахад хүргэв. Беларусь улс гадаад бодлого болон цэргийн бодлогоо ОХУ-ын бодлоготой ихээхэн нийцүүлж, Оросын түрэмгийллийн үйлдэлд хамтран оролцов. Энэхүү дайн нь Беларусь болон Орост илүү их хэлмэгдүүлэлт, хүндрэл бэрхшээл, олон улсын тусгаарлалтад хүргэсэн бөгөөд Орос улсыг Европын зөвлөлийн гишүүнчлэлээс гаргаж, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнчлэлээс түдгэлзүүлэхэд хүргэсэн. ОХУ-ын энхийг сахиулах үүрэг суларснаар Нагорно-Карабах бүсийн мөргөлдөөн дахин хурцадлаа.

Дайн болон Оросын бодлого Баруун Балканы хойгийг тогтворгүй болгож, Серб болон Косовогийн зөрчилдөөнийг улам бүр хурцатгах эрсдэлийг бий болгов. Энэ нь Европын холбооны өргөжих бодлогод шууд бусаар нөлөөлж, Европын Холбоонд нэгдэн орох шалгуурыг хангаагүй хэдий ч Босни Герцеговинад «болзолт» нэр дэвшигчийн статус олгосон. Түүнчлэн Европын Холбоо Украин, Молдав зэрэг улсын гишүүнээр элсэх хэлэлцээг эхлүүлэхийг зөвшөөрсөн ч шинэчлэл, өөрчлөлт нь зогсонги байдалд орж, зарим ухралт хийгдсэн Гүржийн гишүүнээр элсэх хүсэлтэд ахиц гарсангүй.

Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизмын хувьд ОХУ-ын хориг тавих бүрэн эрх нь ЕАБХАБ болон НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн үйл ажиллагааг зогсонги байдалд оруулж, мөргөлдөөнийг зөвхөн хөндлөнгөөс

ажиглах идэвхгүй үүрэгтэй болгов. Гэвч Олон улсын эрүүгийн шүүх урьд өмнөхөөс илүү шуурхай үйл ажиллагаа явуулж, гуравдугаар сарын 2-нд Украины нөхцөл байдалд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах болсноо зарлав.

Украин дахь Оросын дайн нь өмнөх жилүүдийн хүний эрхийн ухралтуудыг хурцатгаж, аюулгүй байдал, эрх тэгш байдлыг үгүйсгэн, дарангуйлагч хүчнийг өдөөж, үндсэн эрх чөлөөг цаашид боомилох нөхцөлийг бий болгов. Эдгээр нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, өөр улс үндэстнийг үзэн ядах, эмэгтэйчүүдийг дорд үзэх, ижил хүйстэн хүмүүсийг үзэн ядах үзэл санааг илэрхийлэх, хэрэгжүүлэх байдлыг улам өдөөж байна. Казахстан, Тажикстан улсад жагсагчдыг харгис байдлаар нухчин дарсан нь эрх баригчид хүч этрүүлэн хэрэглэсээр байгааг илтгэж байна.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Орос улс Украин руу довтолсон нь хүний эрх, хүмүүнлэгийн болон нүүлгэн шилжүүлэлтийн томоохон хямралыг үүсгэсэн.

Мөрдөн шалгагчид Оросын цэргийн хүчнийхний үйлдсэн дайны болон хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэгт тооцогдох хэдэн мянган үйлдлийг баримтжуулсан. Эдгээрт, шүүхээс гадуур цаазлах болон бусад хууль бус аллага, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах, хүн амыг албадан шилжүүлэх, хориглосон зэвсэг хэрэгсэл хэрэглэх, бэлгийн хүчирхийлэл, сургууль болон эмнэлгүүдийг довтолгооны бай болгох гэх зэргийг дурдаж болно. ОХУ энгийн иргэдийн эсрэг бүслэлт хийх тактик хэрэглэж, энгийн иргэдийн ялгахгүйгээр дайралт хийж, өвлийн улиралд Украины эрчим хүчний дэд бүтцийг онилсон нь энгийн иргэдийн зовлонг дээд хэмжээнд хүргэлээ. Мөргөлдөөний оролцогч талууд дайны олзлогсодтой зүй бус харьцаж, шүүхээс гадуур цаазалж болзошгүй нөхцөл байдалд байна.

2020 онд өрнөсөн Армени-Азербайжаны мөргөлдөөний үеэр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдлүүдийг шалгах, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдэд хуулийн хариуцлага хүлээлгэх ажиллагаанд ахиц гарсангүй. Азербайжанд өгсөн нутаг дэвсгэрт Армений цэргийн хүчнийхний тавьсан тэсрэх бөмбөгөнд жирийн иргэд өртөн амь насаа алдсаар байгаа бөгөөд оны сүүлчээр Азербайжаны жагсагчид Нагорно-Карабахыг Арменитай холбосон замыг хааж, зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээний хүртээмжийг тасалдуулснаар хурцадмал байдал улам даамжрав. Гүржээс салан тусгаарласан Абхаз, Өмнөд Осет/Цхинвали мужид өмнө нь үйлдсэн хүчирхийллийн үйлдэлдээ ял завшсан асуудалд ахиц гарсангүй.

Дайны болон хүмүүнлэгийн эсрэг бүхий л гэмт хэргийг түгээмэл харьяаллын зарчимд үндэслэн хараат бусаар, шударгаар мөрдөн шалгах шаардлагатай.

ДҮРВЭГЧ, ЦАГААЧДЫН ЭРХ

Бүс нутагт нүүн шилжиж байгаа хүмүүсийн тоо урьд байгаагүй хэмжээнд хүрчээ. ОХУ-ын Украин дахь түрэмгийллээс зугтсан хүмүүсийн шилжилт хөдөлгөөн нь дэлхийн хоёрдугаар дайнаас ойш тус бүс нутагт өрнөсөн хамгийн том тохиолдол боллоо. Украиннаас дүрвэн ирсэн иргэдийн тоо хамгийн их нь Польш (1.53 сая), Герман (1.02 сая), Чех (468,000) байна. Европын Холбоо анх удаа Түр Хамгаалалтын Удирдамжийг хэрэгжүүлж, Украин дахь мөргөлдөөнөөс зугтсан хүмүүст орон байр, хөдөлмөрийн зах зээл, боловсролын үйлчилгээ авах нөхцөлийг шуурхай бүрдүүллээ. Украины дайнаас үүдэн хамгаалалт хүссэн хүмүүсийг хүлээн авч байгаа нь Европт шинэ жишиг тогтоож, улс төрийн хүсэл зориг байвал Европын холбооны гишүүн улсууд сая сая хүнийг нэр төртэйгөөр хамгаалах чадвартай болохоо батлан харууллаа. Тухайлбал, Нидерланд улс 60,000 Украины оршин суугчдыг орон байр болон бусад үйлчилгээнд хамруулах зорилгоор онцгой байдлын тухай хуулийг

баталсан. Швейцарьт орогнол олгох төвүүдийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн төслүүдийг хойшлуулсан байсан хэдий ч Украйнаас ирсэн дүрвэгсдэд шуурхай дэмжлэг үзүүлсэн.

Мөн Европын Холбооны улс орнуудад 2016 оноос хойш дэлхийн бусад улс орнуудаас аюулгүй байдлыг эрэлхийлж хамгийн олон тооны хүн орогнол хүссэн бөгөөд Баруун Балкан, Төв болон Зүүн Газар дундын тэнгисийн замаар ирэх хүмүүсийн тоо нэмэгджээ. Жилийн туршид Европын хил нь Афганистан, Сири, Сахарын цөлөөс өмнөх Африк зэрэг дэлхийн бусад хэсгээс хамгаалалт хайж буй олон хүмүүсийн хувьд арьс өнгөөр ялгаварлан гадуурхагдсан, аюул, хүчирхийллийн газар хэвээр байв. Улс орнууд хуурай газрын болон далайн хил дээрх дүрвэгсэд болон цагаачдыг хувийн нөхцөл байдлыг нь судлахгүйгээр хүчээр, ихэвчлэн хүчирхийллийн аргаар хуульд заасан журмыг зөрчин тэр даруй нутаг буцааж байв. Олон тооны дүрвэгсэд, цагаачид албан хаагчдын хэрэгжүүлж байгаа арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан хилийн бодлогын үр дагаврыг амсаж байна. Испанийн эрх баригчид 2021 онд Мелилла дахь хилийн цагдаа нарын үйл ажиллагаанаас болж Африкийн Сахарын цөлөөс ирсэн 37 хүний амь эрсдэж, олон хүн бэртэж гэмтсэн үйлдэл болон хамгийн багадаа 470 хүнийг Марокко руу хуульд заасан журмыг зөрчин нэн даруй буцааж хүний эрхийг ноцтой зөрчсөн явдлын хариуцлагыг хүлээгээгүй хэвээр байна.

Далайн хил дээр эргүүл хийж байсан төрийн албан хаагчид завиар ирж буй дүрвэгсэд болон цагаачдыг эрэг дээр буухаас сэргийлэх арга хэмжээ авч байна. Европын Холбооны нутаг дэвсгэрт хүрч чадсан бусад хүмүүсийг хилийн албаныхан болон цагдаа нар дур зоргоороо удаан хугацаагаар цагдан хорих, эсхүл тэр даруй хүчирхийллийн аргаар нутаг буцаажээ. Болгар, Грекээс Турк руу; Туркээс Иран, Сири рүү; Кипрээс Ливан руу; Испаниас Марокко руу; Францаас Итали руу; Хорватаас Босни Герцеговина руу; Унгараас Сербии рүү; болон Латви, Литва, Польш зэрэг улсаас Беларусь руу хүмүүсийг хүч хэрэглэн нутаг буцааж байна.

2021 онд Талибууд Афганистаныг булаан эзэлсэн явдал улс орнууд харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлэв. Дани улс Афганистаны орогнол хүсэгчдийн татгалзсан хэргийг дахин хянаж эхэлсэн бол Бельги улс Афганчуудыг олон улсын хамгаалалтад авахаас татгалзаж эхэлсэн. Герман улс эрсдэлт бүлгийн афганчуудын нэлээд хэсгийг дахин суурьшуулсан хэдий ч сар бүр 1000 хүнийг хүлээн авахыг зөвшөөрсөн шинэ хөтөлбөрийн хэрэгжлтийн шударга, тод байдлыг хангах асуудал хөндөгдөж байна.

Бүс нутгийн зүүн хэсэг орших Тажикстан улс Афганистаны дүрвэгсдийг саатуулж, албадан нутаг буцаажээ. ОХУ-ын Украин дахь дайн нь Оросуудыг Армен, Гүрж, Киргиз, Казахстан руу олноор нүүн шилжихэд хүргэсэн. Казахстан улс олон тооны хүнийг Орос руу буцаахад хүргэж болзошгүй хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулав. Беларусь улс тус улсын нутаг дэвсгэрээр дамжин Европын Холбооны улс орнууд руу дүрвэж, цагаачилж байгаа иргэдийг эрүүдэн шүүж, тэдэнтэй зүй бус харьцаар байна.

Засгийн газрууд хүн бүрийн олон улсын хамгаалалт хүртэх эрхийг ялгаварлан гадуурхалт, дарлал мөлжлөг, хүний эрхийн бусад хүчирхийллээс ангид байдлаар хүндэтгэж, хамгаалж, хэрэгжүүлэх ёстой.

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

Эмэгтэйчүүдийн эрхэд ахиц дэвшил, ухралтын аль аль нь гарлаа. Польш улсад 2021 онд эмэгтэйчүүдийн үр хөндөлтийн хүртээмжийг хязгаарласан Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хор хөнөөл нь хэвээр байгаа бөгөөд үр хөндүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь гэмт хэрэгт тооцогдох эрсдэлтэй хэдий ч төрийн бус байгууллагууд 44,000 хүнийг үр хөндөлтийн үйлчилгээ (ихэвчлэн гадаад улсад) авахад нь дэмжлэг үзүүлжээ. Унгар улсад үр хөндөлт хийлгэх гэж буй хүмүүс «ургийн зүрхний цохилт»-ыг сонссон тухай эмчийн дүгнэлтийг үзүүлэхийг шаарддаг шинэ дүрмийг баталжээ. Словак улсад улс төрийн хүчнүүд үр хөндөлтийн хүртээмжийг хязгаарлах хууль тогтоомжийг баталлаа.

Хэд хэдэн улсад үр хөндөлтийн хязгаарлалтыг хүчингүй болгож эхэллээ. Нидерланд үр хөндөлт хийлгэхэд заавал тав хоног хүлээх хугацааг цуцалсан бол Герман улсад «үр хөндөлтийг сурталчилсан» эмч нарт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг заалтыг хүчингүй болгов. Испаний парламент үр хөндөлт хийлгэх хүсэлтэй 16, 17 настай хүүхдүүдээс эцэг, эхийн зөвшөөрөл авах, заавал зөвлөгөө авах, эргэцүүлэн бодох хугацааг хасах хуулийн төслийг баталлаа. Мальта улсад эмэгтэйн амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй тохиолдолд үр хөндөх боломжийн талаар хэлэлцэж эхэлсэн.

Бүс нутгийн хэмжээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн түвшин өндөр хэвээр байна. Энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэл тогтолцооны шинжтэй, үл бүртгэгддэг Киргиз улс болон эмэгтэй хүний амь насыг хөнөөх явдал улам бүр нэмэгдсээр байгаа Гүрж улсад тулгамдсан асуудал болж байна. Хэд хэдэн улс хүчингийн гэмт хэргийн хууль тогтоомжийг шинэчлэн зөвшөөрлийн зарчмыг батлах чиглэлд шилжсэн. Тухайлбал, Бельги, Финланд, Испани улсад шинэ хуулиуд хүчин төгөлдөр болсон бол Нидерландад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар үргэлжлүүлэн хэлэлцсээр байна.

Украйн, Их Британи улс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Европын Зөвлөлийн конвенцийг (Истанбулын конвенц) соёрхон баталлаа. Хэдийгээр ЕХ Истанбулын конвенцийг соёрхон батлах талаар ахиц дэвшил гаргаагүй хэдий ч Европын Комисс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх шинэ удирдамжийн төсөл боловсруулжээ.

Украины дайнд нэрвэгдсэн бүс нутгуудын өрх толгойлсон эмэгтэйчүүдийн гуравны нэгээс илүү нь хоол хүнсний гачигдалд орсон бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудад өгсөн ОХУ-ын цохилт нь хүүхэд төрүүлсэн эхчүүд эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй болгосон гэж НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагаас мэдээлэв. Дөрөвдүгээр сард Туркменистанд «уламжлалт» үнэт зүйлсийг тогтоох шинэ алхам хийж цагдаа нар хууль эрх зүйн тодорхой зохицуулалтгүйгээр автомашины урд суудалд эмэгтэйчүүдийг суухыг хориглож эхэлжээ.

Засгийн газрууд охид, эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлж буй жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэртэй шуурхай тэмцэж, түүний суурь шалтгааныг арилгах ёстой.

ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХ

Тагнуулын “Пегасус” программ илчлэгдсэний дараахан 2022 онд Испани улс сэтгүүлчид болон сөрөг хүчний улс төрчдийг тагнаж байсан нь ил болсон. Түүнчлэн тайлангийн нэг жилийн хугацаанд Польш, Грек улс тагнах программ ашиглан сэтгүүлч, улс төрчдийг тагнаж байсан нь батлагдсан.

Хэд хэдэн улсын засгийн газар хууль сахиулах болон тагнуулын албаны эрх мэдлийг аюултай хэмжээнд хүртэл өргөтгөх ажлыг үргэлжлүүлсээр байна. Сербийн засгийн газар биометрийн тандалт, мэдээлэл боловсруулалтыг дэмжих хууль тогтоомжийг нэвтрүүлэхээр зэхэв. Швейцарь улсад тагнуулын албаны эрх мэдлийг өргөжүүлэх хуулийн төсөл, Ирландад царай таних технологийг хууль сахиулах байгууллагад нэвтрүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж байгаад төрийн бус байгууллагууд санаа зовниж байгаагаа илэрхийллээ. Гүрж улс хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хууль сахиулах байгууллагуудын нууц тандалт хийх боломжийг нэмэгдүүлжээ. Туркменистан дахь үүний эрхийн идэвхтнүүд хилийн чанадад халдлагад өртлөө. Тухайлбал, Истанбул хотод Туркменстаны консулын газрын ажилтан хүний эрхийн өргөх бичиг тайван замаар хүргүүлэх гэж оролдсон идэвхтнүүд рүү халджээ.

ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХ БА ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ АЛДАГДСАН НЬ

Гүрж улс 2021 онд Шүүхийн тухай хуульд өргөн хүрээнд, хурдан хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулж шүүхийг хянаж, дуугүй байлгах гэж зорьж байгаа нь “шүүгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, шүүхийн дотоод хараат бус байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй” хэмээн Европын зөвлөлийн Венецийн Комисс зургадугаар сард тэмдэглэсэн. Беларусь улс эрүүгийн хэрэгт холбогдогчийг оролцуулахгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа болон шүүх хуралдаан явуулах эрхзүйн орчныг өргөжүүлж, засгийн газрыг шүүмжлэгчдийг шүүхийн систем хавчсаар байв. Унгар, Польш улсын засгийн газар шүүгч, прокуроруудад зүй бусаар сахилгын хэрэг үүсгэн, бүрэн эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ авч байгаа бөгөөд энэ талаарх олон улсын шүүмжлэлийг үл тоомсорлосоор байна. Турк улсад шүүхийн эрх мэдлийг засгийн газар олон жилийн хянаж байгаа нь шүүхийн хараат бус байдлыг үгүй болгож, хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүд болон улс төрийн өрсөлдөгчдийг үндэслэлгүйгээр мөрдөн байцаах, яллах, ял шийтгэл оногдуулахад хүргэж байна.

Засгийн газрууд нийтээр тандах үйл ажиллагааг зогсоож, шударгаар шүүлгэх эрхийг хүндэтгэж, шүүхийн хараат бус байдалд халдах үйл ажиллагааг эцэс болгох шаардлагатай.

ЭРҮҮ ШҮҮЛТ, БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Украин дахь ОХУ-ын дайн нь эрүү шүүлт, бусад зүй бус харьцааг дагууллаа. Дайны олзлогдогсодтой зүй бусаар харьцаж, шүүхээс гадуур цаазлах боломжтой байв. ОХУ-ын «шүүх»-ийн процесс нь Украины зарим энгийн иргэдийг цахилгаан гүйдлээр цохиулах, цаазаар авах ялаар сүрдүүлэх, хоол хүнс, ус өгөхгүй байх, хүүхдүүдийг эцэг, эхээс нь салгах зэрэг хүний эрхийг зөрчилд хүргэлээ. Бүс нутгийн зүүн хэсгээс бусад хэсгийн цагдан хорих төвүүдэд зүй бусаар харьцах явдал түгээмэл байна. Казахстанд цахилгаанд цохиулж, уурын индүүгээр түлсэн хэрэг бүртгэгдсэн бөгөөд албан ёсны мэдээллээр «хууль бус байцаалт»-ын улмаас 6 хүн нас баржээ. Тажикстанд айлган сүрдүүлэх, хэрэг хүлээлгэх зорилгоор эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах явдал нэмэгджээ. Беларусь улсад улс төрийн зорилгоор ял шийтгүүлсэн хүмүүсийг хүнлэг бус нөхцөлд ганцаарчлан хорьж байна. Казахстан улс цаазаар авах ялыг хуулиар бүрэн халсан бол Беларусь улс дор хаяж нэг хүнийг цаазалжээ.

Европын Холбооны гадаад хилийн цэрэг, цагдаа нар дүрвэгсэд болон цагаачдыг хүчирхийлсэн хэвээр байгаа бөгөөд эрүүдэн шүүсэн хэрэг тогтмол бүртгэгдсээр байна. Итали улсын хорих газруудад эрүүдэн шүүх явдал гарсан хэвээр байна.

Засгийн газрууд эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах явдлыг эцэс болгож хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх ёстой.

ТӨРИЙН ХЭТ ЭРХ МЭДЭЛ БА ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газрууд өөртөө эрх мэдлийг шинээр бий болгохын тулд хямралыг урвуугаар ашиглаж байна. Унгарын эрх баригчид Украины дайныг шалтаг болгон онц байдал зарлах эрх мэдлийг өөртөө бий болгожээ. Латви, Литва, Польш зэрэг улс Беларусийн хил дагуух онц байдлын дэглэмээ үргэлжлүүлж, сэтгүүлчид, төрийн бус байгууллага, хүмүүнлэгийн байгууллагуудын нэвтрэх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлалаа.

Турк улс олон арван сэтгүүлч, идэвхтэн, сөрөг хүчний улстөрчдийг терроризмтой холбоотой хилс хэргээр цагдан хорьж, эрүүгийн ял оногдуулсаар байна. Хууль

тогтоох байгууллагаас олон нийтийн сүлжээнд засгийн газрын эрх мэдлийг нэмэгдүүлсэн шинэ хуулийг баталлаа.

Баруун Балканы орнуудад эрх баригчид сэтгүүлчдийг, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, дайны гэмт хэргийн талаар мэдээлдэг сэтгүүлдэд дарамт шахалт үзүүлж, айлган сүрдүүлж, дарамталж байна. Косово, Монтенегро, Серби улсад сэтгүүлдийн бие махбодод халдсан тохиолдлыг ажиглагчид дүн шинжилгээ хийх явцдаа баримтжуулжээ. Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн эрх зүйн маргаан ба сэтгүүлчид болон байгаль орчны идэвхтнүүдийн эсрэг чиглэсэн зүй бус маргаан улам түгээмэл болж байна. Энэ төрлийн хэрэг Австри, Босни Герцеговина, Болгар, Грект гардаг байсан хэдий ч Хорват, Серби, Словени зэрэг улсад эрс нэмэгдэж байна. Европын Комисс нийтийн стратегийн өмгөөллийн маргааны эсрэг удирдамжийн төслийг боловсруулсан бөгөөд энэ нь хэлэлцээрийн шатанд байгаа юм.

Бүс нутгийн зүүн хэсэгт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ноцтой халдлагад өртсөн хэвээр байна. Засгийн газрын хязгаарлалт нь ОХУ-ыг бие даасан мэдээллийн цөөн тооны эх сурвалжтай болгосон. ОХУ-ын Зэвсэгт хүчний талаар “санаатай худал мэдээлэл” тараасан, нэр хүндийг гутаасан үйлдэлд хариуцлага хүлээлгэх шинэ хуулийг гуравдугаар сард баталсан нь Украины дайны талаарх шүүмжлэлийг бодитойгоор хязгаарласан бөгөөд олон мянган хүнд захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ. Дайныг шүүмжилсэн хүмүүсийг баривчилж, их хэмжээний торгууль ногдуулж, цагдан хорьж, хорих ял оноожээ. Дайныг шүүмжлэгчдийг «гадаадын агент» хэмээн зарлав. Олон арван бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон мянган вэбсайтыг хааж, Метаг “хэт даврагч байгууллага” хэмээн зарлав. Түүнчлэн Беларусь улс Украиныг дэмжиж, засгийн газрыг шүүмжилсэн олон зуун хүнд эрүүгийн ял оногдуулж, 40 гаруй хараат бус сэтгүүлчийг баривчилсны зэрэгцээ хоригдож байсан хүмүүст шинээр хэрэг үүсгэн ял шийтгэл оноожээ. Олон зуун хүнийг “хэт даврагч” гэсэн үндэслэлээр хэрэг үүсгэн шүүхэд шилжүүлжээ.

Тажикстаны эрх баригчид Горно-Бадакшан автономит мужид шинээр үүссэн эсэргүүцлийн жагсаалтай холбогдуулан хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хүний эрх хамгаалагчдыг халдлагын бай болгож, оны эхний саруудад интернэтийн хэрэглээг бүрмөсөн хаажээ. Туркменистан улс гадаадаас мэдээлэл авахаас хязгаарлахын тулд 1.2 тэрбум IP хаягийг хаасан гэж мэдээлсэн бөгөөд Азербайжан сэтгүүлчдийн гүлдсэн бүртгэлийг бий болгохын тулд хэвлэл мэдээллийн шинэ хуулийг баталж, хэвлэл мэдээллийнхэн зөвхөн «объектив» мэдээллийг түгээх үүргийг хуульчилжээ.

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн баруун хэсгийн хэд хэдэн улс тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөнд дур зоргоор, эсхүл хэт хориглолт тогтоожээ. Босни Герцеговин улсын Бүгд Найрамдах Серпск мужид дайны үеийн хэлмэгдүүлэлтийн 30 жилийн ойд зориулсан жагсаалыг эрх баригчид хоригложээ. Турк улсад хүчээр алга болсон хохирогчдын дурсгалыг хүндэтгэх жагсаал, цуглааныг зохион байгуулахыг удаа дараа хоригложээ. Эрх баригчид эвлэлдэн нэгдэх эрхийг зүй бусаар хязгаарлах аргууд, тухайлбал урьдчилан саатуулах (Швед), жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэх (Серби), өндөр хэмжээний торгууль (Словени), дур зоргоороо баривчлах (Грек), жагсаалд оролцогчдыг шударга бусаар ажлаас халах (Унгар) зэрэг аргыг хэрэглэсээр байна.

Олон тооны засгийн газар иргэний үл захирагдахуй, ялангуяа байгаль орчныг хамгаалах эсэргүүцэгчдийн үйлдлийг хориглох, ял шийтгэл хүлээлгэх хүчин чармайлтаа үргэлжлүүлсээр байв. Засгийн газрууд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг нухчин дарах олон тооны арга хэрэгслийг хэрэглэжээ. Финландад жагсагчдыг хууль бусаар тараасан бол, Шведэд хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан гэх хэрэгт буруутгажээ. Их Британи улс цагдаа нар т дуу шуугиан, таагүй байдал учруулсан гэсэн үндэслэлээр хязгаарлалт тогтоох шинэ эрх мэдлийг олгосон хууль баталсан бол ХБНГУ-ын Холбооны Захиргааны шүүхээс жагсагчдын хуарангууд нь үндсэн хуулиар

хамгаалагдсан жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хүрээнд хамгаалагдана гэсэн шийдвэр гаргаж жишиг тогтоов.

Бүс нутгийн зүүн хэсгийн хэд хэдэн улсад тайван жагсагчид эрх баригчдын хүч хэтрүүлэн хэрэглэсэн үйл ажиллагааны улмаас шархдан, амь насаа алдаж, эрүүдэн шүүгджээ. Нэгдүгээр сард Казахстанд шинэчлэл хийхийг уриалсан олон нийтийн эсэргүүцлийн жагсаал гэнэт өрнөлөө. Эсэргүүцлийн жагсаалын хариу арга хэмжээний үеэр 10,000 гаруй хүнийг баривчилж, галт болон резинэн сум хэрэглэж, жагсагчдыг “террорист” хэмээн нэрийдэж, хүнлэг бус нөхцөлд зүй бусаар харьцаж, цагдан хорьсон бөгөөд хамгийн багадаа 219 жагсагч, 19 хууль сахиулагч амь үрэгджээ. Оны эцэс гэхэд ихэнх хэргийг мөрдөн шалгаагүй байлаа.

Тажикстан улсын эрх баригчид Горно-Бадахшан автономит мужид өрнөсөн эсэргүүцлийн жагсаалыг хүч хэрэглэн нухчин дарсан. Терроризмын эсрэг гэх ажиллагааны үеэр Памирийн хэдэн арван жагсагчид амь насаа алдаж, хүний эрхийн идэвхтэн, яруу найрагчид, сэтгүүлчид зэрэг 200 гаруй хүнийг дур зоргоор баривчилжээ.

Өнгөрсөн долдугаар сард Узбекистаны Каракалпакстан мужид газар нутгийн статустай холбоотой Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг эсэргүүцсэн жагсаал болжээ. Аюулгүй байдлын хүчнийхний хариу арга хэмжээний улмаас хамгийн багадаа 21 хүн амь насаа алдаж, 250 гаруй хүн шархдаж, олон зуун хүнийг дур зоргоор цагдан хорьж, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцжээ.

Беларусь улсын цагдаа нар Украины эсрэг Оросын түрэмгийллийг эсэргүүцсэн тайван жагсаалыг зүй бус хүч хэрэглэн тарааж, олон жагсагчдыг хаалттай шүүх хуралдааны дараа баривчилж, торгох ял ногдуулжээ. Киргизийн Бишкек хотын эрх баригчид олон нийтийн жагсаал, цуглаан зохион байгуулах боломжтой нийтийн эзэмшлийн газруудад хязгаарлалт тогтоожээ. ОХУ-д эрх баригчид жагсаалд оролцогчдыг төдийгүй жагсаал, цуглааныг хөндлөнгөөс ажиглаж дүн шинжилгээ хийж байсан хүмүүст хүртэл зүй бусаар дарамт шахалт үзүүлжээ.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн баруун хэсэгт Турк, Франц зэрэг улсууд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах оролдлогыг эрчимтэй хэрэгжүүллээ. Турк улс терроризмын эсрэг заалтуудыг хэт өргөн хүрээнд хэрэглэж, эмэгтэйчүүдийн амь насыг хохироохын эсрэг олон нийтийн бүлэг, улс төрийн гол сөрөг хүчнийг үндсэн бай болгож байна. Франц улсад “Бүгд найрамдах улсын үнэт зүйлсийн тухай» шинэ хуулийн заалтыг фашизмын эсрэг бүлэг, Палестиныг дэмжигч бүлгүүд болон байгаль орчны эрхийг хамгаалах эвслийн эсрэг урвуулан ашиглажээ.

Узбекистаны засгийн газар төрийн бус байгууллагуудыг гадаадын тусламжтай төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийн тулд заавал засгийн газраас сонгож өгсөн “үндэсний түншүүд”-тэй байхыг шаардсан тогтоол гаргаж иргэний нийгмийг хянах үндсийг бэхжүүллээ. Киргиз улс төрийн бус байгууллагуудад гадаадын санхүүжилтийн талаар тайлагнах шинэ шаардлага тавьсан бол Беларусь улс «хэт даврагч» болон «терроризм» гэсэн үндэслэлээр хоёр зуу гаруй байгууллагын үйл ажиллагааг зогсоожээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хэрэгжүүлэх бүхий л орон зайг төрийн эрх мэдлийг нэмэгдүүлэх оролдлогоос хамгаалах шаардлагатай.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД

Турк улс хүний эрх хамгаалагчдын эсрэг хүчирхийллээ үргэлжлүүлсээр байна. Оны эцэс гэхэд хүний эрхийн хуульч Озтурк Туркдоганыг “террорист байгууллагын гишүүн”, “төрийн албан тушаалтныг доромжилсон”, “Турк үндэстнийг гутаан доромжилсон” гэсэн гурван төрлийн эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгажээ. Мөн

хүний эрхийн хуульч Эрен Кескин, шүүх эмнэлгийн нэрт мэргэжилтэн Шебнем Корур Финканжы нарыг терроризмтой холбоотой хэрэгт холбогдуулан хилсээр шийтгэжээ. Туркийн эрх баригчид хүний эрх хамгаалагч Осман Кавалагийн эрхийг зөрчиж хууль бусаар үйл ажиллагаа явуулсан хэмээн шийдвэрлэсэн Хүний Эрхийн Европын шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзав. Турк улсын дээд шүүхээс Туркийн Эмнести Интернэшнлийн удирдах зөвлөлийн дарга асан Танер Кылыч нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Турк, Грек, Итали улсууд цагаачид болон дүрвэгсдийн эрхийн чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдыг хавчсаар байна. Мөн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагчид хэд хэдэн улсад хавчлагад өртжээ. Андорра улсад Ванесса Мендоза Кортес үр хөндөлтийг хориглосон шийдвэрийн хор уршгийг шүүмжилснийхээ төлөө бусдыг гүтгэсэн хэрэгт буруутгагдан их хэмжээний торгуулийн хариуцлага хүлээжээ. Польшид Жастина Выдржинска жирэмсэн эмэгтэйн үр хөндөлт хийлгэх оролдлогыг дэмжсэн үндэслэлээр шүүхээр шийтгүүлжээ.

Бүс нутгийн зүүн хэсэгт хүний эрх хамгаалагчдыг дур мэдэн саатуулж, хүчирхийлж, айлган сүрдүүлсээр байна. Беларусь улсын "Виасна" хүний эрхийн төв онцгой халдлагад өртсөн бол Нобелийн шагналт Алес Беляцки болон түүний хамтран ажиллагсад хилс хэрэгт шийтгэгдэн хоригджээ. Хаалттай шүүх хурлаар Марфа Рабковад 15 жил, Андрей Чапюкд зургаан жилийн хорих ял оноолоо. Наста Лойкаг «жижиг танхай» зөрчлийн хэрэгт хилсээр буруутгаж, захиргааны журмаар цагдан хоригдож байхад нь эм тариа, дулаан хувцас, ундны ус өгөхөөс татгалзжээ. Хожим нь хилс эрүүгийн хэрэг үүсгэсэн. ОХУ-д хүний эрх хамгаалагчид «гадаадын агентууд» болон «таагүй байгууллагууд»-ын хууль тогтоомжийн дагуу байнгын дарамт шахалтад өртөж, ихэнх нь эх орноо орхин явахад хүржээ. Дөрөвдүгээр сард Хууль зүйн яам Эмнести Интернэшнл зэрэг гадаадын арав гаруй сан, ТББ-ын бүртгэлийг хүчингүй болгож, Орос дахь салбарыг нь хаасан юм. Эзлэгдсэн Крымд Крымын Татаруудын эрхийн төлөө тэмцэгчид болон хуульчид ноцтой хэлмэгдүүлэлтэд өртсөөр байна.

Засгийн газар хүний эрх хамгаалагчдыг хамгаалж, тэдний үйл ажиллагааг гутаан доромжилж, ял шийтгэл хүлээлгэхийн оронд тэдний гүйцэтгэх чиг үүргийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Хэд хэдэн улсад еврей хүмүүсийг үзэн ядах үзэл өндөр түвшинд хүрлээ. Герман, Их Британид еврей хүмүүсийг үзэн ядах гэмт хэрэг ноцтой хэмжээнд өссөн болохыг дүн шинжилгээ харуулж байна. Словак улсад хоёр ЛГБТИ хүнийг хөнөөсөн хэрэгт сэжиглэгдэж байсан этгээд еврейн эсрэг харгис суртал ухуулга бичсэн нь тогтоогджээ. Латвийн парламент нацист болон зөвлөлтийн эзлэн түрэмгийллийн үед хураан авсан эд хөрөнгийн нөхөн төлбөрийг еврейчүүдэд олгох тухай хуулийг баталжээ.

Хэд хэдэн улс Исламын шашинт эмэгтэйчүүдэд чиглэсэн шинэ арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. Андорра улс Исламын шашинт эмэгтэйчүүдийг толгойн алчуур зүүхийг хориглох зорилгоор шашны бэлгэдэл бүхий өмсгөл өмсөхийг хориглосон хууль баталжээ. Францын орон нутгийн эрх баригчид толгойн алчуур зүүсэн Исламын шашинт эмэгтэйчүүдийг спортын тэмцээнд оролцохыг хориглосон ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг хуульчлах оролдлогыг эсэргүүцсэн эмэгтэй хөлбөмбөгчдийн жагсаалыг хоригложээ. Захиргааны хэргийн дээд шүүхээс Франц улсын Гренобль хотод «буркини» өмсөхийг хориглосон шийдвэрийг хэвээр үлдээлээ. Швейцарьт 2021 онд зохион байгуулсан бүх нийтийн санал асуулгын дараа нүүрээ халхлахыг хориглох хуулийн төслийг хууль тогтоох байгууллага хэлэлцээ. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх эсэх талаар хэлэлцүүлэг нь уламжлалт хэвшмэл сөрөг үзэл хандлага, Исламын шашинтнуудын эсрэг яриа хэлэлцээр зонхилж байлаа.

Бельги, Швейцарь улсад Африк гаралтай хүмүүсийн эсрэг бүтцийн шинжтэй

арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл хүчтэй байгааг хяналт-шинжилгээний үр дүн нотлон харууллаа. Их Британий цагдаа нарын саатуулах-нэгжих үйл ажиллагаанд хар арьст хүмүүст илүү ихээр өртсөн хэвээр байна. Хоёр жилийн хугацааны мөрдөн байцаалтын явцад 650 хүүхдийн биед нэгжлэг явуулсны 58 хувь нь хар арьстай хүүхдүүд байжээ. Дани улсад “баруун гаралтай бус” хүмүүсийг төвлөрүүлэхийг хориглосон хуулийн дагуу “гетто” ангилалд хамаарахгүйн тулд орон сууцны компани олон хүнийг нүүлгэн шилжүүлэв. Герман улсад арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдал тус улсын өдөр тутмын амьдралын нэг хэсэг болсныг Үндэсний ялгаварлан гадуурхалт ба арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн хяналтын байгууллага олж тогтоожээ.

Цыганууд орон сууц, боловсрол, цагдаагийн үйл ажиллагаа болон амьдралын бусад салбарт доромжилсон үг хэллэг, системт ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна. Албани, Хорват, Косово, Хойд Македон, Словак зэрэг улсад цыганууд боловсролын хувьд тусгаарлагдсан хэвээр байна. Арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан бодлого, харьяалалгүй байдал, хувийн бичиг баримт дутмаг байдал нь цыгануудын эрхийн хамгааллыг хэрэгжүүлэх хүчин чармайлтад саад болж байна. Беларусь дахь хүний эрхийн эсрэг харгис балмад үйл ажиллагаа нь Польш, Литва зэрэг үндэсний цөөнх, мөн Беларусийн хэл, соёлыг дэмжигчдийг онилж байна. Польшчууд олноор амьдардаг тус улсын баруун хэсгийн хоёр сургуульд Польш хэлээр хичээл заахыг засгийн газар хориглож, Гродна муж дахь Литвын сургууль болон Беларусийн номын дэлгүүрүүдийг хаажээ

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Зарим улсад ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхаж, хүчирхийлж байгаа бол зарим улсад шүүх болон хууль тогтоох үйл ажиллагаанд дэвшил гарчээ. Словак улсад ижил хүйстнүүдийн цэнгээний газрын гадаа буудалцаан болж, хоёр хүн нас барж, нэг хүн шархадсан нь хүчирхийллийн ноцтой тохиолдлын нэг юм. Хойд Македон, Монтенегро, Польшид ЛГБТИ удирдагчид халдлага, заналхийлэлд өртжээ.

Зарим улсын шүүх ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалсан шийдвэр гаргалаа. Хорват улсын шүүх ижил хүйстэн хосууд бусад хүмүүстэй адил нөхцөлөөр хүүхэд үрчилж авах боломжтой болохыг баталгаажууллаа. Словений Үндсэн хуулийн шүүх ижил хүйстнүүдийн гэрлэлт болон хүүхэд үрчлэн авахыг хориглох нь Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн шийдвэрлэв. Латви улсын Дээд шүүхийн шийдвэрийн дараа захиргааны шүүх ижил хүйстэн хосуудыг хүлээн зөвшөөрч эхэлжээ. Швейцарь улсад иргэний гэрлэлт болон ижил хүйстэн гэр бүл хүүхэд үрчлэн авах талаарх шинэ зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Испани улсын парламент транс хүмүүсийн хүйсээ өөрөө тодорхойлох эрхийг хүлээн зөвшөөрсөн чухал хуулийн төслийг баталлаа. Финлянд, Герман зэрэг улсын засгийн газар хүйсийг хууль ёсоор хүлээн зөвшөөрөх тухай дэвшилтэт хуулийн төслийг боловсруулав.

Харин үүний эсрэгээр Унгар улсын засгийн газар 2021 онд ЛГБТИ-ийн эсрэг хуулийн талаар бүх нийтийн санал асуулга зохион байгуулжээ. Польшид олон тооны орон нутгийн засаг захиргаа өөрсдийгөө “ЛГБТ-гүй бүс” хэмээн зарласан хэвээр байгаа бөгөөд хүний эрхийн идэвхтнүүдийг зоргоороо баривчилж, олон нийтийн оролцооны эсрэг эрх зүйн маргаанд өртсөөр байна.

Бүс нутгийн зүүн хэсэгт зарим ахиц дэвшил ажиглагдаж байна. Ерөнхийлөгч Владимир Зеленский Украинд иргэдийн нөхөрлөлийн тухай хууль батлахаа амласан. Молдавын нийслэл Кишинев хотын захирагч бахархлын жагсаал зохион байгуулахыг хориглоно хэмээн мэдэгдсэн хэдий ч тус улсын түүхэн дэх хамгийн том бахархлын жагсаал зохион байгуулагдлаа. Гэвч бусад газар ЛГБТИ хүмүүс ноцтой хавчлагад өртөөр байна. Орос улс насанд хүрээгүй хүмүүст “уламжлалт бус бэлгийн харьцааг сурталчлах, педофиль болон хүйс солих”-ыг хориглох зохицуулалтыг бүх насны бүлэг болгон өргөжүүлжээ. Туркменистан, Узбекистан улсад гэмт хэрэгт тооцсон хэвээр байгаа бөгөөд Узбекистанд эрэгтэйчүүдтэй бэлгийн харьцаанд орсон эрчүүдийг

албадан шинжилгээнд хамруулахыг цагдаа нарт зөвшөөрсөн ялгаварлан гадуурхсан хуулийн төслийг өргөн барив.

Засгийн газрууд еврей, Исламын шашинтнууд, хар арьст хүмүүс, цыган болон ЛГБТИ зэрэг хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх хүчин чармайлтаа улам бүр нэмэгдүүлэх шаардлагатай.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

ОХУ-тай эдийн засгийн нягт холбоотой орнууд Украйны дайн ихээхэн нөлөөлж байна. Орос улсад ядуурлын түвшин нэмэгджээ. Украйнд ядуурлын түвшин арав дахин нэмэгдэж, дор хаяж хагас сая хүүхэд ядууралд нэрвэгдсэн хэмээн Дэлхийн банк мэдээлэв.

Оны эцэс гэхэд бүс нутгийн ихэнх улс орнууд амьжиргааны өртгийн хямралд өртөж, инфляц урьд байгаагүй хэмжээнд хүрчээ. Европын Холбооны 17 гишүүн улсын инфляци 10 хувиас дээш гарчээ. Бүс нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэтгэврийн иргэд, хүүхдүүд зэрэг нийгмийн хамгийн ядуу, эмзэг бүлгийнхэн хямралд харьцангуй ихээр өртсөн бөгөөд нийгмийн хамгаалал хангалтгүй байв.

Хүн бүр эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх баталгааг хангахын тулд нийгмийн иж бүрэн хамгаалалтыг оролцуулаад шаардлагатай нөөцийг хуваарилах замаар нийгэм-эдийн засгийн өнөөгийн хүндрэлийг шийдвэрлэхэд засгийн газрууд шуурхай арга хэмжээ авах шаардлагатай.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ ЧАДСАНГҮЙ

Урьд өмнө тохиолдож байгаагүйгээр зун нь хэт халж, зарим газарт агаарын хэм 40 хэмээс хэтэрсний улмаас уур амьсгалын хямрал хүмүүсийг гэртээ хорогдоход хүргэв. Хэт халалтын улмаас гол мөрөн ширгэж 25,000 гаруй хүн нас баржээ. Италид мөсөн гол нурж, Португалийн ихэнх хэсэгт хүчтэй ган болж, Испанид өргөн уудам газар нутгийг сүйтгэсэн түймэр гарчээ. ОХУ-ын Украйнд өдүүлсэн дайны үр дагавар нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөв. Украйн дахь Оросын цэргийн ажиллагаа нь агаар, ус, хөрсийг хорт бодисоор бохирдуулсан бөгөөд Запорожье атомын цахилгаан станцын эргэн тойронд цөмийн осол гарах эрсдэлийг нэмэгдүүлэв. ОХУ-ын газрын тос, байгалийн хийн хараат байдлыг багасгахын тулд чулуужсан түлшний өөр эх үүсвэрийг хангах тэмцэл өрнөж, улмаар нүүрс болон цөмийн станцуудын ашиглалтын хугацааг уртасгаж, түлшний татварыг түр хугацаагаар бууруулах шийдвэр гаргахад хүргэв. Туркменистан улс дэлхийн хэмжээнд метан хий ялгаруулалтаар тэргүүлэгч улсын нэг хэвээр байгаа бөгөөд хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд уур амьсгалын өөрчлөлтөд харьцангуй ихээр өртөж байна.

СОР 27 зохион байгуулагдахаас өмнө Европын Холбоо алдагдал, хохирлын сан байгуулахыг дэмжиж, уур амьсгалын хамтын хүчин чармайлтыг талаар зарим итгэл найдвар төрүүлэв. Гэвч Европын орнууд агаарын температурын өсөлтийг 1.5°C хүртэл хязгаарлах дэлхийн зорилтод хүрэхийн тулд 2030 он хүртэл ялгаруулалтыг бууруулах зорилтоо биелүүлж чадсангүй.

Засгийн газрууд уур амьсгалын хямралыг шийдвэрлэх үүрэг хариуцлагын хүрээнд нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах зорилтоо нэмэгдүүлэх шаардлагатай. Улс орнууд шударга шилжилт хийх замаар чулуужсан түлшний үйлдвэрлэл, хэрэглээг үе шаттайгаар зогсоох зэргээр хүний эрхэд үндэслэсэн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн бага орлоготой улс орнуудад олгодог уур амьсгалын санхүүжилтээ яаралтай нэмэгдүүлж, алдагдал болон хохирлыг барагдуулах чиглэлд чармайлт гарган ажиллах шаардлагатай.

ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Украины дайн зэрэг дэлхий дахинд өрнөж буй нөхцөл байдал болон мөргөлдөөн, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байгалийн гамшиг зэрэг бүс нутгийн хүчин зүйлийн улмаас эдийн засгийн нөхцөл байдал улам бүр доройтож байгаагийн эсрэг засгийн газрууд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж чадсангүй. Энэ нь олон сая хүний хоол хүнс, цэвэр ус, орон байр болон эрүүл мэндийн эрхэд сөргөөр нөлөөлж байна.

Зэвсэгт мөргөлдөөн Ойрх Дорнод болон Хойд Африкийн олон сая хүний амьдралыг сүйрүүлсээр байна. Энгийн иргэд зэвсэгт мөргөлдөөний халдлага, амин чухал дэд бүтцийн сүйрэл, албадан нүүлгэн шилжүүлэлт, хариуцлага хүлээдэггүй цэрэг, зэвсэгт бүлэглэл, аюулгүй хүчний хүчирхийлэлтэй нүүр тулгарч байна. Ливан, Йордан зэрэг улс Сирийн олон сая дүрвэгчдийг хүлээн авсаар байсан ч хоёр улс дүрвэгчдийг буцаан ирэхийг шаардсан албадлагын бодлогыг хэрэгжүүлж байна. Эрх баригчид хэдэн сая дотоодын дүрвэгчдийн төрөлх нутагтаа аюулгүй эргэн ирэх баталгааг хангаж чадсангүй.

Засгийн газрууд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг дарангуйлах ноцтой арга хэрэгслийг ашигласаар байна. Эрх баригчид цахим болон цахим бус орчны хэвлэл мэдээллийн хэрэгсэлд цензур тогтоож, шүүмжлэлт дуу хоолойг үгүй хийж байна. Хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчид, жагсагчид, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид, улс төрийн идэвхтнүүд, болон бусад шүүмжлэгчид дур зоргоор баривчлах, үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэх, шударга бус шүүх, хууль бусаар хорих, зөрчих эрхийн хязгаарлалт, заналхийлэл болон бусад төрлийн хүчирхийлэл, дарамтад өртсөөр байна. Аюулгүйн албаныхан эсэргүүцлийн жагсаалыг нухчин дарахын тулд хууль бус, зарим тохиолдолд хүний амь насанд аюултай хүчийг хэрэглэж, хүмүүсийг олноор нь баривчилж байна.

Үндэстний болон шашны цөөнхийг ялгаварлан гадуурхах, хүчээр алга болгох, эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах, цаазаар авах ял болон бусад хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх зэрэг хүний эрхийн бусад зөрчил гарчээ.

Бүс нутгийн хэмжээнд хүний эрхийн асуудлыг онцолсон гурван чухал арга хэмжээ өрнөлөө. Есдүгээр сард Махса (Жина) Аминиг нүүрээ халхлах талаарх үндэсний хууль тогтоомжийг зөрчсөн гэх үндэслэлээр “ёс сурахууны цагдаа” нар баривчилсны дараа тэрээр урьдчилан хорих газарт нас барсан нь Исламын Бүгд Найрамдах улсыг эцэс болгон хүний эрх, тэгш байдлыг хүндэтгэсэн тогтолцоог шаардсан урьд өмнө тохиож байгаагүй эсэргүүцлийн томоохон жагсаал болсон. Арван нэгдүгээр сард Египет улсад Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн оролцогч талуудын 27 дахь удаагийн хурал зохион байгуулсан нь тус улсад хүний эрхийн ноцтой байдал, улс төрийн шалтгаанаар хорих газар ял эдэлж байгаа хэдэн мянган хүний нөхцөл байдлыг анхаарахад хүргэсэн. Түүнчлэн дэлхийн улс орны засгийн газрууд уур амьсгалын хямралаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны доройтлыг арилгахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж чадаагүйг онцлов. Мөн арван нэгдүгээр сарын сүүлээр дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг Катар улсад зохион байгуулсан нь Катарын цагаач ажиллах хүчний хүний эрхийн асуудлыг онцлоход хүргэлээ. Учир нь цагаач ажилчдын хөдөлмөрийн нөхцөл нь маш хангалтгүй бөгөөд зарим хүмүүс албадан хөдөлмөр эрхэлж байна. Бүс нутгийн хэмжээнд цагаач ажилчид ижил нөхцөл

байдалтай нүүр тулгарч байна. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Катар дахь ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтын асуудлыг онцолсон.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗӨРЧИЛ

Удаан хугацаанд үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эзлэн түрэмгийлэл, аюулгүй байдлын асуудал нь Израйль болон Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр, Ливи, Сири, Ирак, Йемен зэрэг улсын олон сая энгийн иргэдийн амьдралыг сүйрүүлсээр байна. Мөргөлдөөнд оролцогч төрийн болон төрийн бус талууд энгийн иргэдийг ялгахгүйгээр, эсхүл тэднийг онилж халдлага үйлдэх, үхэлд хүргэх болон дэд бүтцийг сүйтгэх гэх зэргээр дайны гэмт хэрэг үйлдэж, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчиж байна.

Сири дэх зэвсэгт мөргөлдөөний хүчирхийллийн түвшин буурсан хэдий ч 11 дэх жилдээ үргэлжилж байна. Сири болон Оросын арми энгийн иргэд болон иргэний дэд бүтэц, тэр дундаа дотоодын дүрвэгсдэд зориулсан худаг, хуаран руу газар болон агаараас хууль бусаар халдлага үйлдсэний улмаас олон тооны энгийн иргэд амь үрэгдэж, шархаджээ.

Гал зогсоох гэрээ байгуулсан хэдий ч Йемен дэх сүйрэл дагуулсан мөргөлдөөн үргэлжилсээр байна. Мөргөлдөөнд оролцогч бүх талууд хууль бус халдлага үйлдэж, энгийн иргэдийн амь насыг хөнөөж, хүмүүнлэгийн тусламж авахад саад болж, иргэний дэд бүтцийг сүйтгэсэн.

Ливид 2020 оны 10-р сараас хойш үндэсний гал зогсоох хэлэлцээр явагдсан. Цэргүүд болон зэвсэгт бүлэглэлүүд газар нутаг, нөөц баялгийнхаа төлөө орон нутгийн чанартай мөргөлдөөн хийсээр байсан бөгөөд энэ үеэр тэд энгийн иргэдийг ялгахгүйгээр халдлага үйлдэж, иргэний дэд бүтцийг устгасан.

Израйлийн арми болон Палестины зэвсэгт бүлэглэлийн хоорондох мөргөлдөөн дахин хурцадлаа. 8 дугаар сарын 5-нд Израйль 15 жилийн турш Израйлийн хууль бус бүслэлт, ялгаварлан гадуурхах дэглэмийн дор байгаа Газын зурвас дахь Палестины Исламын Жихад бүлэглэлийн эсрэг гурван өдрийн цэргийн довтолгоог эхлүүлэв. Довтолгооны үеэр Палестины 1700 орчим гэр орон эвдрэн сүйдэж, олон зуун энгийн иргэд дүрвэжээ. Израйлийн довтолгооны улмаас Палестины 17 энгийн иргэн амь үрэгдсэний долоо нь Палестины зэвсэгт бүлэглэлийн харвасан пуужинд өртжээ.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүх талууд олон улсын хүмүүнлэгийн хуулийг дагаж мөрдөх, ялангуяа энгийн иргэд болон иргэний дэд бүтэц рүү шууд халдах, ялгаварлан гадуурхах халдлагыг зогсоох ёстой. Иймд гадаад улсын засгийн газрууд хүний эрхийн ноцтой зөрчил үйлдэхэд ашиглагдах өндөр эрсдэлтэй тохиолдолд зэвсгийн шилжүүлгийг зогсоох ёстой.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүх тал олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг даган мөрдөж, энгийн иргэд болон иргэний дэд бүтэц рүү чиглэсэн шууд халдлага болон энгийн иргэдийг ялгахгүйгээр халдлага үйлдэхээ зогсоох шаардлагатай. Харин гадаад улсын засгийн газрууд хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчил үйлдэхэд ашиглах өндөр эрсдэлтэй тохиолдолд зэвсгийн шилжүүлэлтийг зогсоох шаардлагатай.

ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧ, ДҮРВЭГЧ, ЦАГААЧДЫН ЭРХ

Дүрвэгсэд, цагаачид болон дотооддоо дүрвэгсдийн эрх өмнө болон одоо өрнөж буй мөргөлдөөний улмаас хохирсоор байна. Ливан, Йордан зэрэг хүлээн авагч улсууд дүрвэгсдийн эрхийг зөрчиж байгаагийн зэрэгцээ олон улсын хандивлагч засгийн газрууд хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрийг хангалттай хэмжээнд санхүүжүүлсэнгүй.

Эрх баригчид дүрвэгсэд болон цагаачдыг баривчилж, дур зоргоор саатуулж, тэднийг нутаг буцаах, бөөнөөр нь хөөн гаргах арга хэмжээг хэрэгжүүлсээр байна.

Ливан улс 1.5 сая орчим сиричүүдийг хүлээн авсан хэдий ч тус улсын засгийн газар эдийн засгийн хямралын улмаас ихэнх дүрвэгсэд хоол хүнс, орон сууц, боловсрол, эрүүл мэнд зэрэг хүний эрхээ эдлэх боломжгүй нэн ядуу нөхцөлд амьдарч байна. Ливаны эрх баригчид Сири улсад хавчлага, эрүүгийн ял шийтгэх явдал байгааг баталгаажуулсныг ул харгалзан Сирийн дүрвэгчдийг сайн дураараа ирсэн гэсэн үндэслэлээр нутаг буцааж байна.

Хөрш зэргэлдээ Йордан улс 2 сая орчим Палестины дүрвэгсэд болон Ойрх Дорнод, Хойд Африкийн бусад орноос ирсэн 750,000 гаруй дүрвэгсдийг хүлээн авсан бөгөөд тэдний ихэнх нь санхүүжилтийн дутмаг байдлын улмаас чухал үйлчилгээнд хамрагдах боломж ихээхэн хязгаарлагдмал байна. Израйль хэдэн арван мянган Украйны дүрвэгсдийг хүлээн авч, олон мянган еврей украйн иргэдийг тус улсад суурьшуулахыг зөвшөөрсөн ч сая сая палестинчуудын буцаж ирэх эрхийг үгүйсгэсээр байна. Мөн Африкийн орнуудаас, ялангуяа Эритрей, Суданаас дүрвэн ирсэн хэдэн арван мянган хүнд орогнол олгохоос татгалзсан.

Ливид төрийн албан тушаалтнууд, цэргийн болон зэвсэгт бүлэглэлүүд дүрвэгсэд болон цагаачдыг хууль бусаар алах, хугацаагүйгээр дур зоргоороо баривчлах, эрүүдэн шүүх, хүчиндэх болон бусад зүй бус харьцах, албадан хөдөлмөрлөх зэрэг өргөн хүрээтэй хүний эрхийн зөрчил үйлдсээр байна. Европын Холбооноос дэмжлэг авдаг Ливийн эргийн хамгаалалтынхан Газар дундын тэнгисийг гаталж буй дүрвэгсэд болон цагаачдыг тэвэрлэж явсан завь руу буудаж, санаатайгаар гэмтээжээ. Ливид далайд саатуулагдсан, эсхүл эрэгт буусан олон мянган хүмүүсийг хүчээр алга болгосон бол олон мянган хүн орогнол хүсэх боломжгүйгээр тус улсын өмнөд хилээс хөөгджээ.

Мароккогийн хойд хэсэг болон Испаний Мелилла мужийг холбосон хил дээр хоёр талын хамгаалалтын албаныхан хүч хэтрүүлэн хэрэглэсний улмаас Африкийн Сахарын цөлөөс ирсэн 37 хүн амь үрэгдэж, олон арван хүн шархаджээ. Алжир улсын эрх баригчид олон арван дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийг баривчилж, шууд албадан гаргажээ. Иранд аюулгүйн албаныхан Иран/Афганистаны хилээр нэвтэрч буй Афганистаны иргэд рүү гал нээж, хүмүүсийг хууль бусаар хөөн гаргахын өмнө дур мэдэн саатуулж, эрүүдэн шүүжээ. Саудын Араб хэдэн арван мянган оршин суух эрхийн бичиг баримтгүй Этиоп цагаачдыг хүнлэг бус нөхцөлд дур мэдэн саатуулж, эрүүдэн шүүх болон бусад зүй бус хэлбэрээр харьцсаны дараа албадан нутаг буцаажээ. Ирак, Ливи, Сири зэрэг улсад дотооддоо дүрвэсэн иргэд аюулгүй байдлын албаныхны дур зоргоороо баривчлах, дарамтлах эрсдэл зэрэг аюулгүй байдлын асуудал, түүнчлэн зайлшгүй шаардлагатай үйлчилгээ, ажлын байрны боломж дутмаг байдлаас үүдэн гэртээ буцаж очиж чадахгүй байна.

Засгийн газар дүрвэгсэд болон цагаачдыг эрх зүйн байдлаас нь үл хамааран дур зоргоор баривчлах явдлыг зогсоож, нутаг буцааж, бөөнөөр нь албадан гаргах явдлаас хамгаалах шаардлагатай. Мөн дотооддоо дүрвэсэн иргэдийг төрсөн газар нутагтаа сайн дурын үндсэн дээр аюулгүй, нэр төртэйгээр эргэн очих баталгааг хангах чиглэлд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ЖАГСААЛ ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Ойрх Дорнод болон Хойд Африкийн бүс нутгийн эрх баригчид шүүмжлэлт үзэл бодлоо илэрхийлсэн, тайван жагсаалд оролцсон, хүний эрхийн үйл хэрэг болон улс төрийн үйл ажиллагаа явуулсан хэргээр хүмүүсийг дур мэдэн баривчлах, саатуулах, ял шийтгэх, дарамтлах байдл үргэлжилсэн хэвээр байна.

Эрх баригчид терроризмын тухай хууль тогтоомж, эсхүл «үндэсний аюулгүй

байдал»-тай холбоотой хэт ерөнхий зохицуулалтыг ашиглан эсэргүүцэгчдийн дуу хоолойг нухчин дарж, олон жилийн хорих ял оногдуулж байна. Алжирт байгаль орчны идэвхтэн Мохад Гасми тус улсад занарын хийн ашиглалттай холбоотой цахим шуудан солилцсон хэргээр гурван жил хорих ялаар шийтгүүлжээ. Иордан улсад гурван сэтгүүлч компаниуд, улс төрчид болон хааны санхүүгийн үйл ажиллагааг илчилсэн баримт бичгүүдийг дэлгэснийхээ төлөө “хуурамч мэдээ тараасан” хэргээр баривчлагдаж хорих ялаар шийтгүүлжээ. Мароккод хүний эрх хамгаалагч Саида Алами олон нийтийн сүлжээгээр сэтгүүлчид, идэвхтнүүдийг хэлмэгдүүлж байгааг шүүмжлэн нийтлэл бичсэнийхээ төлөө анхны шатны шүүхээс хоёр жилийн хорих ял оноосон бол давж заалдах шатны шүүхээс гурван жил болгон нэмэгдүүлжээ.

Зарим улсын эрх баригчид хэвлэлийн эрх чөлөөнд тавих цензурийг нэмэгдүүлж, үг хэлэх эрх чөлөөний эсрэг заналхийлж байна. Йемены Хути эрх баригчид нийслэлийн зургаан радиог хааж, дор хаяж найман сэтгүүлчийг үргэлжлүүлэн хорьж байгаагийн дөрөв нь цаазаар авах ялаар шийтгүүлжээ. Сирийн засгийн газар эрх баригчид болон үндсэн хуулийг цахим сүлжээгээр шүүмжилсэн бол урт хугацаагаар хорих ял оноох тухай цахим гэмт хэргийн тухай шинэ хуулийг баталжээ. Тунис улсад гарсан шинэ тогтоолоор харилцаа холбооны сүлжээг “хуурамч мэдээ” болон бусад худал, гүтгэлгийн чанартай мэдээлэл бэлтгэх, илгээх, түгээх зорилгоор санаатайгаар ашигласан тохиолдолд 10 жил хүртэл хорих ял оноож, үүнийг зөрчсөн байгууллагуудыг татан буулгах эрхийг эрх баригчдад олгожээ. Арабын Нэгдсэн Эмират улсын (АНЭУ) шинэ хуулиар “төрийн нэр хүнд, нэр төр, байр суурь”, эсхүл “түүний үүсгэн байгуулагч удирдагчдыг” доромжилсон, гутаасан, хохирол учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.

Иран, Ливи, Сири улсын эрх баригчид эсэргүүцлийн жагсаалыг нухчин дарах зорилгоор хүний амь насанд аюултай хүч хэрэглэж, иргэдийг олноор нь баривчилжээ. Ираны эрх баригчид Исламын Бүгд Найрамдах улсын эсрэг урьд өмнө гарч байгаагүй бослогод барилт сум, төмөр үрэл хэрэглэн, бороохойдож зодсон хариу арга хэмжээ авсны улмаас олон зуун хүн, тэр дундаа олон арван хүүхэд амь үрэгдэж, олон мянган хүн шархаджээ. Эрх баригчид интернэт болон гар утасны сүлжээг хааж, тасалдуулсны зэрэгцээ нийгмийн цахим сүлжээний платформуудыг хаажээ. Хэдэн мянган хүнийг дур мэдэн баривчилж, шударга бусаар шүүж, гэмт хэрэг үйлдсэн хэмээн ялласан бөгөөд хоёр хүнийг цаазалжээ. Баруун эрэг болон Газын зурвас дахь Палестины эрх баригчид тайван жагсаал цуглааныг тараахын тулд зарим үед хүч, албадлагыг хэтрүүлэн хэрэглэжээ.

Хууль бус аллага болон хүний эрхийн бусад ноцтой зөрчилд ял шийтгэлгүй үлддэг байдал бүс нутгийн хэмжээнд давамгайлж байсан хэдий ч олон улсын түвшинд зарим эерэг алхмуудыг хийсэн. Тухайлбал, есдүгээр сард дэгдсэн Ираны эсэргүүцлийн жагсаалтай холбоотой хүний эрхийн зөрчлийг судлах зорилгоор НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өнгөрсөн арван нэгдүгээр сард баримт судлах комисс байгуулсан. Түүнчлэн, Европын зарим улс Сири, Иранд олон улсын гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн хүмүүсийг түгээмэл харьяаллын зарчмын дагуу үндэсний шүүхээр дамжуулан мөрдөн шалгаж, ялласан.

Хэд хэдэн улсын эрх баригчид эсэргүүцлийг тулд өөр бусад арга хэмжээг авчээ. Алжирын эрх баригчид сөрөг хүчний улс төрийн нам, хөдөлгөөний гишүүдийн дуу хоолойг нухчин дарахын тулд терроризмын эсрэг ял шийтгэлийг урвуулан ашиглаж байна. Тэд хамгийн багадаа нэг улс төрийн намын үйл ажиллагааг зогсоосон бөгөөд цаашид дор хаяж хоёр намыг татан буулгана хэмээн заналхийлэв. Израйлийн эрх баригчид Палестины долоон иргэний нийгмийн байгууллагыг хаах шийдвэр гаргаж, Палестины улс төрийн намын Израйлийн парламентын сонгуульд оролцох эрхийг нь хасжээ. Арван хоёрдугаар сард хүний эрхийн хуульч Салах Хаммури-г шүүхээс оногдуулсан ямар нэгэн шийтгэлгүйгээр есөн сарын турш захиргааны журмаар хорьж, Зүүн Иерусалимд оршин суух эрхийг нь цуцалсны дараа Франц руу албадан гаргажээ.

Египетийн эрх баригчид дөрөвдүгээр сараас эхлэн оны эцэс хүртэл улс төрийн

шалтгаанаар баривчлагдсан 895 хүнийг сулласан боловч 11 дүгээр сард болсон COP27-ын үеэр эсэргүүцлийн жагсаал зохион байгуулсантай холбогдуулан 2,562 хүнийг сэжигтэй хэмээн үзэж прокурорууд баривчилж, байцаажээ. Мянга мянган хүний эрхийг хамгаалагчид, сэтгүүлчид, жагсагчид болон шүүмжлэгчид хүний эрхээ эдэлснийхээ төлөө дур зоргоор саатуулагдсаар байна.

Засгийн газар үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрхийг хүндэтгэх үүрэгтэй бөгөөд сэтгүүлчид, хүний эрх хамгаалагчид, идэвхтнүүдийг дарамт, хүчирхийлэл, ял шийтгэлээс ангид байх баталгаагаар хангаж, эрхээ эдэлснийхээ төлөө саатуулагдсан хүмүүсийг суллах шаардлагатай.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД

2022 онд Ойрх Дорнод болон Хойд Африк даяар охид, эмэгтэйчүүдийн өв залгамжлах, гэрлэлтээ цуцлуулах, улс төрийн төлөөлөл болон хөдөлмөр эрхлэх боломжийг хуулиар болон бодитоор ялгаварлан гадуурхсан хэвээр байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд зөрчил үйлдэгч этгээдүүд ял шийтгэлгүй үлдэж байна. Египет, Ирак, Иран, Йемен, Саудын Арабын эрх баригчид эмэгтэйчүүдийн эрх хамгаалагч, идэвхтнүүдийг бэлгийн хүчирхийлэл, жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтын эсрэг үг хэлснийх нь төлөө яллах, байцаах болон бусад төрлийн дарамт шахалт үзүүлсээр байна.

Иран улсад олон арван жил үргэлжилсэн жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл болон нүүрээ заавал халхлах талаарх хууль тогтоомжийг эсэргүүцэн есдүгээр сард улс даяар зохион байгуулсан эсэргүүцлийн жагсаалын тэргүүн эгнээнд охид, эмэгтэйчүүд жагсаж байв.

Гэр бүл дэх эмэгтэйчүүд болон бусад эмэгтэйчүүдийн амь насыг хөнөөх явдал үргэлжилсээр байна. Иракийн төв хэсэг болон Курдистан бүсэд энэ төрлийн аллага, жендэрт суурилсан бусад төрлийн хүчирхийлэл тэр дундаа транс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хэрэг нэмэгдсэн хэдий ч засгийн газар гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцохгүй хэвээр байна. Алжирт 37 эмэгтэйг хөнөөсөн хэрэг бүртгэгджээ.

Бүс нутгийн хэд хэдэн улсад ялгаварлан гадуурхалтаас хамгаалах эрх зүйн хамгаалалт улам суларчээ. Гуравдугаар сард Саудын Араб улс анхны «хувийн байдлын тухай хууль»-ийг баталсан. Уг хуулиар эрэгтэйчүүдийн хамгааллын тогтолцооны уг шинжийг хуульчлан, гэр бүлийн амьдралын бүх харилцаанд хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг баталгаажуулсан. Тунис улс сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг сайжруулсан заалтуудыг хасжээ. Йемен дэх Хути де-факто эрх баригчид өрсөдийн хяналтат байгаа нутаг дэвсгэрт эмэгтэйчүүдийг эрэгтэй асран хамгаалагч, эсхүл түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр зорчихыг хориглов.

Хэдийгээр эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхах, хүчирхийлэлд өртсөөр байгаа ч зарим улс улсад ахиц дэвшил гарсан. Марокко улс Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протоколыг соёрхон баталсан боловч дотоодын хууль тогтоомж нь жендэрийн тэгш бус байдлыг хэвээр хадгалсан хэвээр байна. Йордан улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хуулийн өмнө эрх тэгш хэмээн тунхаглаж, тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглосон боловч тус улсын холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах алхам хийгдээгүй байна. Кувейт улсын засгийн газар төрийн алба болон манлайлал дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан боловч дотоодын хууль тогтоомж нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан хэвээр байна. Оманы эрх баригчид гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх утас ажиллуулж байсан ч хамгаалах байр байгуулах болон гэр бүлийн хүчирхийллийг тодорхойлсон хууль батлаагүй байна.

ЛГБТИ ХҮМҮҮС

Бүс нутаг даяар ЛГБТИ хүмүүс баривчлах, яллагдагчаар татах, зарим үед бэлгийн чиг хандлага, жендэрийн баримжаанаас нь хамааран албадан шулуун гэдсээр шинжилгээ хийх зэрэг эрүү шүүлтэд өртөж байна. Зарим эрүүгийн шүүх ижил хүйстнүүдийн зөвшилцсөн харилцаанд холбогдсон хүмүүст хэт хатуу ял шийтгэл оногдуулсан.

Зарим улс хүрсэн амжилтаасаа ухрах шинж ажиглагдлаа. Ливанд шашны бүлгүүдийн “ижил хүйстний харилцааг дэлгэрүүлэхээс татгалзах» шаардлагын дагуу Дотоод хэргийн яам ЛГБТИ хүмүүсийн тайван цуглаан хийхийг хориглосон хэдий ч шүүхээс уг шийдвэрийг түдгэлзүүлсэн байна. АНЭУ-д ижил хүйстнүүдийн зөвшилцлийн харилцааг гэмт хэрэгт тооцдог тул засгийн газраас сургуулийн багш нарт «жендэрийн баримжаа, ижил хүйстэн болон АНЭУ-ын нийгэмд үл хүлээн зөвшөөрөх бусад зан үйлийн талаар» хэлэлцэхгүй байхыг тушаажээ. Йемен улсад бэлгийн болон жендэрийн баримжаатай болох нь нотлогдоогүй хүмүүсийг онилон дур зоргоороо баривчлах, хүчиндэх болон бусад эрүү шүүлт тулгаж байна.

УГСААТНЫ БОЛОН ШАШНЫ ЦӨӨНХ

Бүс нутгийн хэмжээнд үндэсний, угсаатны, шашны болон цөөнхийн бүлгийн гишүүд шашин шүтэх, хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд тэгш хамрагдах, ял шийтгэх болон бусад хүний эрхийн ноцтой зөрчлөөс ангид хамгаалагдсан байх зэрэг эрхийн харилцаанд хууль тогтоомж, практикт үндэслэсэн ялгаварлан гадуурхалттай тулгарсаар байна.

Палестинчуудыг газар нутгаар хэсэгчлэн хуваах, ялгаварлан тусгаарлах, хянах, газар нутаг, эд хөрөнгийг нь хураах, эдийн засаг, нийгмийн эрхийг үгүйсгэх, дарангуйлах, ноёрхох замаар Израйль улс ялгаварлан гадуурхалтын ноцтой хэлбэр болох апартейдийн тогтолцоог хадгалсаар ирсэн. Израйль улс энэхүү тогтолцоог Палестинчуудын эсрэг удаан хугацаанд хадгалахын тулд албадан нүүлгэх, захиргааны журмаар саатуулах, эрүүдэн шүүх, хууль бусаар алах, үндсэн эрх, эрх чөлөөг үгүйсгэх, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болох апартейдын хавчлага зэрэг хүний эрхийн олон төрлийн зөрчил үйлдсэн. Эрх баригчид апартейдын тогтолцоог улам бүр бэхжүүлж, еврей хүн ам зүйн олонхийг хадгалах зорилгоор 3 дугаар сард Палестины гэр бүлүүдийн дахин нэгдэх боломжид хуулиар томоохон хязгаарлалт тогтоосон. Түүнчлэн “төрд үнэнч байх ёсыг зөрчсөн” хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн иргэний харьяаллыг хүчингүй болгох бүрэн эрхийг Дотоод хэргийн сайдад олгосон хуулийн зохицуулалтыг тус улсын дээд шүүхээс зөвтгөсөн.

Иранд Ахвази Араб, Азербайжаны Түрэг, Балучи, Курд, Туркмен зэрэг үндэстний цөөнхүүд системт ялгаварлан гадуурхалтад өртөж, боловсрол, ажил эрхлэлт, шаардлагад нийцсэн орон сууц, улс төрийн албан эрхлэх боломж нь хязгаарлагдаж байна. Кувейтэд Бидун (уугуул боловч харьяалалгүй Кувейтчүүд) иргэдийг хуулиар ялгаварлан гадуурхах явдал нэмэгдсэн.

Шашны цөөнхийн гишүүд шүтэн бишрэх эрхийг нь ноцтой зөрчсөн өргөн хүрээний ялгаварлан гадуурхалтад өртөж байна. Алжир улсын эрх баригчид Энх тайван ба гэрлийн Ахмади шашны гишүүдийг хавчиж, дор хаяж гурван протестант сүмийг хаахын тулд Суннит Исламаас бусад шашныг хязгаарлах шийдвэр гаргажээ. Египетийн эрх баригчид христийн шашинтнууд болон бусад шашны цөөнх, түүнчлэн шашингүй үзэлтнүүд болон төрөөс зөвшөөрөөгүй шашны итгэл үнэмшлийг дэмждэг хүмүүсийг “шашныг гүтгэсэн”, эсхүл бусад хилс хэрэгт шийтгэж, хорьсон хэвээр байна. Иранд бахайчууд, христийн шашинтнууд, гонабади дервишүүд, иудейчүүд, яресан, суннит Исламын шашинтнуудыг боловсрол, ажил эрхлэлт, улс төрийн албан тушаал, мөргөлийн газарт нэвтрэх гэх зэргээр хууль болон практикт ялгаварлан гадуурхаж байна.

Засгийн газар охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эсрэг жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг таслан зогсооход чиглэсэн

үйл ажиллагааг шуурхай явуулж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх шаардлагатай. Түүнчлэн зөвшилцөлд үндэслэсэн ижил хүйстнүүдийн харилцааг гэмт хэрэгт тооцохгүй байх шаардлагатай. Үндэс угсаа, гарал үүсэл, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах явдлыг эцэс болгож, хүн бүрт ялгаварлан гадуурхалтгүйгээр эрх тэгш эрх эдлэх баталгааг хангах, итгэл үнэмшил, шашин шүтэх эрх чөлөөг хамгаалах, дэмжих хууль зүйн болон бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх шаардлагатай.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ЭРХ

Зарим улсын эдийн засгийн хямрал нь амьжиргааны өртөг, хоол хүнс, түлшний аюулгүй байдал, ус, орон байр, эрүүл мэнд, амьжиргааны зохистой түвшинд хүрэхэд ихээхэн сөргөөр нөлөөлсөн. Ялангуяа гадуурхагдсан бүлгийн хүмүүс, тэр дундаа эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүс, үндэстэн, шашны цөөнх, дүрвэгсэд, цагаачид, бага цалинтай ажилчид ихээр өртсөн.

Дэлхийн банкнаас орчин үеийн түүхэн дэх хамгийн гүнзгий хямралын нэг хэмээн үзсэн Ливан улс дахь улсын эдийн засгийн ноцтой хямралыг тус улсын эрх баригчид даван туулж чадаагүй бөгөөд үүний үр дүнд эдийн засаг, нийгмийн эрхийн баталгаа эрс мууджээ. Ливаны нийт өрхийн бараг тал гаруй хувь нь хүнсний аюулгүй байдлын дутагдалтай байсан бөгөөд улсаас өдөрт хоёр цаг хүрэхгүй цахилгаан эрчим хүчээр хангадаг, эмийн үнэ маш өндөр худалдан авах боломжгүй эсвэл хүртээмжгүй, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд туйлын хангалтгүй хэвээр байв. Египет улс олон сая хүний эдийн засаг, нийгмийн эрхийг алдагдуулсан санхүү, эдийн засгийн хямралд орсон. Мөн Тунисын эдийн засгийн хямрал улам даамжирч, ажилгүйдэл 15%-д хүрч, үндсэн нэр төрлийн хүнсний хомсдолд оров. Сири улсын хүн амын 55 хувь нь хүнсний аюулгүй байдлын асуудалд өртөв. Валютын ханшийн уналт, өндөр инфляц, дэлхийн хүнсний үнийн огцом өсөлтөөс үүдэн Йемэн улсын иргэдийн хүнсний хүртээмж ихээхэн хязгаарлагдлаа. Бүс нутгийн хэмжээнд засгийн газрууд бага цалинтай ажилчдыг хөдөлмөрийн хүчирхийлэл болон бие даасан үйлдвэрчний эвлэлд нэгдэх, ноцтой үр дагавраас айж эмээхгүйгээр ажил хаях эрхийг хамгаалж чадсангүй. Египет, Иран, Йорданд жагсаал, ажил хаялт зохион байгуулсан, бие даасан үйлдвэрчний эвлэл байгуулахыг эрмэлзсэн ажилчдыг ажлаас үндэслэлгүй халах, баривчлах, эрүүгийн ял ногдуулах зэргээр шийтгэж байна. Персийн булангийн орнуудын ажиллах хүчний дийлэнх хувийг бүрдүүлдэг бага цалинтай цагаач ажилчид хөдөлмөрийн хэт мөлжлөг, хөдөлмөр эрхлэлтийн ялгаварлан гадуурхалт, шаардлагад нийцээгүй орон байр, бие махбодын болон сэтгэцийн олон төрлийн хүчирхийлэл, хэт бага цалин хөлс, эсхүл цалингаа авч чадахгүй байх, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал зэрэг эрсдэлд өртсөн хэвээр байгаа бөгөөд эцэст нь ажлаас халагдан эх орондоо буцаж ирдэг. Катар улсын засгийн газар цагаач ажилчдад зориулсан кафала (ивээн тэтгэх) тогтолцоог шинэчлэх ажлыг үргэлжлүүлсэн хэвээр байгаа боловч энэ нь цалингийн дээрэм зэрэг өргөн тархсан хөдөлмөрийн хүчирхийллийг зогсоож чадсангүй. Эрх баригчид цагаач ажилчдын гэнэтийн үхэл, тэр дундаа хэт халуунд, завсарлага, амралтын өдөргүй удаан хугацаагаар ажилласны улмаас амь насаа алдсан хэргийг мөрдөн шалгаж чадаагүй хэвээр байна. Олон тооны цагаач ажилчид арьсны өнгө, үндэс угсаа, хэлээр нь ялгаварлан гадуурхалд өртсөн бөгөөд тэдний цалингийн хэмжээ бага, хөдөлмөрийн нөхцөл хангалтгүй, гүйцэтгэх ажил улам хүнд болж байна. Түүнчлэн гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа эмэгтэйчүүд хөдөлмөрийн хүнд нөхцөл, бие махбодын болон сэтгэл санааны ноцтой хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэлд өртсөөр байна. Мөн засгийн газар цагаач ажилчдад үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэхийг хориглосон хэвээр байгаа бөгөөд дээрх эрхийг зөвхөн Катарчууд эдэлж байна

Засгийн газрууд хямралын сөрөг үр дагавраас хүн бүрийг, тэр дундаа гадуурхагдсан бүлгийг үр дүнтэй хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлж, эрүүл мэнд, хоол хүнс, амьжиргааны

зохих түвшний эрхийг баталгаажуулах талаарх олон улсын хамтын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Түүнчлэн засгийн газрууд ажилчдын бие даасан үйлдвэрчний эвлэл байгуулах, жагсаал цуглаан хийх эрхийг хамгаалж, гэрийн үйлчлэгч гэх зэрэг цагаач ажилчдын хөдөлмөрийн хамгаалалтыг хуулиар өргөжүүлэх шаардлагатай.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭЖ ЧАДСАНГҮЙ

Бүс нутгийн улс орнууд, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон улсын гэрээ болох 2015 оны Парисын хэлэлцээрт оролцогч улс орнууд уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтолтой тэмцэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж чадсангүй. 2022 он бол уур амьсгалын хямрал хүний эрхэд сөргөөр нөлөөлж буй талаарх өргөн хүрээний нотолгоог бидэнд харууллаа. Алжирт ой хээрийн түймрийн улмаас их хэмжээний ой модыг сүйдэж, 40 гаруй хүн амь насаа алджээ. Иранд нуур, гол мөрөн, намгархаг газар ширгэж ой мод устан үгүй болж агаар, усны бохирдол ихсэж, газрын хөрсний суулт үргэлжилсээр байна. Иракт хүчтэй ган гачиг, халууны давлагаа, элсэн шуурганы улмаас 10,000 гаруй гэр бүлийг нүүлгэн шилжүүлжээ.

Бүс нутгийн газрын тос, байгалийн хий олборлогч томоохон үндэстнүүд чулуужсан түлшийг үе шаттайгаар зогсоох, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд шаардлагатай арга хэмжээг эх орондоо авч хэрэгжүүлэх талаарх COP27-ийн эцсийн хэлэлцээрийг дэмжих үүргээ биелүүлсэнгүй. Дэлхийн хамгийн том газрын тос үйлдвэрлэгчдийн нэг болох Саудын Араб улс хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах талаарх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрээ шинэчилсэнгүй. Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн хий ялгаруулалтаар дэлхийн хоёр, гурав, дөрөв дүгээрт бичигддэг Кувейт, Бахрейн, АНЭУ, Катар зэрэг улсууд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрээ мөн шинэчилсэнгүй. АНЭУ Парисын гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчин жилийн хугацаанд газрын тосны олборлолтоо нэмэгдүүлжээ. Бусад мужууд дэлхийн агаарын температурын өсөлтийг 1.5 хэмээс доош байлгахын тулд 2030 он хүртэл ялгаруулалтын зорилтоо шинэчлэх, эсхүл дахин нягтлах үүргээ биелүүлээгүйн зэрэгцээ олон улсын санхүүгийн дэмжлэгтэй холбоотой хангалттай амлалт өгч чадсангүй. COP27-ийн хэлэлцээрүүд нь Египетийн хүний эрхийн хямрал, тэр дундаа бага хурлын үеэр зохион байгуулсан эсэргүүцлийн жагсаал хийх уриалгатай холбогдуулан олныг хамарсан баривчилгааны давлагаанд дарагджээ. Энэхүү арга хэмжээ нь эсэргүүцлийн жагсаал оролцогчид байцаалт, хяналт болон бусад хэлбэрийн дарамтад өртсөн хэлмэгдүүлэлтийн орчинд болж өнгөрлөө.

Засгийн газрууд нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг хязгаарлахын тулд шуурхай арга хэмжээ авч, чулуужсан түлшний төслийн санхүүжилтийг зогсоох шаардлагатай. Түүнчлэн үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрээ дахин эргэн харж, шинэчлэхийн зэрэгцээ Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай.

ЭРҮҮ ШҮҮЛТ, БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Египет, Ливи, Израйль/Палестины эзлэгдсэн нутаг дэвсгэр, Палестин, Иран, Ирак, Саудын Араб, Йемен, Ливан, Сири зэрэг улсын албан болон бус цагдан хорих газруудад эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцах байдал үргэлжилсэн хэвээр байна. Баривчлагдсан хүмүүст «хэрэг хүлээлгэж», шийтгэхийн тулд хүч хэрэглэсээр байна. Эрүүдэн шүүхийн тулд зодох, цахилгаанд цохиулах, цаазлуулж байгаа мэт орчин, нөхцөлийг бий болгох, бэлгийн хүчирхийлэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, ганцаарчлан удаан хугацаагаар хорих зэрэг аргыг ашиглаж байна. Эрх баригчид эрүүдэн шүүлт болон хорих газарт амь насаа алдсан бараг бүх хэргийг зохистой байдлаар мөрдөн шалгаж чадсангүй.

Ливийн зэвсэгт хүчин болон зэвсэгт бүлэглэлүүд баривчлагдсан хүмүүсийг цахилгаанд цохиулах, ташуурдах, бэлгийн хүчирхийлэл болон бусад аргуудыг ашиглан системтэйгээр тамлан зовоож, зарим тохиолдолд үхэлд хүргэж байна. Саудын Арабд эрх баригчид цагаач ажилчдыг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах, тэдэнд зохих эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байсны улмаас хэд хэдэн хүн урьдчилан хорих газарт нас баржээ. Египетэд хорих газар, цагдаагийн газар, Үндэсний аюулгүй байдлын агентлагийн харьяа байгууллагуудад эрүү шүүлт өргөн тархсан хэвээр байна. Израйлийн аюулгүй байдлын хүчнийхэн цагдан хоригдож байгаа Палестин иргэдийг эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан хэвээр байгаа бөгөөд Баруун эрэг болон Газын зурвас дахь Палестины эрх баригчдын удирддаг цагдан хорих, байцаах төвүүдэд ийм хүчирхийлэл үргэлжилсээр байна. Сирийн дүрвэгсдийг эрүүдэн шүүсэн хэрэгт Ливаны аюулгүй байдлын албаны таван гишүүнийг буруутгаж байгаа хэдий ч уг хэргийг шударга бус цэргийн шүүхээр хянан шийдвэрлэжээ.

Иран, Ливи, Саудын Араб улсад биеийг нь тайрах, ташуурдах, нүдийг нь сохлох, чулуугаар шидэх, загалмайд цовдлох зэрэг бие махбодын шийтгэл ногдуулах хууль хүчин төгөлдөр байсаар байна. Иранд 5-9 дүгээр сарын хооронд эрх баригчид хулгайн хэргээр шийтгүүлсэн таван хүний хурууг тайрчээ.

Бүс нутгийн хэмжээнд хоригдлууд хэт олноор, агааржуулалт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд, хангалттай хоол хүнсээр хангагдаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг тухайд нь авах, гэр бүлтэйгээ уулзах, цэвэр агаар амьсгалах, гадаа дасгал хийх боломжгүй хүнлэг бус нөхцөлд хоригдож байна. Бахрейн улсад Ахмед Жабер Ахмед 11 сарын турш эмнэлгийн тусламж авч чадаагүй бөгөөд алхах, өөрийгөө хувцаслах ч тэнхэлгүй болжээ. Эцэст нь түүний сүрьеэ өвчин хүндэрснийг эмнэлгийн үзлэгээр оношилжээ. АНЭУ-д хүний эрхийн хамгаалагч Ахмед Мансурыг 2022 оны турш гудас, дэр, хувийн ариун цэврийн хэрэглэл, ном, нүдний шилгүйгээр ганцаарчлан хорьжээ.

Засгийн газрууд эрүүдэн шүүх, шүүхээс гадуур цаазаар авах, хүчээр алга болгох болон олон улсын эрх зүйн бусад гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчлийг хараат бусаар, шударгаар, үр дүнтэй мөрдөн шалгах баталгааг хангаж, эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хохирогчдод нөхөн төлбөр олгох шаардлагатай.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Бүс нутгийн ихэнх улс орнууд цаазаар авах ялыг хадгалсан хэвээр байна. Гэвч бусдыг болгоомжгүй алах гэмт хэрэг, олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан үйлдэл болох ижил хүйстнүүдийн зөвшилцөлд тулгуурласан харилцаа, шашнаас гарах, шүүмжлэлт үзэлтнүүдэд хуурамч хэрэг тулгах зэргээр шударга бус шүүх хуралдаанаар цаазын ял оногдуулж байна.

Египет, Саудын Араб, Иран, Ирак, Палестин улс, ялангуяа Газын зурваст ХАМАС-ын эрх баригчид сүүлийн таван жилд анх удаа цаазаар авах ялыг гүйцэтгэжээ. Египет, Иран, Ирак, Ливи, Саудын Араб зэрэг улсад онц байдлын, цэргийн болон тусгай шүүх зэрэг шударга бус шүүх хуралдаанаар цаазын ялыг оногдуулжээ. Цаазаар авах ялыг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хэрэгсэл болгон өргөн хэрэглэж байсан Иран улсад 2022 онд цаазаар авах ялаар шийтгэх явдал нэмэгдсэний зэрэгцээ цаазлах ажиллагааг нийтээр гүйцэтгэх явдал дахин сэргэлээ. Иран улс бол хүүхэд байхдаа гэмт хэрэгт үйлдсэн хүмүүст цаазын ял оноодог бүс нутгийн цорын ганц улс юм. Саудын Арабд 3 дугаар сарын 12-ны өдөр 81 эрэгтэйг цаазалсан нь сүүлийн хэдэн арван жилд тохиож байгаагүй олон хүнийг нэг дор цаазалсан тохиолдол боллоо. Саудын Араб хоёр жилийн албан бус хоригийн дараа хар тамхитай холбоотой хэрэгт цаазын ялыг дахин хэрэглэжээ. Египет, Ирак зэрэг улсад 2022 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад цөөн тооны цаазын ял гүйцэтгэсэн байна.

Засгийн газрууд цаазаар авах ялыг халахын тулд цаазаар авах ялыг гүйцэтгэх ажиллагааг албан ёсоор нэн даруй түдгэлзүүлэх шаардлагатай.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН

ТАЙЛАН 2022/23

2022 онд шинээр үүссэн мөргөлдөөн ужгирч, дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэгдэж, хүн төрөлхтөн эмгэнэлт байдалд хүрлээ. Дэлхий даяар үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хатуу гараар нухчин дарлаа. Мөргөлдөөн, хямралаас дайжсан хүмүүсийг хамгаалах, түүнчлэн олон улсын эрх зүйг зөрчсөн хэрэгт үзүүлэх олон улсын хариу арга хэмжээ ихээхэн зөрүүтэй, ялгамжтай байв. Зарим нь буруушааж, зарим нь дэмжиж, бусад олонх нь үл ойшоов.

Эдийн засгийн хямрал нь хүнс, түлшний үнийг огцом өсгөж, эрүүл мэнд, бусад нийгмийн үйлчилгээнд дарамт учрууллаа. Энэ сорилт нь нийгмийн эмзэг бүлгийнхэнд илүүтэй нөлөөлж, тэгш бус байдлыг гааруулж байна. Охид, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүс жөндөрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай нүүр туллаа.

Эдгээр нь Эмнести Интернэшнлээс 2022 онд дэлхийн 156 оронд хийсэн судалгаагаар хамгийн чухлаар хөндөгдсөн асуудлууд бөгөөд өөр хоорондоо нягт холбоотой юм. Эмнести Интернэшнлийн Тайлан 2022/23-т засгийн газрууд, бусад талууд эдгээр сорилтыг даван туулах илүү зоримог арга хэмжээ авах шаардлагатайг онцолж, дэлхий даяарх хүмүүсийн амьдралыг сайжруулахын тулд ямар алхам хийж болохыг дурдлаа. Хууль тогтоогчид, бодлого боловсруулагч, өмгөөлөгч, идэвхтнүүд гээд хүний эрхийг сонирхдог хүн бүхэнд зайлшгүй унших ёстой зүйлийн нэг нь энэ тайлан билээ.

www.amnesty.org
www.amnesty.mn



ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

